



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН

⋮⋮⋮ **ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ
СУРГАЛТЫН АЖЛЫН
ҮЛГЭРЧИЛСЭН
ХӨТӨЛБӨР,
ХЭРЭГЖҮҮЛЭХ
ЗӨВЛӨМЖ**

/САЙЖРУУЛСАН ХУВИЛБАР/



АЖЛЫН ХЭСЭГ:

**Б.АЛТАНСҮХ
Ц.ЛХАГВАСҮРЭН
С.ОТГОНТУЯА
Х.ЭНХЖАРГАЛ**

**БСҮХ-ИЙН ЭША
БСҮХ-ИЙН ЭША
БСҮХ-ИЙН ЭША
БСҮХ-ИЙН ЭША**

РЕДАКТОР:

**А.БҮРЭНЖАРГАЛ
Б.БАЛЖИННЯМ**

**ГҮҮД НЭЙБОРС ОУБ-ЫН МОНГОЛ ДАХЬ
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БОЛОВСРОЛ СУДЛААЧ**

АГУУЛГА

<u>НЭГ. ҮНДЭСЛЭЛ</u>	2
<u>ХОЁР. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ</u>	2
<u>ГУРАВ. ЗОРИЛГО</u>	4
<u>ДӨРӨВ. ЗОРИЛТ</u>	4
<u>ТАВ. ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</u>	4
<u>ЗУРГАА. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ</u>	
<u>МЕНЕЖЕМЕНТ</u>	5
<u>6.1. Хичээлээс гадуурх сургалтаар хөгжүүлэх чадвар:</u>	6
<u>6.2. ХГСА-ыг зохион байгуулах хэлбэр</u>	7
<u>6.3. Орчин, хэрэглэгдэхүүн</u>	8
<u>ДОЛОО. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН АЖЛЫГ ҮНЭЛЭХ</u>	9
<u>Эх сурвалж:</u>	10
<u>Хавсралт 1. Нэмэлт хөтөлбөрийн жагсаалт</u>	10
<u>Хавсралт 2. Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн төлөвлөгөө</u>	11
<u>ХГСА-ын үлгэрчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж</u>	12

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Бага, дунд боловсролын тухай хуулийн 18 дугаар зүйл¹ дэх “Хичээлээс гадуурх сургалтын ажил нь суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авъяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ”, Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн шаардлагад “Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрт байгаль орчин, эдийн засаг, нийгэм, соёлын уялдаа холбоог хангасан цогц байдлаар агуулгын болон арга зүйн шийдлийг хийх, суралцагчдад хандлага, үнэт зүйлс, хэрэглээний чадварыг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай”, Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмийн “Сургалтын ажил нь хичээл, хичээлээс гадуурх сургалт, хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангах тэдгээртэй холбоотой бусад ажлаас бүрдэнэ”, “Сургууль хичээлээс гадуурх сургалт, хүмүүжлийн ажлын төлөвлөгөөтэй ажиллана” гэж тус тус заасан. Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.13. “... хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг хичээллүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг нэвтрүүлж, хүүхдийн авъяас чадварыг нээн хөгжүүлнэ” зорилт, БСШУ-ны сайдын 2016 оны А/186 оны “ЕБС, насан туршийн боловсролын төвд дугуйлан, секц, клуб ажиллуулах зөвлөмж”, МУ-ын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, БСШУС-ын сайдын 2019 оны А/528 дугаар тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагаанд баримтлах чиглэл батлагдсан.

2018 онд Дэлхийн банк, БХАН-ээс “Хичээлээс гадуурх үйл ажиллагааны нөхцөл байдал”-ыг илрүүлэх зорилгоор хийсэн шинжилгээний зарим үр дүнд болон “ЕБС-ийн дунд ангийн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээ”-ний тайлан, Боловсролын хүрээлэнгийн хийсэн “ЕБС-ийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны хэрэгжилтийн нөхцөл байдал”-ын судалгааг үндэслэл болгосон.

“ЕБС-ийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны хэрэгжилтийн нөхцөл байдал”-ын судалгаагаар ЕБС-ийн ХГҮА-ны төлөвлөлтийг авч үзэхэд сургуулийн хэмжээнд төлөвлөгдсөн ажлын 47.0 хувь нь хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хамгаалах, 17.6 хувь нь эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхдийн хөгжлийг дэмжих, 35.2 хувь нь сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэх, зөвлөн туслахад чиглэсэн байна.

Судалгаанд хамрагдсан сурагчдын 76.0 хувь нь урлагийн үзлэг, 58.1 хувь нь секц дугуйлан, олимпиад, 64.0 хувь нь спортын уралдаан тэмцээнд оролцдог гэж хариулсан байна.

Сургуулиас зохион байгуулж байгаа ажил тэдний сонирхолд нийцсэн үйл ажиллагааг зохион байгуулдаг гэж 81.1 хувь нь хариулсан байгаа нь энэ чиглэлийн үйл ажиллагаа сурагчдад хэрэгцээтэй байгааг илэрхийлж байна.

ХГҮА-г зохион байгуулдаг багш нарын хувьд улсын хэмжээнд нэгдсэн нэг загвартай болох ба зөвлөмж, гарын авлагатай байх саналуудыг илэрхийлсэн байна.

Иймд энэхүү үлгэрчилсэн хөтөлбөр нь хүүхдийн оролцоонд тулгуурлан сурагчдын танин мэдэхүй, бие бялдар, нийгэмшлийн хөгжлийг дэмжих, ХГҮА-г сургуулийн жилийн болон ангийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэхэд багш нарт чиглэл болно.

ХОЁР. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Хичээлээс гадуурх үйл ажиллагаа (extracurricular activities)-г сургалтын нэг чухал талбар хэмээн тодорхойлсон байдаг. Хичээлээс гадуурх үйл ажиллагаа (ХГҮА) дэх суралцагчийн оролцооны талаарх хийгдсэн судалгааны үр дүн багагүй байна. Тухайлбал, Boone, Kurtz, Fleenor (1988) нарын судалгаанд, ХГҮА-д оролцоо илүү байсан суралцагчийн ирээдүйн мэргэжлийн ахиц дэвшил (карьер), амжилт дагаад илүү байгааг дурдсан бол Рубин, Боммер, Болдуин нар (2002) судалгаандаа ХГҮА-ны оролцоо илүү байсан суралцагчийн манлайлал, харилцааны ур чадвар илүү байна гэдгийг онцолж дурджээ.

1 <http://www.legalinfo.mn/>

Бага, дунд боловсролын тухай хууль, 18 зүйл. Хичээлээс гадуурх сургалтын ажил

18.1. Хичээлээс гадуурх сургалтын ажил нь суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авъяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ.

18.2. Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтооно.

18.3. Сургуулийн захиргаа нь хичээлээс гадуурх сургалтын ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг хэлбэрээр үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдтэй хамтран зохион байгуулна.

18.4. Сургууль хүндэтгэлийн танхим, булантай байж болно.

ХГҮА (extracurricular activities) гэдгийг эх сурвалжуудад ихэнхдээ жишээ хэлбэрээр тайлбарласан байдаг байна. Тухайлбал, Барнетт (2007) сурагчдын спорт, хичээлээс гадуурх төрөл бүрийн үйл ажиллагааны оролцоо, дэмжлэг гэж; Кесер нар (2011) мэргэжлийн болон оюутан суралцагчдын сонирхлын бүлэг, клуб, төсөл зэргийг дурдсан бол, Бирзеа нар (2004) ХГҮА-г албан бус сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг гэж тодорхойлсон байна.

2012 онд АНУ-ын Юта мужийн их сургуулийн судлаач Кеннет Р. Барткус нар ХГҮА-ны тухай ойлголтыг тодруулах зорилгоор судалгаа хийсэн байна. Ойлголтыг тодруулах үүднээс уг судалгаанд авч үзсэн зарим эх сурвалж, тодорхойлолтуудыг харъя. Үүнд:

1. ХГҮА (extracurricular activities) гэдгийг сургууль, коллеж, их дээд сургуулиудын хичээл, сургалтын хөтөлбөрөөс гадуур зохион байгуулах үйл ажиллагааг хэлнэ, гээд үүнд хичээлээс гадуурх нэмэлт академик үйл ажиллагаа, соёлын үйл ажиллагаа зэргийг багтааж үзжээ. Мөн ХГҮА нь сайн дурын шинжтэй нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаа бөгөөд ижил насны суралцагчдын оролцоог хангасан байна гэжээ. ХГҮА-г сургууль, багш нарын удирдлага, чиглүүлэгтэйгээр, мөн сурагчид бие даан санаачилж зохион байгуулж болно. ХГҮА-г суралцагчид бие даан, санаачлан зохион байгуулах нь илүү түгээмэл байдаг.
2. IpExtracurricular activities (ХГҮА) нь сургалтыг дэмжсэн үйл ажиллагаа
3. Extracurricular activities (ХГҮА) сурагчдын өөрийн удирдлагын байгууллага, клубын гишүүнчлэл, удирдлага, сайн дурын оролцоо гэсэн утгыг агуулна. Сурагчдын өөрийн удирдлагын байгууллага, клубын үйл ажиллагааг хэлнэ.
4. Extracurricular activitie (ХГҮА)-г сургуулийн хүрээнд сонголттойгоор зохион байгуулах нэмэлт хөтөлбөр, үйл ажиллагааг хэлнэ. Үүнд, нэмэлт сургалт, спорт, урлаг соёлын үйл ажиллагааны тусгай хөтөлбөр, аялал, оролцооны байгууллага, клубээр олгох боловсролыг авч үзнэ.
5. Extracurricular activitie (ХГҮА) нь академик мэдлэгийг бататгах, өргөжүүлэх сургуулийн хүрээнд хичээлээс гадуурх үйл ажиллагааг ойлгоно.
6. ХГҮА гэдэг нь сургуулийн хүрээнд хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөрт тусгагдаагүй академик болон хичээлийн бус бусад үйл ажиллагааг хэлнэ.

Уг судалгааны эцэст, ХГҮА-ны тухай нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт одоогоор байхгүй байна гээд, судлаачийн зүгээс үүнийг “хичээлээс гадуурх хамтарсан сургалт, үйл ажиллагаа” хэмээн ойлгож болохоор байна гэжээ. Санал болгож буй энэхүү (хичээлээс гадуурх хамтарсан сургалт, үйл ажиллагаа) тодорхойлолт нь ХГҮА-ны талаарх хэт өргөн хүрээний ойлголтыг багасгахад сургууль багш нарт дөхөм болох талтай.

ХГҮА нь тасралтгүй шинжтэй, шууд ба шууд бус байдлаар сурагчдын хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа байх ба албан ёсны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжихэд чиглэсэн, тодорхой хөтөлбөр, төлөвлөгөөтэй байж болно. ХГҮА-ны агуулгын хүрээ нь тэнцвэртэй, үр дүнтэй байх шаардлагатай. Эх сурвалжуудаас авч үзэхэд ХГҮА-ны агуулгын хүрээг дараах байдлаар тодорхойлж болохоор байна. Үүнд,

- Суралцсан зүйлийг бататгах (мэдлэгээ бататгах, хэрэглэх, өргөжүүлэх боломжийг олгох)
- Зайлшгүй шаардлагатай болон сонгон суралцах нэмэлт хөтөлбөр (курсын ажил)
- Мэдлэгийг нэгтгэх/интеграцилах (нэгдмэл шинж чанартай, олон талын мэдлэг, туршлагыг нэгтгэх чиглэсэн үйл ажиллагаа)
- Сурагчдын оролцох боломж олгох, нээлттэй байх, оролцооны байгууллага, зөвлөл, клуб, сайн дурын бүлэг, зохион байгуулалттай үйл ажиллагаа гэсэн агуулгын хүрээтэй байна.

Манай улсын боловсролын салбарт ХГҮА хэмээх ойлголтыг албан ба албан бус байдлаар өргөн хэрэглэж ирсэн ба бага, дунд боловсролын тухай хуульд ХГҮА гэдэгтэй адилтгах ойлголтыг “Хичээлээс гадуурх сургалтын ажил” гэж тодорхойлж, “Хичээлээс гадуурх сургалтын ажил нь суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авъяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ” гэсэн байна.

Мөн хичээлээс гадуурх сургалтын ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг хэлбэрээр зохион байгуулахыг дурджээ. Боловсролын бүх түвшний сургалтын байгууллагуудад ХГҮА-ны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж ирсэн байна.

ГУРАВ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Сурагч өөртөө итгэлтэй, бие бялдар, оюун сэтгэхүй, ёс суртахууны төлөвшилтэй, нийгмийн олон талт харилцаанд зохицон, бусдыг манлайлж, хамт олны хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах, шийдвэр гаргах чадвартай, бүтээлч, санаачилгатай хувь хүн болон хөгжихөд дэмжлэг үзүүлнэ.

ДӨРӨВ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна.

- Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшлийг дэмжих
- Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах
- Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх
- Бие бялдар, авьяас чадварыг хөгжүүлэх
- Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих
- Суралцагчийн хөгжил болон нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих
- Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих
- Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх

ТАВ. ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт 1. Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшлийг дэмжих

- Хүмүүжлийн үйл ажиллагаанд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх
- Хүүхэд хүмүүжүүлэх гэр бүлийн уламжлалт соёл, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурласан хүмүүжлийн ажилд дэмжлэг үзүүлэх

Зорилт 2. Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах

- Амьдралын аюулгүй байдлыг эрхэмлэдэг, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх соёлыг төлөвшүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Хүүхдийг идэвхтэй, эрүүл амьдралын хэв маягт сургах, эрүүл хоол хүнс хэрэглэхийн ач холбогдлыг таниулахад чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй амьдрах ухааны боловсрол олгох хөтөлбөрүүдийг хөгжүүлэх

Зорилт 3. Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх

- Хүүхдийг шударга ёс, шударга байдал, нинжин сэтгэлийг эрхэмлэдэг, эцэг эх, багш, ахмад үе, үе тэнгийнхэн болон бусад хүмүүсийг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Хүүхдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг эрчимжүүлэх
- Өсвөр насныхны дундах дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх орчин нөхцөл бүрдүүлэх, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах
- Замын хөдөлгөөний дүрмийг сурталчилан таниулах, соёлтой оролцох дадал төлөвшүүлэх

Зорилт 4. Бие бялдар, авьяас чадвараа хөгжүүлэх

- Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан-танин мэдэхүй, зохион бүтээх чиглэлийн үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэх
- Олон нийтийг хамарсан спортын арга хэмжээнд оролцох, эерэг жишээг сурталчилах, дэлгэрүүлэх
- Уламжлалт өв соёл, түүн дотроо соёлын биет болон биет бус өвийг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчилах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх
- Орчин үеийн цаашилбал дэлхийн урлаг, уран сайхны бүтээлийг сурталчилах зорилготой хүүхдийн урлаг, соёлын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх, дэмжин хөгжүүлэх

Зорилт 5. Мэдээллийн технологийн ёс зүйтэй хэрэглээг дэмжих

- Уламжлалт соёл, ёс зүй, гэр бүлийн үнэт зүйлийг мэдээллийн орчинд сурталчлахад дэмжлэг үзүүлэх
- Интернетийн орчинд хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилтөд сөргөөр нөлөөлж болохуйц мэдээллээс хамгаалах төрөл бүрийн арга, орчин нөхцөл бүрдүүлэх
- Цахим хэрэглээний эерэг жишээг сурталчлах

Зорилт 6. Суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих

- Хүүхдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэх, тэдний эрх, ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргахад чиглэсэн ажлыг эрчимжүүлэх
- Сурагчдыг нийгэмд тустай үйл ажиллагаанд бүтээлчээр оролцоход дэмжлэг үзүүлэх
- Боловсролын байгууллагуудтай хүмүүжлийн асуудлаар хамтран ажилладаг эцэг эхийн болон
- Олон нийтийн бусад байгууллагын ажиллагааг хөхүүлэн дэмжих

Зорилт 7. Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих

- Хүүхдэд эх оронч хүмүүжил олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Суралцагчдад суралцах чиглэл, мэргэжлээ тодорхойлж, ухамсартай сонгоход дэмжлэг үзүүлэх
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх

Зорилт 8. Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх

- Хүүхдэд байгаль дэлхий, эх орон газар нутгаа хайрлах хандлага төлөвшүүлэх ажлыг дэмжих, хэрэгжүүлэх
- ТХБ-ын үзэл санааг суралцагчдад таниулах, сурталчилах

ЗУРГАА. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ МЕНЕЖЕМЕНТ

ЕБС-ийн хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааны бүх хэлбэр, чиглэл нь боловсролын үр дүн дээр төвлөрсөн байна. Боловсролын үр дүн нь тухайн үйл ажиллагаанд хүүхэд оролцох замаар ёс суртахуунтай хөгжих явдал юм.

Хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Сэдэв, чиглэл, агуулга, хэлбэрийг сонгох, төлөвлөх, зохион байгуулахдаа суралцагчдын оролцоонд тулгуурлах
- Ажлын үр дүнг үнэлэхдээ тооноос илүү чанарыг, тухайлбал суралцагчдын авьяас, үр чадварт гарсан өөрчлөлтөд тулгуурлах
- Тайлагнах, үнэлэх арга хэлбэр нь нийтэд ил тод байхаас гадна суралцагчид өөрсдөө оролцож, ахиц дэвшлээ мэдэрч, урам авахаар байх
- Суралцагчид бие дааж ажиллах, чадварын төлөвшил, нийгэмшилд эерэг нөлөө үзүүлэх, ажил мэргэжлийн баримжаа, арга туршлага хуримтлуулахад анхаарах

Хичээлээс гадуурх сургалтын ажил нь боловсролын үйлчилгээний хавсарга, туслах хэлбэр биш, харин ч тэрхүү үйлчилгээг өөрчлөх, шинэчлэх, хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж өгдөг байна.

Иймээс сургууль, суралцагчдын зорилгыг бодит үр дүн болгоход хичээлээс гадуурх үйл ажиллагааг судлагдахуун болоод бусад үйл ажиллагаа, олон нийтийн байгууллага, хөтөлбөрүүдтэй нягт уялдаатай холбож үзэн хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал,

Хичээлээс гадуурх үйл ажиллагаа нь боловсролын үр дүнд хүрэхэд чиглэгддэг. Тухайлбал,

- суралцагчдын нийгмийн туршлагыг олж авах
- нийгмийн суурь үнэт зүйлсэд эерэг хандлагыг төлөвшүүлэх
- сурагчид нийгмийн бие даасан үйл ажиллагааны туршлагыг олж авах

Үүнээс гадна сургуульд хичээлээс гадуурх үйл ажиллагаа удирдах багш нарт хэд хэдэн маш чухал ажлыг шийдвэрлэх боломжийг олгодог байх хэрэгтэй. Тухайлбал,

- сургуульд хүүхдийн таатай дасан зохицох нөхцлийг бүрдүүлэх
- сурагчдын ачааллыг оновчтой болгох
- хүүхдийн хөгжлийн нөхцөлийг сайжруулах
- хүүхдийн нас, хувь хүний онцлогийг харгалзан үзэх

Хичээлээс гадуурх үйл ажиллагааг дараах хөтөлбөрүүдийн хүрээнд явуулах хэрэгтэй. Үүнд:

- боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр
- ерөнхий боловсролын сургалтын байгууллагын нэмэлт хөтөлбөр
- хүүхдийн байгууллагуудын боловсролын хөтөлбөрүүд

6.1. Хичээлээс гадуурх сургалтаар хөгжүүлэх чадвар:

Хичээлээс гадуурх сургалтын ажил нь өнөөдрийн сурагчид ба ирээдүйн иргэдийн эзэмшвэл зохих 1) шүүмжлэлт болон шинэлэг сэтгэлгээ, 2) хүмүүс хоорондын харилцаа, 3) хувь хүний чадвар, 4) дэлхийн иргэн, 5) мэдээллийн технологийн хэрэглээ гэсэн 5 хүрээ түүнд харгалзах чадваруудын хөгжлийг дэмжихэд чиглэнэ. (Уг чадамж, харгалзах чадварыг ЮНЕСКО-гийн ERI-Net судалгааны төвөөс 2016 онд танилцуулсан байна). Эдгээрийг чадвар тус бүрээр дэлгэрүүлэн үзүүлбэл:

Шүүмжлэлт болон шинэлэг сэтгэлгээний чадвар

- Бүтээлч чадвар
- Зохион бүтээх чадвар
- Эргэцүүлэн бодох чадвар
- Шийдвэр гаргах чадвар

Хүмүүс хоорондын харилцааны чадвар

- Харилцааны чадвар
- Зохион байгуулах чадвар
- Багаар ажиллах чадвар
- Хамтарч ажиллах чадвар
- Нийтэч байх чадвар
- Өөрийгөө бусдын оронд тавьдаг байх, бусдыг өрөвдөх чадвар

Хувь хүний чадвар

- Хувийн сахилга бат
- Бие даан суралцах
- Дасан зохицох
- Өөрийгөө мэддэг
- Шаргуу байдал
- Өөрийгөө хүндэтгэх


Дэлхийн иргэний чадвар

- “Глобал/дэлхийн иргэний” талаар мэдлэг ойлголт
- Хүлээцтэй байх
- Нээлттэй байх
- Хариуцлагатай байх
- Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах
- Ёс зүйтэйг ойлгох
- Олон талт соёлыг ойлгох
- Зөрчилдөөнийг шийдвэрлэх
- Чөлөөт оролцоо
- Хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах
- Үндэсний онцлогоо мэдэх

Мэдээллийн технологийн хэрэглээний чадвар

- Мэдээлэл харилцааны технологиор дамжуулан мэдээлэл олж авах
- Мэдээлэлд дүн шинжилгээ хийх
- Мэдээллийн технологийг ёс зүйтэй ашиглах

21-р зууны эдгээр чадварыг эзэмшүүлэхийн тулд багш нар хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажлаар практикт ашиглаж болох арга, хэрэгсэл, сургалтын стратеги, үйл ажиллагааг түлхүү сонгох хэрэгтэй юм.



Зураг 1. ХГСА ба сурагчдын эзэмших чадварын матриц

6.2. ХГСА-ыг зохион байгуулах хэлбэр

Хичээлээс гадуурх сургалтын ажлыг орон нутгийн онцлог, тухайн сургуулийн сурагчдын эрэлт хэрэгцээнд тулгуурлан хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, тэдний авьяас, сонирхлыг дэмжин хөгжүүлэх чиглэлээр төсөлт ажил, туршилт, дадлага, дугуйлан, клуб хичээллүүлэх зэрэг олон хэлбэрээр зохион байгуулж болно. Тухайлбал:

- Дугуйлан, секц нь бүжиг, дуу, хөгжим, баримал, уран зураг болон гар бөмбөг, сагсан бөмбөг, бөх, байт сур, сур харваа, хөнгөн атлетик, усанд сэлэлт зэрэг урлаг, спортын авьяасыг нээж, хөгжүүлэх;
- Клуб нь хувцас, хоолны технологи, шатар, механик элетроникийн авьяас хөгжүүлэх болон мэтгэлцээн, байгаль экологи, хүмүүнлэгийн сайн дурын үйл ажиллагаагаар хувь хүний нийгэмшихүйн хөгжлийг хангах

Тодорхой төрлийн үйл ажиллагааг зохион байгуулахад өөр өөрийн зорилго, чиглэлтэй байх учраас арга зүйн хувьд онцлог ялгаатай байна. Иймд хичээлээс гадуурх сургалтын ажлыг боловсролын түвшин бүрт дараах байдлаар хэлбэржүүлэн хэрэгжүүлэх боломжтой юм.

Ангийн үйл ажиллагаа

- Ангийн зорилго, зохион байгуулалт, анги хамт олны уур амьсгал, эв нэгдлийг бэхжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа
- Хувь сурагчийн нэр хүнд, эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа

Секц, дугуйлангийн үйл ажиллагаа

- Суралцах арга барилыг сайжруулахтай холбоотой үйл ажиллагаа (сэтгэхүй хөгжүүлэх дугуйлан)
- Өөрийн авьяас чадварыг нээж, хөгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа (ардын урлаг, тайз дэлгэц, бүжиг, найрал дуу, үндэсний болон орчин үеийн хөгжим, дүрслэх урлаг, дизайн, техникийн загвар, гар урлал, загвар зохион бүтээх, загвар өмсөгч, шатар, даам, хөнгөн атлетик, спорт тоглоом, өвлийн спорт, бөх, мэтгэлцээний клуб, мини парламент гэх мэт)

Сургуулийн үйл ажиллагаа

- Тэмдэглэлт болон уламжлалт үйл ажиллагаа
- Амжилтаа тайлагнах үйл ажиллагаа
- Сургуулийн өдөр тутмын дэг, соёл, эрүүл аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаа
- Ажил хөдөлмөр, нийгмийн сайн сайхны төлөө хийх үйл ажиллагаа
- Сургууль доторх ургамал хамгаалал
- Сургуулийн цайны газар, сургуулийн цайны газар дахь үүрэг хариуцлагын зохион байгуулалт
- Сургуулийн номын санчдад туслах
- Аялал, зугаалга, эх оронтойгоо танилцах тойрон аялал

Сурагчдын зөвлөлийн үйл ажиллагаа

- Сургууль, орон нутгийн сайн сайхан байдал, хөгжлийг дэмжихэд тодорхой чиглэлийн дагуу хувь нэмрээ оруулахтай холбоотой үйл ажиллагаа (сайн дурын үйл ажиллагаа, эко клуб г.м)

Хичээлээс гадуурх сургалтын ажлыг сургуулийн захирал, нийгмийн ажилтны удирдлага чиглүүлгээр анги удирдсан эсхүл мэргэжлийн болон сайн дурын багш нар сургуулийн бодит байдал, сурагчдын бүтээлч санаачилга, онцлог, хөгжлийг харгалзан гэр бүл, нутгийн оршин суугчид, орон нутгийн байгууллагуудтай хамтран бэлтгэл сайтай, үр дүнтэй хэрэгжихээр зохион байгуулна. Үүнээс гадна хичээлээс гадуурх сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэлэлцүүлэх, сонгуулах, үйл ажиллагааг зохион байгуулах, үр дүнг үнэлэх, сайжруулахад сурагч, эцэг эх, асран хамгаалагч, орон нутгийн удирдлага, боловсролын болон олон нийт, бусад байгууллага, сонирхлын бүлгүүдийн оролцоог хангаж, хамтран ажиллана.

Багш хичээлээс гадуурх сургалтын ажлын явцад суралцагчийн эрүүл аюулгүй байдлыг ханган ажиллахад эцэг, эх, асран хамгаалагч, орон нутгийн иргэд холбогдох байгууллага, мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллахаас гадна тэднийг хараа хяналтгүй орхих, хүчирхийлэл, хорт зуршил, авто замын болон болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах бэлтгэлийг сайтар хангана.

Хичээлээс гадуурх сургалтын ажил нь суралцагчдад судлан шинжлэх арга барилд суралцах, бусадтай хамтран асуудлыг эргэцүүлэн бодож, шийдвэрлэх, илэрхийлэх явцдаа авьяасаа хөгжүүлэх, хамтран ажиллах, харилцан суралцах боломжийг олгохын зэрэгцээ ажил мэргэжлийн чиглэлээр судалгаа хийх, биечлэн танилцах, ажиглах, дадлага хийх, бусдад туслах сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах зэргээр анги танхимаас гадуур хичээллэх боломжийг бүрдүүлнэ.

6.3. Орчин, хэрэглэгдэхүүн

Сургуулиуд хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг хангах, өсвөр үеийнхний оролцоо, хамгааллын асуудлыг цогц байдлаар шийдсэн, хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлсэн байна.

Сургалтыг танхимын ба танхимын бус хэлбэрээр хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажил хоорондын интеграцыг ханган зохион байгуулна.

Танхимын орчинд:

- Багаар, бүлгээр уулзалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах
- Урлаг, спорт, хурлын заал, анги танхим дахь үйл ажиллагаа, илтгэл тавих, тайлан бичих, хамгаалах

Танхимын бус орчинд:

- Орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага сургалтын төвийн үйл ажиллагаатай танилцах аялал экскурс хийх
- Сургууль, эцэг эхийн хамтын ажиллагаанд тулгуурласан үйл ажиллагаа
- Хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгчидтэй хамтарсан төсөлт ажил, судалгаа хийх
- Бүтээлч санал санаачилга бүхий сайн үйлсийн аян өрнүүлэх
- Зайн сургалтын хэлбэрүүдийг хөгжүүлэх
- Орон нутгийн мэргэжлийн байгууллагын байр, танхим, олон нийтийн газар, байгаль орчныг түшиглэн явуулна.

ДОЛОО. ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН АЖЛЫГ ҮНЭЛЭХ

Хичээлээс гадуурх сургалтын ажлын үр дүнг үнэлэхдээ уралдаан, тэмцээний хэлбэрийг сонгох нь тийм ч оновчтой биш юм. Харин суралцагчдын ур чадвар, ахиц, бүтээлийн чанарын өсөлтийг өөрийнх нь гүйцэтгэлтэй харьцуулан үзэх нь оновчтой төдийгүй суралцагч урамшин өөртөө итгэлтэй болдог байна.


Сонгон, секц, дугуйлангийн үр дүнг дараах хэлбэрээр тодруулж, үнэлгээ хийх боломжтой. Үүнд:

- Сэтгэл ханамжийн судалгаа, ярилцлага хийх (багш, эцэг эх, сурагчдаас авах)
- Сурагчдыг өөрөө өөрийгөө үнэлэх өөрийн үнэлгээний хуудсаар үнэлэх
- Хүүхдийн хувийн хөгжилд чиглэсэн хандлагийн талаарх найдвартай мэдээллийг олж авахад чиглэсэн сэтгэл зүйн болон социологийн судалгаа явуулах
- Суралцагчдын авьяасаа хөгжүүлж, харилцан суралцаж буй байдлын бүтээлийн үзэсгэлэн, тайлан тоглолт, бүтээлийн сангаар үнэлэх

ХГҮА - г сэтгэл ханамжийн судалгаагаар дэмжинэ. Сэтгэл ханамжийн судалгааг сургалтын агуулга, хэлбэр нь уян хатан, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад ойлгомжтой эсэх, нээлттэй, ил тод байгаа эсэх; сул байгааг төлөвлөх дэмжих, үйл ажиллагааны төлөвлөгөөг сайжруулах, харилцаа, хандлага, уур амьсгал, үйл ажиллагаанд сэтгэл ханамж хэр байгаа талаар тодорхойлж, үнэлэлт дүгнэлт хийж, илэрсэн алдаа дутагдлыг арилгах, цаашид сайжруулах зорилготой хийнэ.

Сэтгэл ханамж нь багшийн санал болгож буй хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаа нь суралцагчийн хүлээлтэд хэрхэн нийцэж байна вэ гэдгийг тодорхойлдог өргөн ойлголт юм. Сэтгэл ханамж нь тодорхой хэмжүүрийн дагуу тооцогддог ба сургалт үйл ажиллагаагаа хөгжүүлэх шат дамжлагыг нарийн тодорхойлж өгдгөөрөө давуу талтай. Сэтгэл ханамжийн судалгаа нь ХГҮА -н хөтөлбөрт гарч буй өөрчлөлт чанар, сайжруулах эсэх талаарх санал бодлыг багш, суралцагч, эцэг эх хэрхэн үнэлж байгааг илтгэнэ.

Сэтгэл ханамжийн судалгаа хийх арга аргачлал



Сэтгэл ханамжийн асуулга нь (тодорхой асуулгын тоо хэд ч байж болно) Лайкартийн 1- 5 гэсэн шкалаар үнэлэгдэх бөгөөд “1” сэтгэлд огт нийцэхгүй, “2” сэтгэлд нийцэхгүй, “3” дунд зэрэг нийцнэ, “4” сэтгэлд нийцнэ, “5” маш их сэтгэлд нийцэж байна гэсэн хувилбартай байж болно.

ЭХ СУРВАЛЖ:

1. БСШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 15, 145
2. БСШУЯ. (2015). Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 160-179
3. БСШУ-ны сайдын 2010 оны 471 дүгээр тушаалын хавсралт. “Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм” УБ
4. БСШУ. (2016). ЦБС, “Насан туршийн боловсролын төвд дугуйлан, секц, клуб ажиллуулах зөвлөмж” УБ
5. БСШУЯ. Швейцарийн хөгжлийн агентлаг. (2016). “Ерөнхий боловсролын сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган, хэрэгжүүлэх үндсэн шаардлага” УБ. ВСI
6. МУ-ын Засгийн газар.(2017). “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр” УБ
7. Боловсролын хүрээлэн. (2017). “Ерөнхий боловсролын сургуулиудын хичээлээс гадуурх үйл ажиллагааг зохион байгуулж буй нөхцөл байдлын шинжилгээ”-ний тайлан, УБ
8. Дэлхийн банк, Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг. (2018). “Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээ”-ний тайлан, УБ
9. БСШУСЯ. (2018). “Аюулгүй амьдрах ухааны хөтөлбөр” сургалтын хөтөлбөр
10. (2014)., Аврагч мазаалайн зөвлөмж., гарын авлага
11. (2015). “Өсвөрийн аврагч” бүлгийн багшийн гарын авлага
12. (2017). “Бэлэн бай” сургалтын багц материал
13. (2016). “Сургуулийн гамшгаас хамгаалах менежмент” сургуулийн удирдлага, багш ажилтнуудад зориулсан гарын авлага
14. <http://ontsgoisur.gov.mn> Аврагч мазаалайн түүх видео хичээл
15. “Бэлэн бай” интерактив сургалтын хичээл
16. Бага, дунд боловсролын тухай хууль. <http://www.legalinfo.mn/>

Хавсралт 1. Нэмэлт хөтөлбөрийн жагсаалт

Хичээлээс гадуурх сургалтын ажлын хүрээнд нэмэлтээр сонгон судлах боломжтой хөтөлбөрийн жагсаалт

1. БСШУСЯ. (2018). “Аюулгүй амьдрах ухааны хөтөлбөр” сургалтын хөтөлбөр
2. БСШУСЯ. (2017). “Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр”
3. ХНХЯ. Монголын Урлагийн Сэтгэл Заслын Мэргэжлийн холбоо. (2021) “Үе тэнгийнхний дээрэлхэлт хүчирхийллийг зогсоох, урьдчилан сэргийлэх” гарын авлага
4. ГБХЗХГ. НҮБ-ын Хүүхдийн Сан (2017). “Миний ертөнц” хөгжлийн хөтөлбөр
5. ГБХЗХГ. НҮБ-ын Хүүхдийн Сан (2017). “Миний гэр бүл” хөгжлийн хөтөлбөр
6. ГБХЗХГ. НҮБ-ын Хүүхдийн Сан (2017). “Хүүхдийн оролцоог үнэлэх арга зүй”
7. Дэлхийн Зөн МОУБ (2016) “Оролцоод хөгжье” хөтөлбөр
8. БНБ-ын төлөө эвсэл “Үе тэнгийн дээрэлхэлээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр”
9. “Оролцоод хөгжье” - 12-18 насны хүүхдүүдэд зориулсан амьдрах ухааны хөтөлбөр (2016 оноос хойш хэрэгжиж буй)
10. “Оролцоод хөгжье” - 6-11 насны хүүхдүүдэд зориулсан амьдрах ухааны хөтөлбөр (2021 оноос хойш хэрэгжиж буй)
11. “Нөлөөлөл +” - 12-18 насны хүүхдүүдэд зориулсан амьдрах ухааны хөтөлбөр (2021 оноос хойш хэрэгжиж буй)
12. “Ухаалаг хөтөч” - Хүн худалдаалах гэмт хэргээс өөрийгөө болон үе тэнгийнхнийгээ хамгаалахад чиглэсэн хөтөлбөр 12-18 насны хүүхдүүдэд зориулсан (**Шинэ**)
13. “Өөрчлөлтийн төлөөх дуу хоолой” - Хүн худалдаалах гэмт хэргээс өөрийгөө болон үе тэнгийнхнийгээ хамгаалахад чиглэсэн хөтөлбөр, 12-18 насны хүүхдүүдэд зориулсан (**Шинэ**)
14. “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал” - Хүүхдийг цахим орчны эрсдлээс хамгаалахад чиглэсэн хөтөлбөр, 10-18 насны хүүхдүүдэд зориулсан амьдрах ухааны хөтөлбөр (**Шинэ**)

Хавсралт 2. Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн төлөвлөгөө

Хичээлээс гадуурч сургалтын ажлын үлгэрчилсэн чиглэл /агвар/

	хэд дэх 7 хоног	Танин мэдэхүйн хөгжил			Бие бялдрын хөгжил		Нийгэмшлийн хөгжил				
		Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшил дэмжих	Эрүүл, аюулгүй амьдрах арга ухааны боловсролд дэмжлэг үзүүлэх	Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Бие бялдрын чадварыг хөгжүүлэх	Авьяас чадварыг хөгжүүлэх	Нийгэм, олон нийтийн хамтын ажиллагааг дэмжих	Эх орноч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих	Мэдээллийн орчин хүмүүжилд нөлөөлөх нөлөөг өргөжүүлэх	Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх ажлыг эрчимжүүлэх	
1-р улирал	9-р сар	1	Багш, сурагч, эцэг эхийн гурвалсан гэрээ	Амьдрах үр чадварын сургалт	Сургуулийн дотоод дэг журам						
		2	Мэндлэх, хүндлэх ёсны талаарх сургалт		Сургуулийн орчныг танилцуулах		Харилцааны үр чадвар сургалт			Байгаль, экологийн чиглэлээрх ХӨУБ-ын үйл ажиллагаа	
		3		Эрүүл мэндийн сургалт				Ангийн хурал		Гар утас, зурагтын зохистой хэрэглээний сургалт	
		4	Хүүдийн эрийн талаарх сургалт			Оюун ухаан, сэтгэхүйн наадам, үйл ажиллагаа					
		5		Халварт өвчнөөс урьдчилан сэргийлэх			Монгол ёс заншил, ахуй соёлын талаарх үйл ажиллагаа		Монгол ёс заншил, ахуй соёлын талаарх үйл ажиллагаа		
10-р сар		6	Биеэ зөв авч явах, зөв төлөвшил олгох сургалт				Сургуулийн орны эрсдэлийн үнэлгээ-хүүдийн оролцоо арга хэмжээ				
		7		Эрүүл мэндийн сургалт	Хүүдийн эрх, хамгааллын талаарх сургалт		Сэтгэхүйн наадам, үйл ажиллагаа				
		8		Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, үйл ажиллагаа		Спортын арга хэмжээ		Сургуулийн Удирдах Зөвлөлийн хурал			
2-р улирал	12-р сар	11			Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, үйл ажиллагаа		Хүүдийн уран бүтээлийн урлан үзэсгэлэн, тайлан тоглолт зохион байгуулах				
		12			Хүүдийн хөгжих эрийн талаарх сургалт, үйл ажиллагаа						
		13						Орон нутгийн хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагаа		Хүүдийн эрийн конвенцийн тэмдэглэлт арга хэмжээ	
		14	Зөв хооллолт, ус, хүнсний эрүүл ахуйн талаарх сургалт, үйл ажиллагаа		Хүүдийн эсэн мэнд амьдрах эрийн талаарх сургалт, үйл ажиллагаа	Спортын арга хэмжээ	Урлагийн бага наадам				
	1-р сар	1-р сар	15							Цахим орчин дахь хүчирхийлээс урьдчилан сэргийлэх	
			16			Хүүдийн оролцооны эрийн талаарх сургалт, үйл ажиллагаа	Оюун ухаан, сэтгэхүйн наадам, үйл ажиллагаа			Байгаль, экологийн чиглэлээрх ХӨУБ-ын үйл ажиллагаа	
			17					Багаар ажиллах үр чадвар олгоход чиглэсэн үйл ажиллагаа		Спортын арга хэмжээ	
	2-р сар	2-р сар	18	Омьдн эрүүл ахуйн талаарх сургалт, үйл ажиллагаа	Сургуулийн Удирдах Зөвлөлийн уулзалт			Шинэ жилийн тэмдэглэлт арга хэмжээ зохион байгуулах			
			19			Хууль ёсыг сахиу, иргэн болж төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа					
			20	Хүүдийн хамгаалагдах эрийн талаарх сургалт, үйл ажиллагаа							Цахим орчин дахь харилцаа, өөрийгөө удирдах соёлын талаарх сургалт, үйл ажиллагаа
3-р улирал	2-р сар	21		Халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээ					Спортын арга хэмжээ		
		22					Бусад...		Байгаль орчноо хайрлан хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа		
	3-р сар	3-р сар	23	Хүүхэд хамгаалал тусламжийн утас сургалт, үйл ажиллагаа				Дотуур байрны хяналт үнэлгээг хүүдийн оролцоотойгоор хийх арга хэмжээ			
			24		Шилжилтийн үеийн онцлог (өсвөр насныханд) -ийн талаарх сургалт үйл ажиллагаа						
4-р улирал	5-р сар	25									
		26									
	5-р сар	5-р сар	27	Хүүхэд хамгаалал тусламжийн утас сургалт, үйл ажиллагаа							
			28		Өөртөө итгэлтэй бие хүн болж төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа		Спортын арга хэмжээ				
	5-р сар	5-р сар	29	Амны хөндийн эрүүл мэндийн талаарх сургалт, үйл ажиллагаа							
			30								
			31								
			32								
6-р сар	6-р сар	33					Хүүдийн уран бүтээлийн урлан үзэсгэлэн, тайлан тоглолт зохион байгуулах	Өөрийгөө удирдах чадвар олгоход чиглэсэн сургалт, үйл ажиллагаа	Байгаль орчноо хайрлан хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа		
		34	Гэр бүлийн боловсролд чиглэсэн сургалт, үйл ажиллагаа								
		35		Үе тэнгийний дарамтаас сэргийлэх	Хүүдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхийн өдөр арга хэмжээ						
		36		Архи, тамхины хор уршиг, сэргийлэлт							
6-р сар	6-р сар	37	Олон улсын гэр бүлийн өдрөөр эцэг эхийн сургалт өдөрлөг								
		38						Үерлэл нөхөрлөлийн үнэ цэнийн талаарх сургалт, үйл ажиллагаа			
		39		Нөхөн үржихүйн (ахлах ангийнханд) сургалт, үйл ажиллагаа							
		40					Олон улсын хүүдийн эрийн өдрийн тэмдэглэлт арга хэмжээ		Байгаль, экологийн чиглэлээрх ХӨУБ-ын үйл ажиллагаа		
41											

- Сурагчдын амралтын хугацаа
- Анги удирдсан багийн хариуцан гүйцэтгэх ажил
- Сургуулийн нийгмийн ажиглалтын хариуцан гүйцэтгэх ажил
- Сургуулийн эмчийн хариуцан гүйцэтгэх ажил
- Дугуйлан, секц удирдсан багийн хариуцан гүйцэтгэх ажил
- Сургалтын менежерийн хариуцан гүйцэтгэх ажил

ЖИЧ: Дээрх ажиглалтууд тус тусын ажлыг хариуцан гүйцэтгэх боловч хамтын ажиллагаанд тулгуурлан бүсдүн дэмжлэгийг авах нь чухал.

ХИЧЭЭЛЭЭС ГАДУУРХ СУРГАЛТЫН АЖЛЫН ҮЛГЭРЧИЛСЭН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Энэхүү зөвлөмж сурагчдын дунд зохион байгуулагдах үйл ажиллагааг өөрсдийнх нь оролцоонд тулгуурлан нас сэтгэхүйн, хөгжил төлөвшил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хэрхэн зохион байгуулж, чиглүүлж болох талаар санаа өгөх, ерөнхий чиглүүлэг удирдамж болгох зорилготой тул өөрийн орон нутаг, сургууль, сурагчдын нөхцөл байдал, хувь шинж, онцлог сонирхолтой уялдуулан бүтээлчээр ашиглана гэдэгт найдаж байна.

Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчдад өөрийгөө удирдан хөгжүүлэх, манлайлах, харилцах, сурах арга барилыг сайжруулах, тодорхой асуудлыг шийдвэрлэх, нийгмийн олон талт харилцаанд оролцох, түүнд өөрийн байр сууриа илэрхийлэх, бие хүний чадварууд хөгжих боломжтой болно.

Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж нь дараах 2 үндсэн хэсэгтэй.

- Сурагчдын бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн ерөнхий онцлог
- Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх зөвлөмж

6-17 насны сурагчдын танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийн онцлог

2014-2017 онд Боловсролын хүрээлэнгээс Монголын 6-17 насны хүүхдүүдийн танин мэдэхүй, нийгэмшил, бие бялдрын хөгжлийн онцлогийг цогц байдлаар судлан тогтоож түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг авч үзжээ. Судалгааны үр дүнг 6-17 нас тус бүрээр, бага боловсрол, суурь боловсрол, бүрэн дунд боловсролын түвшин тус бүрээр дундаж үзүүлэлтүүдийг гаргасан.

6-17 насны хүүхдүүдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн ерөнхий онцлог

Бие бялдар	Танин мэдэхүй	Нийгэмшил
10-12 насанд охидын биеийн өндрийн үзүүлэлт, 14 наснаас эхлэн хөвгүүдийн биеийн өндрийн үзүүлэлт нэмэгддэг.	Мэдээллийг хүртэхдээ ерөнхийд нь хүртэх хандлагатай.	Өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх нь зэрэг болдог.
Охидын биеийн өндөр 14 наснаас, хөвгүүдийн биеийн өндрийн үзүүлэлт 16 наснаас удааширсан байна.	Юмсыг гадаад байдлаар нь харьцуулах чадвартай, дотоод мөн чанар, учир шалтгаанд нь харьцуулах нь сул байна.	Нийцтэй, нөхөрсөг, бусадтай харилцах, хамтрах сонирхол сайтай болно.
Охидын биеийн жин 11-14 насанд, хөвгүүдийн биеийн жин 13-15 насанд нэмэгдсэн.	Нарийн мэдээлэл агуулсан байнга хэрэглэдэггүй үг хэллэгтэй мэдээллийг утгачлан тогтоох нь сул байна.	Өсвөр насанд бусдыг хүлээн зөвшөөрөх нь буурч, шүүмжлэлтэй хандлага бий болно.
12 наснаас эхлэн суурь боловсролын түвшинд хүүхдүүдийн хурдны чанар саарсан 15-17 насанд хөвгүүдийн хурд нэмэгдсэн. Нийт насанд хөвгүүдийн хурд илүү байна.	Өдөр тутам байнга хэрэглэдэг, бодит юмсыг заасан үгийн нөөц давамгайлдаг. Тэмдэг нэр, салаа утгатай үгийн нөөц сул болсон байна.	Өсвөр насанд эцэг эхтэйгээ дотно харилцах нь суларсан.
Хөвгүүдийн хүчний чанар анги ахих тусам нэмэгдсэн.	Энгийн богино өгүүлбэрээр ярьдаг. "бөгөөд, гэвч, учраас, боловч, миний бодлоор" гэх мэт холбоос хэрэглэсэн нийлмэл өгүүлбэрийг нийт хүүхдүүд хэрэглэх нь маш бага байна.	Өсвөр насанд айдас нэмэгдсэн.

Бага боловсролын түвшинд сурагчдын танин мэдэхүй, нийгэмшил, бие бялдрын онцлог:

Танин мэдэхүйн онцлог:

- Энгийн богино өгүүллэг, үлгэр гэх зэргийг утгаар нь хялбар тогтоодог, анхаарлаа төвлөрүүлэн хурдтай ажиллахдаа бэрхшээдэг байна.
- Юмс үзэгдлийг бодитоор харж, үйлдэж танин мэддэг бодит сэтгэхүй давамгайлна.
- Мэдээллийг утгаар нь тогтоох чадвартай байх тусам богино хугацаанд харж, сонсож тогтоох чадвар нь сайн байна.
- Үзэгдэл юмсыг хурдан хугацаанд ерөнхий дүр байдлаар хүртдэг, харин бүтэц, бүрэлдэхүүнийг ажиглан хүртэхдээ нэлээд удаан хугацаа шаарддаг. Юмсыг өнгө, хэлбэр, дүрс зэргээр нь ангилах чадвартай.
- Энгийн богино өгүүлбэрээр гадаад шинж байдлыг тоочин ярих нь давамгайл, 9 наснаас дэлгэрэнгүй нийлмэл өгүүлбэрээр санаагаа илэрхийлэх нь сайжирдаг.
- Хүүхдүүд богино хугацаанд ойролцоогоор 6-7 дүрс, зургийг хараад тогтоож сэргээн санадаг бол тоо/цифр хараад 3-4-ийг тогтоож сэргээн санадаг онцлогтой байна.
- 6-7 настай хүүхдүүд ахуйн түвшний агуулгатай 22 үйл явдал бүхий утгын нэгжээс 13-14 утгыг сэргээн санаж ярьсан бол 8-10 насанд 24 утгын нэгжтэй энгийн үлгэрээс 11-13 хүртэлх утгын нэгжийг сэргээн санаж байна.

6-10 настай хүүхдүүд анхаарлаа төвлөрүүлэн хурдтай ажиллах нь хангалтгүй, дүрс тэмдэгт хэлбэрийн мэдээллийг хараад тогтоох нь цифр, үг гэх мэт хийсвэр мэдээллийг тогтоохоос илүү, энгийн богино өгүүллэг, үлгэр уншаад утгаар нь тогтоох нь дундаж түвшинд байна.

Утгын ой тогтоолт сайтай байх тусмаа анхаарал, богино хугацааны ой тогтоолт, мэдээллийг хүртэх чадвар сайн байна.

- 7 наснаас эхлэн ухагдахууны талаарх ойлголтын төлөвшил нэмэгдэж байгаа ба 8-10 настай сурагчдын сэтгэхүйн задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, үйлдлийг юмсын гол шинжийг олох, сэтгэхүйн харьцуулах үйлдэл нь дундаж буюу дунджаас доогуур түвшинд байгаа нь эдгээр үйлдлүүд сул хөгжилтэй байгааг харуулж байна.
- Хэл яриа-сэтгэхүйн логик чадварын хувьд үгийн утга тайлбарлах, энгийн ойлголт, мэдлэг, сэтгэхүйн задлан шинжлэх, нэгтгэх чадварууд нь 6-10 насанд чухал байдаг байна.
- Бага ангид хүүхдүүдэд бодит үгийн нөөц давамгайлдаг ба ярих чадварын хувьд харагдаж байгаа зүйлийг байгаагаар нь тоочин энгийн богино өгүүлбэрээр ярих нь илүү давамгайлдаг байна. Харин салаа үг, тэмдэг нэрийн эзэмшилтийг сайжруулахад анхаарах нь зүйтэй байна.
- Математик тооцоолол хийх, юмсыг шинж байдлаар нь задлан шинжлэх, ижил төсөөтэйгөөр ангилах чадвар нь сэтгэхүй хэл ярианы бусад чадвартай харилцан хамаарал өндөртэй тул тухайн чадвар нь танин мэдэхүйд голлох үүрэгтэй байна.
- 2 минутад зорилго чиглэлтэйгээр санаа бодлоо илэрхийлэхдээ дунджаар 34-35 үгийг хэрэглэсэн байна.

Нийгэмшлийн онцлог:

- Бага боловсролын 6-10 настай хүүхдүүдийн зан төлөвийн ерөнхий онцлог нь ажил үүрэгтээ хариуцлагатай хандах, өөрийн зан төлөвөө зохицуулах, үйл ажиллагаанд идэвхтэй хандах, оролцох чадвар сайн, бусад хүмүүстэй харилцахдаа анхааралтай хандах, анхаарал халамж тавих чадвартай, сэтгэл санааны хувьд тогтвортой байдаг байна. Энэ насныхан сэтгэл санааны хувьд өөдрөг айдас түгшүүрт автагдах нь бага байна.
- Энэ насны хүүхдүүдийн өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар нас нэмэгдэхэд бага зэрэг буурч байгаа нь бие даасан, шүүмжлэлт сэтгэхүйн хөгждөгтэй холбоотой юм.
- Хүүхдүүд бусадтай нээлттэй, идэвхтэй харилцах болон бусад хүмүүсийн сэтгэл санааг ойлгож харилцах чадвартай болсон байдаг байна.

- Бага боловсролын 6-10 настай хүүхдүүд аюулгүй байхыг хамгийн чухалд үзсэн бол бие даасан байх, бусдаар хүндлүүлэхийг харьцангуй чухал биш гэж үзсэн байна. Харин бусдад хүндэтгэлтэй хандах, уламжлал, ёс заншлаа чухал хэмээн хүүхдүүд үздэг байна.
- Бага боловсролын 6-10 настай хүүхдүүд нийгмийн болон ёс суртахууны хэм хэмжээ, заавар зөвлөгөөг даган биелүүлэх чадвартай байна.

Бие бялдрын хөгжлийн онцлог:

- 6-10 настай эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн өндөр нь жилд дунджаар 4-6 см-ээр, биеийн жин 2-4 кг-аар нэмэгддэг байна.
- Хөвгүүдийн биеийн цээжний тойргийн хэмжээ жилд 1-2 см-ээр, охидынх 2-3 см-ээр нэмэгдсэн байна. Хөвгүүдийн бүсэлхийн тойрог 8, 10 насанд нэмэгддэг бол охидынх 8 насанд илүү нэмэгджээ.
- Хөвгүүд дунджаар гар дээрээ 30 секундэд 17 удаа суниадаг бол охид 13-14 удаа суниадаг байна.
- Авхаалж самбаатай байх чадвар, хурдны чанар охид хөвгүүдийн хувьд ялгаагүй байна. Холын зайд гүйх тэсвэрт чанар хөвгүүдийнх охидтой харьцуулахад илүү үзүүлэлттэй байна.
- Хөвгүүдийн хөлийн булчингийн тэсрэлтийн хүч буюу холын зайд харайх нь уртын хэмжээ дунджаар 122 см бол охидынх 108 см байна.
- Уян хатан чанар буюу суугаа байдлаас бөхийх чадвар нь хөвгүүдийнх 4.4 см бол охидынх 6.4 см байна.

Суурь боловсролын түвшинд сурагчдын танин мэдэхүй, нийгэмшил бие бялдрын онцлог:

Танин мэдэхүйн онцлог:

- 11-14 настай хүүхдүүд хялбар танил зүйлсийг ерөнхийд нь таньж хүртэх, харин анхаарлаа төвлөрүүлэн, хүчин чармайлттайгаар нарийн бүтэц бүрэлдэхүүнийг хүртэж ажиглах, ажиллах чадварыг нь дэмжих хэрэгтэй байна. Хүүхдүүд нарийн мэдээлэл тэмдэгтүүдтэй ажиллахдаа анхаарал сарнидаг, ажиллах чадвар нь хурдан буурдаг талтай байна.
- Богино хугацаанд 9 хүртэлх дүрс тэмдэгтийг, 5 хүртэлх цифр тоо гэх мэт нарийн мэдээллийг тогтоож сэргээн санадаг, дунджаар 6 хүртэлх үгийг сонсоод богино хугацаанд тогтоож сэргээн санадаг.
- Мэдээллийг харж тогтоохдоо эхэнд байгаа 5 хүртэлх мэдээллийг тогтоодог бол сүүлийн мэдээллийг сэргээн санахгүй байх нь элбэг, харин сонсоод тогтоохдоо эхний болон сүүлийн үгсийг тогтоож сэргээн санадаг, харин дундах мэдээлэл мартагдах магадлалтай байна.
- 11-14 настай хүүхдүүдийн тооцоолох сэтгэхүй, юмсыг бүтэц бүрэлдэхүүнээр задлан шинжлэх, юмсыг ижил төсөөтэй шинжээр нь нэгтгэн дүгнэх, хэл ярианы чадвар зэрэг нь нас нэмэгдэхэд аажмаар нэмэгджээ. Тодруулбал, нас нэмэгдэхэд үгийн нөөц сайжирч, юмсыг учир шалтгаанд нь сэтгэх чадвар нь нэмэгдэн гадаад байдал, төрхөөр нь тоочиж ярих нь буурч ерөнхийлөн дүгнэж ярих хандлагатай болдог байна.
- 11-14 насанд нийт хүүхдүүдийн анхаарлын тогтворжилт сул байна.
- Хүүхдүүдийн богино хугацаанд шинжлэх ухааны, утга агуулгатай мэдээллийг тогтоох чадвар сул байгаа нь анхаарлын тогтворжилт сул байгаатай холбоотой.
- Хүүхдүүд мэдээллийн утга санааг ойлгохдоо нийтлэг шинжээр нь харьцуулах нь хангалтгүй байна.
- Нас ахих тусам хүүхдүүдийн үгийн нөөц нэмэгдсэн ба бүх насанд “бөгөөд, гэвч, учраас, боловч, миний бодлоор” гэх мэт холбоос хэрэглэсэн нийлмэл өгүүлбэрийг хэрэглэх нь маш сул. Гэтэл энэхүү хэрэглээ нь хүүхдүүдийн хийсвэр сэтгэхүйн хөгжлийн илрэл байдаг.

- Хэл яриа-сэтгэхүйн логик чадварын хувьд, хүүхдүүд үзэгдэл юмсыг гадаад шинж байдлыг танин мэдэж нийтлэг шинжээр нь нэгтгэн дүгнэх нь илүү байна. Ялангуяа, анхаарлын төвлөрөл бага шаардсан зүйлийг таньж нэгтгэн дүгнэж, зүй тогтолд нь сэтгэдэг байна. Харин учир шалтгаан, мэдлэг ойлголтод үндэслэн зүй тогтолд нь сэтгэн нэгтгэн дүгнэх нь сул байна. Тухайн чадвар нь нас нэмэгдэхэд аажмаар сайжирсан байна.
- Хүүхдүүдийн үгийн нөөцийн хувьд, бодит, ахуйн шинжтэй үгийн утгыг илүү мэддэг бол салаа/ижил утгатай үг, тэмдэг нэрийн үгийн утгыг таньж тайлбарлах, бүлэглэх нь сул байна.
- Ярих чадварын хувьд, энгийн богино өгүүлбэрээр ерөнхийлөн дүгнэж, дунджаар 2 минутад ойролцоогоор 31 үгээр санаагаа ярьж илэрхийлдэг байна.
- Охидын үгийн нөөц, үгийн утгыг оновчтой тайлбарлах, юмсыг хооронд нь харьцуулан төстэй ба ялгаатай талыг нь олох, нэгтгэн дүгнэх нь хөвгүүдтэй харьцуулахад сайн байна.

Нийгэмшлийн онцлог:

- Энэ насны хүүхдүүдийн өөрийгөө хүлээн зөвшөөрөх, сэтгэл санааны тогтвортой байдал, өөрийн зан төлөвийг удирдах, ухамсар хариуцлагатай, анхааралтай зан төлөв, эцэг эх, хүүхэд хоорондын харилцаа, эзэнгшилт, бусадтай хамтрах чадвар нь нас нэмэгдэхэд бага зэрэг буурч байна.
- Өөртөө хандах хандлага сайн байх тусам бие хүний онцлог, сэтгэлийн хөдөлгөөн, дасан зохицолт, эзэнгшилт болон харилцааны чадварууд эерэг байна.
- Өөртөө хандах хандлага, бие хүний онцлог болон харилцааны чадварууд нь 11-14 насны хүүхдийн нийгэмшилд чухал нөлөөтэй байна.
- Хөвгүүдийн харилцааны чадвар, нийгмийн хэм хэмжээг баримтлах чадвар, нийт хүүхдүүдийн өөртөө хүндэтгэлтэй хандах, бусдаас хамааралгүй бие даан шийдвэр гаргах, эцэг эхтэйгээ нээлттэй харилцаатай байх чадварыг нь дэмжих хэрэгцээтэй байна.
- Өсвөр насанд нийгмийн хэм хэмжээг сахих нь бага зэрэг буурч байна. Өсвөр наснаас хүүхдүүд эцэг эхтэйгээ хөндий харилцаж эхэлдэг байна. Ийм учир багш ангийн ажлаар чиглүүлэн эцэг эхэд нь ойлгуулан хүүхдийн нийгэмшлийг дэмжих чухал үе байна.
- Суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд суралцаж буй хүүхдүүдийн бусдын сэтгэл санааг ойлгож харилцах чадвар сул байна.

Бие бялдрын хөгжлийн онцлог:

- 11-14 насанд хүүхдүүдийн биеийн ерөнхий хөгжил тухайлбал толгойн тойрог, биеийн жин, бүсэлхийн тойрог, цээжний тойрог, биеийн өндөр нас нэмэгдэх тусам өссөн үзүүлэлттэй байгаа нь насны зүйн тогтол, физиологийн хөгжлийн дагуу явагдаж байна.
- Биеийн жингийн индексийн үзүүлэлтээр охидын 13-14 насанд таргалалтын 1 ба 2 зэрэгт орж эхэлж байгаа энэ үед анхаарах тохирсон дасгал хөдөлгөөнийг хийлгэх шаардлагатай болж байгааг харуулж байна. Хүүхдүүдийн биеийн жин нэмэгдэж байгаатай холбоотой цээжний тойрог болон бүсэлхийн тойрог мөн нэмэгдэж байгааг илэрхийлж байна.
- Хүүхдүүдийн биеийн өндөр 11-12 насанд 4.74 см, 13-14 насанд 2.41 см-ээр нэмэгдэж байгаа нь манай улсын эрдэмтдийн хийсэн судалгааны үр дүнтэй буюу эрчимтэй хөгжлийн үе шатандаа явж байгааг илэрхийлж байна.
- Хөвгүүдийн хувьд нас нэмэгдэх тусам хурдны чанар сайжирсан байна. Тухайлбал 11-12 насанд 0.50 секундээр, 13-14 насанд 0.20 секундээр нэмэгдсэн нь хурд сайжирч байгааг илэрхийлж байна.

Бүрэн дунд боловсролын түвшинд сурагчдын танин мэдэхүй, нийгэмшил бие бялдрын хөгжлийн онцлог:

15-17 настай хүүхдүүдийн хэл яриа, сэтгэхүйн хөгжлийн онцлог

Хэл яриа, сэтгэхүйн логик чадварын хувьд, үзэгдэл юмсыг дотоод мөн чанарыг таньж нэгтгэн дүгнэх чадвартай хэдий ч гадаад шинж байдлыг нь голчилдог хандлага давамгай байна. Хийсвэр сэтгэхүй нь нас нэмэгдэхэд аажмаар сайжирсан байна. Бодит, ахуйн шинжтэй үгийн утгыг илүү мэддэг салаа/ижил утгатай үг, тэмдэг нэрийн үгийн утгыг таньж тайлбарлах, бүлэглэх нь дундаж түвшинд, өмнөх 11-14 настай харьцуулахад үгийн нөөц, хэл ярианы сэтгэхүй сайжирсан. Энгийн богино өгүүлбэрээр ерөнхийлөн дүгнэж, дунджаар 90 гаруй минутад ойролцоогоор 32 үгээр ярьдаг онцлогтой байна.

Танин мэдэхүйн онцлог:

- Хүүхдүүдийн танин мэдэхүйн хөгжилд мэдээллийг утгаар нь тогтоох, богино хугацаанд харж тогтоох, анхаарлын төвлөрөл, сэтгэхүйн харьцуулан, ангилах, нэгтгэн дүгнэх, математик үйлдэл хийх чадвар болон үгийн утгын эзэмшилт голлох байр суурьтай байна.
- Энгийн богино өгүүлбэрээр ерөнхий дүгнэж ярих нь давамгай байр суурьтай байна. Хүүхдүүдийн сэтгэхүй, хэл яриа үгийн нөөцийг дэмжих нь тухайн насныхны танин мэдэхүйн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.
- Богино хугацаанд энгийн дүрс тэмдэглэгээг хараад 10-11 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг бол цифр, нарийн мэдээлэл зэргийг 6 хүртэлхийг тогтоож сэргээн санадаг онцлогтой. Сонсоод богино хугацаанд 6-7 хүртэлх үгийг тогтоож сэргээн санадаг, хийсвэр агуулгатай, танил бус үг хэллэгтэй үйл явдал бүхий мэдээллээс 16 хүртэлх утгыг тогтоодог онцлогтой байна.
- 5 жилийн өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад, хүүхдүүдийн анхаарлаа төвлөрүүлэх, үгийн утгыг таньж тайлбарлах нь сайжирсан байна. Мөн богино өгүүлбэрээр ярьдаг нь өссөн үзүүлэлттэй. Өөрөөр хэлбэл, нийлмэл өгүүлбэрээр ярих нь буурсан гэсэн үг юм. 17 насанд хүүхдүүд нийлмэл өгүүлбэрээр ярих чадвар нь нэмэгддэг байна.
- Хүүхдүүд мэдээллийг дотоод мөн чанар, учир шалтгаанд нь сэтгэж харьцуулан ойлгох чадвар хангалтгүй байгаа нь шийдвэр гаргах, юмсыг ойлгохдоо хөнгөн хийсвэр, гадаад хэлбэр, шинжээр нь хандах хандлагыг бий болгодог тал байж болох тул үүнийг анхаарах нь зүйтэй байна.
- Үгийн нөөц нь нас нэмэгдэхэд сайжирсан хандлагатай байна. Нас нэмэгдэхэд энэ нь хийсвэр, салаа утгатай үг, тэмдэг нэрийн ойлголт хэрэглээгээр нэмэгддэг онцлогтой байна. Анги ахих тусам юмсыг харагдаж байгаагаар нь биш илүү цаад учир шалтгааныг дүгнэж товчхон илэрхийлэх хандлага нэмэгдэж байна.

Нийгэмшлийн онцлог:

- Хүүхдүүдийн нийгэмшлийн хөгжилд үнэт зүйл, нийгмийн хэм хэмжээ, эзэнгшилтийн чадварууд голлох байр суурьтай байна.
- Эрэгтэй хүүхдүүдийн өөртөө итгэх итгэл, өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар нь эмэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа бол эмэгтэй хүүхдүүд эрэгтэй хүүхдүүдтэй харьцуулахад ёс суртахууны хэм хэмжээ, дүрэм журам, олон нийтийн газар биеэ авч явахад илүү ач холбогдол өгдөг бөгөөд охид стресс, түгшүүрт хөвгүүдээс илүү өртөмтгий, эмзэг байдаг байна.
- Сэтгэлийн хөдөлгөөний чадваруудын хувьд, өсвөр насны онцлог ажиглагдсан бөгөөд бусдын болон өөрийн сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг мэдэх, ойлгох чадвар илүү хөгжсөн ч заримдаа сэтгэлийн хөдөлгөөнөө бусдад илэрхийлж гаргахдаа нөхцөл байдалд автагдан өөрийн үг, үйлдлээ тохиромжгүй байдлаар илэрхийлдэг онцлогтой.
- Дасан зохицох чадваруудын хувьд, аливаа харилцаанд илүү тэвчээртэй, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг, ойлголцохыг эрмэлздэг, шүүн тунгаах, өөрийн хариуцлагыг ухамсарлан бие даан шийдвэр гаргах чадвартай болсон

хэдий ч заримдаа гаднын болон орчин тойрны хүмүүсийн нөлөөнд автдаг, аялдан дагалдах хандлагатай байгааг харуулж байна.

- Эцэг эхийн ойр дотнын хүмүүсийн дэмжлэгт эргэлздэггүй ч заримдаа эцэг эх, асран хамгаалагчтайгаа нээлттэй, чөлөөтэй санаа бодлоо илэрхийлж чаддаггүй байна.
- Харилцааны хувьд, 15-17 настай хүүхдүүд бусдын сэтгэл санааг илүү ойлгодог, бусадтай харилцах дуртай болсон ч заримдаа илэн далангүй, нээлттэй харилцан ярианд орж чаддаггүй, ихэнх тохиолдолд тогтсон жишиг зааврыг дагах, хариуцсан ажилдаа хариуцлагатай байхаас илүү бусадтай хамтрахыг илүү эрмэлздэг байна.
- 15-17 настай хүүхдүүдийн дунд амьдралын зорилготой, хувийн зохион байгуулалттай, хариуцлагатай, дүрэм журмыг баримталдаг, өөрийн амьдралдаа урам зоригтой, баяр баясгалантай, хэм хэмжээг зөрчихгүй байхыг анхаардаг бие хүний онцлог шинжүүд түлхүү ажиглагдаж байна.
- 15-аас дээш насны хүүхдүүдийн хувьд олон нийтийн газар биеэ зөв авч явахад анхаардаг, дүрэм журам баримтлахыг хичээдэг, ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрддөг байна.
- Хүүхдүүдийн нийгэмшлийн хөгжилд унтдаг цаг, эцэг эхийн тусалдаг оролцоо, багшийн өгч буй гэрийн даалгавар, гэр бүлийн харилцаа, эцэг эхийн боловсролын түвшин, өрхийн орлого эерэг нөлөө үзүүлдэг байна. Жишээлбэл, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдүүдээ урамшуулж, сайн хандах тусам эцэг эх, хүүхэд хоорондын итгэлцэл нэмэгдэн, эцэг эх, хүүхэд хоорондоо нээлттэй харилцаатай болж улмаар хүүхдийн өөртөө итгэх итгэл, өөрийн үнэлэмж, бие хүний төлөвшилд эерэг нөлөө үзүүлдэг байна.

Бие бялдрын хөгжлийн онцлог:

- Хүүхдүүдийн биеийн ерөнхий хөгжил тухайлбал толгойн тойрог, биеийн жин, бүсэлхийн тойрог, цээжний тойрог, биеийн өндөр харьцангуй бусад насаа бодвол тогтвортой байдаг байна. Биеийн жин нас нэмэгдэх тусам охидын хувьд 1.38- 1.35 кг аар, хөвгүүдийн хувьд 2.29-2.1 кг аар нэмэгдсэн ба 15 насны хөвгүүдийн 8.4 хувь, 16 насны хөвгүүдийн 15.4 хувь, 17 насны хөвгүүдийн 15.0 хувь нь илүүдэл болон таргалалтын 1 ба 2-р хэлбэрт байгаа нь биеийн жингийн илүүдэлд анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.
- 15-17 насанд хөвгүүдийн баруун, зүүн гарын атгах хүч ялгаа ихтэй байгаа ба охидын гарын атгах хүч тогтвортой байгаа ба хөвгүүдийн гарын атгах хүч 2.67-1.58 кг -аар нэмэгддэг байна.
- Хөвгүүдийн хувьд нас нэмэгдэх тусам хурдны чанар сайжирсан байна. Охидын хувьд хөвгүүдээс хурд удаан байна.
- Хүүхдүүдийн уян хатан чадварын хувьд охидоос хөвгүүд уян хатан бус байгаа учир хөвгүүдийн энэ чадварыг дэмжих шаардлагатай байна.
- Авхаалж самбаатай чадвар нь охидын хувьд тогтвортой байгаа ба хөвгүүдийн хувьд хурд 16 насанд хурд нэмэгдсэн байна.

НЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮРЭЭНД ОЛГОХ ХҮМҮҮЖИЛ, ТӨЛӨВШЛИЙГ ДЭМЖИХ

1.1. Хүмүүжлийн үйл ажиллагаанд гэр бүлийн оролцоог нэмэгдүүлэх

1.2. Хүүхэд хүмүүжүүлэх гэр бүлийн уламжлалт соёл, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлан, гэр бүл дэх хүмүүжлийн чиглэлээрх ажилд дэмжлэг үзүүлэх

1.1.1.Зорилго: Хүүхэд гэр бүлдээ хүмүүжих, хүүхдийн сонирхлыг дэмжих, хүүхдийг хөгжүүлэх гол үндэс нь болох гэр бүл болон сургуулийн орчинд дүрэм журам баримтлах, харилцан ойлголцох, өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг таних, хянах, ойлгох, буруу зүйлд уучлал гуйх зэрэг эерэг хандлагыг төлөвшүүлэхэд оршино.

1.1.2. Үндсэн ойлголт:

- Гэр бүлийн тухай ойлголт
- Энгийн дэг, дүрэм журам баримтлах талаар ярилцах, өөрсдөө зохиох
- Үлгэр эх уншиж асуудлыг тайлбарлан өөрсдөө дүгнэж ярилцах
- Эцэг эх, багш сурагчид, хоорондоо ээнэгшин дасах, харилцан ойлголцох
- Сэтгэлийн хөдөлгөөнийг таних, гомдсон, ууралсан үеийн байдлаа хэрхэн ойлгуулах
- Тодорхой асуудалд шүүмжлэлттэй хандаж өөрсдийн санал бодлыг бүрэн илэрхийлэх
- Багш сурагчдын харилцааны талаар тохиолдож болох кейс ашиглах
- Энэрэнгүй үйлсийн аян зохион байгуулах, бусдад туслах
- Монголчуудын хүүхдээ хүмүүжүүлж байсан онцлог
- Монгол хүний үнэт зүйлийн талаар санал бодлоо илэрхийлэх
- Монгол гэрийн дэг, аав хүний эрдэм, хатан хүний ухаан, охин, хүүгийн баримтлах дэг гэх мэт

1.1.3. Үйл ажиллагаа:

а. Бага боловсролд

- Хэн нэгэнд туслах, санамсаргүй буруу зүйл хийсэн бол уучлал гуйх, дүрэм журмын тухай ойлголттой болгох, сэтгэлийн хөдөлгөөнийг ялгаж, таних
- Эцэг эхээ хайрлах санаа авах үлгэр “Хөхөө шувууны”
 - Яагаад хөхөө шувуу болоод нисээд явсан тухай асуултууд бэлдэж асууна.
 - Яагаад эцэг эх, гэр бүл, найз нөхдөө, эргэн тойронд байгаа хүмүүсээ хайрлах, туслах талаар асуултаар чиглүүлэн ойлголт өгөх
- Хүүхдүүдийг харьцуулах дүгнүүлэх, өөрсдийн санаа бодлыг яриулах, асуултад хариулах байдлаар сэтгэхүйн үйлүүдийг хөгжүүлэх
- Эцэг эхтэйгээ харилцах, ойлголцох талаар ахмад багш, эцэг эхийн төлөөлөлтэй уулзалт хийлгэх, санаа авах загвар олж уншуулан дүгнүүлэх, тайлбарлан ярьж өөрсдөөр нь харьцуулах, дүгнүүлэх үйл хийлгэх өөрийн санаа бодлоо бүтэн өгүүлбэрээр илэрхийлэх боломж олгох

б. Суурь боловсролд

- Сургуулийн орчин, нийгмийн орчин, гэр бүлийн орчинд дэг журам баримтлах, бусдыг хүлээн зөвшөөрөх, шүүмжлэлттэй хандаж сурах, өөрийн буруу үйлдэлд уучлал гуйх, бусдын үйлдлийн талаар өөрийн байр суурийг илэрхийлэх
- Гэр бүлийн гишүүдийн оролцоотойгоор тодорхой даалгавруудыг гүйцэтгэх болон гэр бүлийнхэн болон бусад хүмүүст туслах аян өрнүүлэх

в. Бүрэн дунд боловсролд

- Ахмад настан болон бусад хүмүүсийг хүндэтгэн туслах, хүмүүнлэгийн ажилд идэвхтэй оролцох, дүрэм журам баримтлах, өөрийн санаа бодлоо ямар ч үед илэрхийлэх чадвартай болох дүгнэх харьцуулах боломжтой санаануудыг жишээгээр бэлдэх
- Гэр бүлийн харилцаа олон хэлбэрүүдийг таниулах гэр бүл болоход ямар ямар зүйлд анхаарах талаар бусад хичээлтэй холбож багш нартай хамтран чөлөөт ярилцлага зохион байгуулах

1.1.4 Арга зүй

Хамтын уншлага – хамтын ярилцлага арга

Хамтын уншлага ба ярилцлага нь (Vaughn and Estes, 1986; Steele and Meredith, 1997) “Хөхөө шувуу” үлгэрийг хоёр сурагч мөрөөр буюу хэсэг хэсгээр нь ээлжлэн уншиж нөгөө сурагчдаа гол утгыг нь ярьж өгөх арга юм.

Хамтран сурахуйн энэ арга нь сурагчид бие биеийн сурахуйд идэвхтэй хандахын зэрэгцээ хичээлийн сэдвийн гол агуулгыг ойлгоход нь дэмжлэг үзүүлэх явдал юм.

Сурагчдын хийх үйл ажиллагаа

Алхам 1: Ач холбогдол бүхий мэдээлэлтэй текст, бичвэрийг сонгоно. 3-аас дээшгүй өгүүлбэрээс бүтсэн догол мөр бүхий байвал сайн ба эсвэл багш өөрөө текстийг хэсгүүдэд хувааж тэмдэглэж болно.

Алхам 2: Хэрэв сурагчид энэ аргыг хараахан эзэмшээгүй бол багш эхлээд тайлбарлаж үзүүлнэ. Үүний тулд:

а) Дасгалын эхний хэсэгт: Багш текстийн эхний хэсгийг чанга дуугаар сурагчдад уншиж өгсний дараа гол утгыг нь ярьж өгнө. Гол утгыг тайлбарлахдаа уншсан хэсгийнхээ чухал мэдээллийг нь дамжуулахад анхаарахын зэрэгцээ эх текстээс арай богино, цөөн үгээр илэрхийлнэ гэдгийг сурагчдад хэлж өгнө. б) Дасгалын 2 дахь хэсэгт: Үлгэрийн (текстийн) энэ хэсгийн талаар асуулт асуугаарай багш нь хариулъя гэнэ. Багш сурагчдын асуултад хариулт өгнө. Дараа нь багш сурагчид үүргээ солино.

Алхам 3: Сурагчдыг хос хосоор хамтран ажиллуулна. Нэг сурагч текстийн эхний хэсгийг нөгөө сурагчдаа уншиж өгөхийн зэрэгцээ гол утгыг нь ярьж өгнө. Энэ хэсгийг тодорхой хугацаанд гүйцэтгэх ба багш сурагчид дасгалыг хэрхэн гүйцэтгэж буйг хянахын тулд хэдэн сурагчдаар гол утгыг нь яриулна.

Мөн сурагчид бие биендээ асуулт асууж хариулт авна. 2-3 сурагчийг асуултаа хуваалцахыг хүсэх ба хэрэв асуулт оновчтой бус байвал багш нэмэлт тайлбар өгч тусална.

Алхам 4: Ийнхүү дасгалыг бие даан гүйцэтгэх дадал, чадвартай болсны дараа сурагчид хосоор бие даан ажиллана. Текстийн догол мөр буюу хэсэг бүрийн дараа сурагчид үүргээ сольж байхыг сануулна.

Кейс арга: (Case method)

Тохиолдол буюу кейс шинжлэх арга нь амьдралын тодорхой жишээн дээр үндэслэж задлан шинжилгээнд мэдээ баримтыг ашигладаг арга. Кейс судалгааг нөхцөл байдлыг тайлбарлах, шүүмжлэх, эрэл хайгуул хийх зэрэгт ашигладаг. Кейс судалгааны давуу талууд бол амьдралтай шууд холбогддог, хүүхдүүдэд ойлгомжтой нээлттэй байдаг зэрэг юм. Кейс арга нь өдөр тутмын амьдралын туршлага, бодит амьдралын нөхцөл байдлыг хэрхэн ойлгож байгаатай нь шууд холбогддог үр дүнтэй чанарын арга бөгөөд асуултын аргад тулгуурласан хэлбэр юм.

Багш асуултаар болон тодорхой жишээгээр чиглүүлэх үед цээжлэн тогтоох эхний хэлбэрээс эхлээд бодит баримтыг үнэлэх дүгнэх сэтгэхүйн үйлдлүүдийг хийж сурах учир хүүхдүүд тухайн сэдвийг сонирхох, мэдээлэл сонирхон судлах, идэвхийг нэмэгдүүлэхэд энэ арга чиглэгдэнэ.

Бага боловсролын түвшинд багш асуултаар чиглүүлэн үлгэрийн үйл явдлыг бодуулах дүгнүүлэх, санаагаа илэрхийлэх боломж олгосноор сэтгэхүйн үйлдүүдийг хөгжүүлэх боломж бүрдүүлэх юм.

Суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд ихэвчлэн эх бичвэрийн хэлбэртэй байж болох боловч кино дүрс, дуу бичлэг, маргаан зохиох арга ашиглах, дүр бүтээж тоглох болон бусад хэлбэрээр байж болно.

Багш нь энэ аргаар хичээл явуулахад ярилцлагыг хөтлөгчийн дүрд тоглох учир энэ дүрд бэлэн байна

Энэ аргыг хэрэглэхдээ багш 25 хүртэл хүүхэдтэй ажиллах бөгөөд хэтэрхий олон хүүхэдтэй багш нэгэн зэрэг ажилласан тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлөх сөрөг талтай.

Кейс бэлтгэх

Кейс бэлтгэх сонгож авах болон боловсруулахдаа дараах зүйлүүдийг анхаарна. Үүнд:

- Тухайн хичээлийн агуулга, арга, үр дүнд тохирсон байдал
- Гэр бүлийн амьдралд тохиолддог асуудлуудыг тусгасан буюу бодит байдалд бүрэн нийцсэн байдал
- Тохиолдол нь хүүхдүүдэд анализ хийх, шийдэл гаргах, бодож боловсруулах боломж олгохуйц байгаа байдал
- Тохиолдлын талаар эерэг, сөрөг нотолгооны хувилбар, шийдэлд хүрэхүйц байдал
- Тухайн тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай баримт нотолгоог бүрдүүлж, холбогдох мэдээллийг өгөх нь мэдээллийг боловсруулж, үндэслэл бүхий шийдвэр гаргахад чухал нөлөөтэй юм.

Тохиолдлыг уншуулж танилцуулахдаа тохиолдлын эцсийн шийдийг мэдээлэхгүй байх хэрэгтэй бөгөөд уг асуудлын бодит шийдлийг хичээлийн төгсгөлд авч үзэж болно. Гэхдээ зарим тохиолдлоос хамаарч тухайн өгөгдлийн шийдлийг хэлээд зөв, эсвэл буруу шийдэл болох талаар хэлэлцүүлж болох юм. Хүүхдүүдийн анхаарлыг бодит баримтын учрыг олоход чиглүүлэх хэрэгтэй.

Багш жишээгээр авсан кейс тохиолдлын үйл явдлыг сайн ойлгуулах тодруулж тайлбарлаж өгөх хэрэгтэй. Бүх хүүхэд нэг ижил баримтад тулгуурлах ёстой бөгөөд тэднийг идэвхтэй ажиллах боломж олгохын тулд багш сургалтын явцад хүүхдүүдийг идэвхжүүлэхэд анхаарч байх нь маш чухал юм.

Үүний хамт уншлагын дадал суугаагүй суралцагчдад ч энэ үе нь их ач холбогдол, нөлөөлөлтэй байдаг. Багш өөрөө болон хүүхдүүдээр өөрсдөөр нь асуулт бэлдүүлж болно. Хүүхдүүд хэрэгтэй мэдээллээ авч тохиолдлыг тал бүрээс нь сайн судалж, ойлгосны эцэст шийдэл гаргах үйл ажиллагаандаа орно. Хүүхдүүд мэдээллээ боловсруулан тохиолдлоо ойлгосны үндсэн дээр шийдэх бөгөөд ийнхүү шийдвэр гаргах үйл явцыг багш ямар ч аргаар зохион байгуулж болно.

Багш сэдэвтэй холбоотой ангид тохиолдсон бодит зүйл болон хүүхдүүдэд сургамж авахаар баримтууд цуглуулан асуулт хариултын хувилбартай бэлтгэнэ.

Загвар 1: Кейс – 1. Би сайн багш бас ...

Дорж нэгэн дунд сургуулийн багш. Тэр сүүлийн үед сайн багшийн тоонд орж байлаа. Тэрээр сүүлийн хэдэн жил 7-р ангид математикийн хичээл орж байгаа. 7б ангийн Бат гэдэг хүү тооны хичээлдээ сайн хүүхдүүдийн тоонд ордог. Дорж багшийгаа хүү маш их хүндэлдэг, Дорж ч Бат хүүд сайн ханддаг.

Нэгэн удаагийн Доржийн найдвар тавьж байсан Бат хүү хангалтгүй дүн үзүүлж, багийн үнэлгээнд нөлөөлснөөр хүүг ангийнхны дунд босгож байгаад ...Тэнэг юм уу... гэх мэтээр загнажээ. Хүү эхэндээ толгойгоо илээд зогсож байснаа гэнэт хаалга саван гарч явав.

Энэ тухай Дорж багш хүүг хүмүүжилгүй, итгэлгүй гэх мэтээр багш нарт ярьснаас болж, цөөн хэдэн багш нар түүнийг зэмлэжээ.

Үүнээс хойш Дорж багш ч түүнд таагүй хандаж хүүг үл тоосон царай гаргаж эхлэв.

Бат ч түүний хичээлийг хийхээ больж, ингэх тусам нь багш нь улам л тааруухан дүн тавих болсноор Бат хичээлдээ ч суух нь багасаж, аль л болохгүй гэсэн зүйлийг хийх болжээ.

Хожим хүү сургуулиа төгсөөд ажил амьдралтай болсон ч тэр багштайгаа тааралдсан ч харилцахаа больжээ.

Хэлэлцэх асуудлууд

- Харилцааны зөрчил үүсэхийн эх үүсвэр юу вэ?
- Харилцааны зөрчлөөс үүдэн ямар үр дагавар үүссэн бэ?
- Хэрэв та Дорж багшийн оронд байсан бол яах байсан бэ? Нэг бүрчлэн дурдана уу.
- Энэ тохиолдолд хүүгийн хувьд байдал ямар байх байсан бол? Нэг бүрчлэн дурдана уу.
- Энд багшийн ёс зүйн ямар зарчим зөрчигдөж байна вэ?
- Кейсийг ийнхүү нэрлэх болсны шалтгааныг юу гэж бодож байна вэ? *Чадвар*
- Тодорхой өгсөн баримт эх, кейсын мэдээллийг уншиж ашиглан (үндэслэл, нотолгоо болгох, Загвар баримт татах, тайлбарлах) тухайн асуудлыг тайлбарлаж, шийдвэр гаргаж чадаж байгаа болон бодлого бодох, тохиолдол шийдвэрлэхдээ мэдлэгээ ашиглаж чадаж байгаа байдал
- Амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлж сурч байгаа байдал
- Өөрийн үзэл бодол, байр суурь, үнэлгээ дүгнэлтийг илэрхийлж чадаж байгаа байдал түүнчлэн, илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, байр сууринд хүндэтгэлтэй хандаж, түүнээс үнэ цэнэтэй зүйлийг олж харж, авч чадаж байгаа эсэх багийн гишүүн байх, бусдыг төлөөлөх чадвар, ялгаатай үзэл бодол байр сууринд хандах хандлага, түүнийг хүлээн зөвшөөрч байгаа байдал асуудалд хууль зүйн үүднээс хандаж байгаа байдал
- Бага боловсролын түвшинд уншсан үлгэр юм уу эхээ бүрэлдэхүүн хэсгүүдэд хувааж задлан ялгах, суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд ажилласан кейс тус бүрээ учир шалтгаанаар нь хэд хэдэн хэсэгт хувааж задлан ялгах үйл хийнэ.

Бага, суурь бүрэн дунд боловсролын түвшинд задлан үзсэн хэсгүүдээ тухайлбал бага боловсролын түвшинд яагаад хэн нэгнийг гомдоохгүй туслах нь хүний хийх энгийн наад захын үйлдэл байна гэх мэтээр нийлүүлэн нэг бүхэл болгож ойлгож авч үзэх үйл хийж байна.

Бусад судлагдахуунтай хамтрах боломж

Бага боловсролын түвшинд ангийн багш өөрөө хичээлүүдээ орж байгаа учир Хүн нийгэм, Хүн ба орчин, Иргэний боловсрол, Монгол хэл судлагдахуунтай уялдуулан сургалтын явцад хүүхэд бүрийг оролцуулан хэл яриа болон сэтгэхүйн үйлүүдийг хөгжүүлэх боломжтой болно.

Суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд ангийн багш нийгэм, түүхийн багш нартай хамтран санал болгосон аргуудаар хамтран зохион байгуулж болно.

ХОЁР. ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ АМЬДРАХ АРГА УХААНЫ БОЛОВСРОЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

2.1. Амьдралын аюулгүй байдлыг эрхэмлэдэг, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх соёлыг залуу үед төлөвшүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх

2.1.1. Зорилго: Эрүүл амьдрах гэсэн ойлголтыг бий болгох, ямар орчныг аюултай гэх вэ?, ямар орчныг таатай орчин гэх вэ? гэсэн ойлголтыг бий болгох, биеийн тамир болон биологийн судлагдахуунтай хамтран мэдлэг бүтээлгэх, харьцуулах, зөв мэтгэлцэж сургах сонголт хийх боломжтой болгоход оршино.

2.1.2. Үндсэн ойлголт:

1. Эрүүл хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?
2. Эрүүл монгол хүн нийгмийн баялаг гэдгийг ойлгуулах
3. Эрүүл амьдрах талаар дэлхийн улс орнуудын онцлог хооллох аргын тухай баримт цуглуулан бусдадаа мэдээлэл өгөх боломжуудыг хайх
4. Эрүүл хоол буюу ногоон хүнсний тухай ойлголт бий болгох
5. Өөртөө болон бусдад нийгэмд эрүүл байснаар гарах үр ашгийн тухай ярилцах
6. Таргалалтын талаар шүүмжлэлттэй хандаж өөрсдийн санал бодлыг бүрэн илэрхийлэх
7. Сургуулийн орчин болон сургуулиас гэр хүртэлх замд хүүхдэд аюултай орчин байгаа талаар ахлах ангийн сурагчид судалгаа хийж танилцуулах, өөрчлөх боломжуудыг эрэлхийлэх, сайн үйлсийн аян зохиох
8. Суралцагч, багш нарын хоорондын харилцан бие биеэ хүндэтгэсэн харилцааны талаар ярилцах
9. Мэргэжил сонголт нь яагаад эрүүл аюулгүй аж төрөх ёстой холбоотой болох талаар мэтгэлцээн өрнүүлэх
10. Суурь бүрэн дунд боловсролын түвшинд суралцаж байгаа хүүхдүүд бага ангийн хүүхдүүдийн аюулгүй эрүүл орчинд өөр өөрсдийнхөөрөө үнэлгээ хийж өөрсдөд нь мөн энэ эрсдэл таарч болох талаар санал солилцох

2.1.3. Үйл ажиллагаа

а. Бага боловсролд

- Биеийн тамирын хичээлийн анхны өдрөөс олгох дасгал хөдөлгөөн яагаад хэрэгтэй, яагаад биеийн тамирын хувцас сольж өмсөх шаардлагатай талаар биеийн тамирын багш, эцэг эхтэй хамтран энгийн анхан шатны ойлголт бий болгох, хэрэгжүүлж хэвшүүлэх
- Шүдээ, гараа яагаад угаах ёстой талаар хүүхдүүдтэй ярилцах
- Дасгал хийх үед болон бусад үед хэрхэн хооллох талаар ярилцах жижиг жүжигчилсэн тоглолт хийж үзүүлэх
- Дасгал хөдөлгөөн хийж сурах үндсэн ойлголт өгөх, дасгал хөдөлгөөн хийхийн ач холбогдлыг ойлгуулах

б. Суурь боловсролд

- Улиралд тохируулан хувцаслах, хооллох, унтах амрах цаг яагаад баримтлах талаар хүүхдүүдийг баг болгож мэдээлэл бэлдүүлэн шүүмжлүүлэх, санал дэвшүүлэх, дүгнэх үйлүүд хийлгэх.
- Биеийн тамир, биологийн багштай хамтран охид хөвгүүдийн биед гарч буй өөрчлөлт нь физиологийн хувьд ямар өөрчлөлтүүд болох ачаалал, хооллолт, хувцаслалтад яагаад эцэг эх нь анхаарал тавьж шүүмжлээд байгааг ойлгуулах чиглэлээр мэдээлэл өгөх, хамтран шийдвэр гаргах боломж хайх
- Дасгал хөдөлгөөн тогтмол хийж туршиж ач холбогдлыг нь өөрөөр нь дүгнүүлэх.

в. Бүрэн дунд боловсролд

- Эрүүл байхын ач холбогдол, дасгал хөдөлгөөн тогтмол заавал хийж хэвших шалтгаан, өөрт тохируулан хооллох сонголт хийх чадвартай болох.
- Физиологийн хувьд насанд хүрэгчидтэй адил болох хөгжил явагдаж байгааг биологи, биеийн тамирын багштай хамтран ойлгуулах.
- Биеийн онцлогт тохирсон дасгалыг сонгож ачааллаа тохируулан спортоор хичээллэх, сонгох чадвартай болох.

2.1.4. Арга зүй

Чиглүүлэгтэй уншлага:

Багш өөрийн бэлдсэн сургамжтай зохиол ба мэдээлэл бүхий текстийг уншиж, ойлгуулах боломжтой энэ аргыг **Мэдлэг бүтээх** үед ашиглаж болно.

Хүүхдүүдэд зохиол, мэдээллийн текстийн гол санааг ойлгуулах, утгыг нь ангийнхаа хүүхдүүдтэй ярилцах боломжтой арга юм.

Энэ аргыг 8-25 хүүхдүүдтэй ангид хэрэглэхэд илүү зохимжтой байдаг ба түүнээс олон бол хүүхдүүдийн оролцоо буурах сул тал байж болно.

Хугацаа: 30-40 минутад зохион байгуулалт хийж ашиглаж болох ба заавал 1 удаа бүх зүйлийг хийх шаардлагагүй хэд хэдэн хэсэгт хувааж сурах хүртэл нь бага багаар хийлгэж болно.

Сурагчдын хийх үйл ажиллагаа

Алхам 1: Эхний үед хүүхдүүдийн сонирхлыг төрүүлэх, идэвхжүүлэх боломжтой сэдвээр хүүхдүүдийн өмнөх мэдлэг, мэдээллийг сэргээх, сэдвийн түлхүүр үгтэй танилцуулах ойлгуулах ажлуудыг хийнэ. Түлхүүр үгээ унших эх болон зохиол, үлгэрийн гол санааг зургаар илэрхийлэн түүнээс хүүхэд гол түлхүүр үгийг тааварлан олох дасгал байж болно.

Алхам 2: Энэ аргыг хэрэглэхийн өмнө багш урьдчилан зохиол, эх, үлгэр, текстийг гол гол утга санаагаар нь хэсгүүдэд хуваасан байна. Мөн хэсэг бүрийн гол санааг нь ойлгуулахад дөхөм болох асуултыг урьдчилан бэлтгэнэ.

- Зохиол, эх, үлгэр, текстийг хүүхдүүд тэмдэглэсэн хэсэг хүртэл зогсолттой уншина.
- Хүүхдүүд зохиол, эх үлгэр, текстийг чимээгүй уншаад багшийн асуултад хариулт өгнө.
- Хүүхдүүд хариулахдаа зохиол, эх үлгэр, текстийн тохирох хэсгийг уншиж баталгаажуулна.

Алхам 3: Хүүхдүүд ойлголтоо баталгаажуулж, улмаар шинэ мэдлэг, мэдээллээ хэрэглэх бололцоо олгох дасгалыг багш хүүхдүүдээр байнга хийлгэж хэвшүүлэх нь гэрийн даалгавраа бие дааж хийх боломж олгодог тул гэрийн даалгавар заавал өгч маргааш нь заавал шалгаж хэвшүүлэх нь хүүхдийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах ба бусад багш нар бүгд даалгавар өгч байгаатай уялдуулан холбож өгөх нь бие даах боломжийг олгоно.

2.2.Хүүхдийг идэвхтэй, эрүүл амьдралын хэв маягт сургах, эрүүл хоол хүнс хэрэглэхийн ач холбогдлыг таниулахад чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

2.2.1. Үйл ажиллагаа

а.Бага боловсролд

- Ямар зүйлийг аюул гэх вэ?, ахуйн осол, аюул юунаас болж үүсдэг, амьдарч буй орчинд эргэн тойронд ямар зүйл аюултай байж болохыг ойлгуулах (Цахилгааны тог дамжуулдаг утаснаас болон хөл бөмбөгийн талбай дээр хүүхэд амь эрсэдсэн аюулыг жишээгээр ярьж үзүүлэн ойлгуулах)

б.Суурь боловсролд

- Амьдрах орчны аюулгүй байдлаас илүү сэтгэл санааны аюулгүй байдал гэж ямар ойлголт болохыг нийгмийн ажилтантай хамтран хэлэлцүүлэг хийж таниулах,
- Эцэг эх багш ойр дотны хүмүүс яагаад өөрт нь санаа тавьж байгаа нь өөрт нь дарамт юм шиг бодогдож байгааг жишээгээр харьцуулан ойлгуулах, хэнийг хамгийн сайн найз гэх вэ гэсэн сэдвээр маргаан зохиох, хэлэлцүүлэг хийх

в.Бүрэн дунд боловсролд

- Өөрийн аюулгүй байдлаа хэрхэн бий болгож амьдрах, энэ нь ирээдүйд мэргэжлээ хэрхэн зөв сонгох, найз нөхдөө зөв сонгохоос эхлэлтэй талаар эцэг эхийн төлөөлөл болон амжилттай яваа болон жирийн хүмүүстэй ярилцлага хийх замаар ойлгуулах
- Өөртөө болон бусдад аюулгүй аж төрөх боломжийн тухай сонголттой мэдээлэл цуглуулан мэтгэлцэх урлагт сургах

2.2.2. Арга зүй

Чиглүүлэгтэй уншлага – Сэтгэн бодохуйн дасгал

Энэ нь эх зохиол уншиж ойлгоход хүүхдүүдэд их тустай арга юм. Уг арга нь “Чиглүүлэгтэй уншлага”-ын аргатай төстэй боловч чиглүүлэх асуултууд илүү чөлөөтэй байх бөгөөд текстийг бүрэн ойлгохыг чухалчилдаггүйгээрээ ялгаатай юм. Сурагчид “Чиглүүлэгтэй уншлага”-ын аргыг сайн эзэмшсэний дараа уг аргыг хэрэглэхэд илүү хялбар байх ба бие даан таамаглал дэвшүүлэх боломжийг сурагчдад олгодог онцлогтой арга юм.

Хэрэглэгдэхүүн: Текстийг сурагчдын тоогоор олшруулах ба тэмдэглэл хийх цаас ба үзгээ сурагчид бэлтгэсэн байна.

Хугацаа: Дасгалыг 15-30 минутад гүйцэтгэнэ.

Сурагчдын хийх үйл ажиллагаа

Алхам 1: Текстийг дөрвөөс таван хэсэгт хувааж тэмдэглэнэ. Зогсолт хийх хэсэг нь текстийн гол утга санааг илэрхийлэх хэсгүүдтэй давхцахаар тааруулна.

Алхам 2: Самбарт эсвэл самбарын цаасан дээр доор өгсөн хүснэгтийг зурж бэлтгэнэ. Сурагчдад текстийг зогсолттойгоор хэсэгчлэн уншина гэдгийг тайлбарлаж хэлнэ. Текстийн дараагийн хэсгийг уншихгүй байхыг тэдэнд анхааруулна. Текстийн хэсэг бүрийн дараа цааш ямар үйл явдал өрнөх талаар сурагч бүр өөртөө таамаглал дэвшүүлсний дараа дараагийн хэсгийг уншина.

Алхам 3: Сурагчид зохиолын нэрийг буюу сэдвийн гарчиг, зохиогчийн нэрийг уншина. Номын хавтасны зургийг үзэх ба номын нэрийг уншина. Үүний дараа энэ зохиолд юуны тухай өгүүлэх саналыг нь багш сурагчдаас асууна. Сурагчдын санааг “Юуны тухай өгүүлэх вэ?” хүснэгтэд багш тэмдэглэнэ. Сурагчдаас яагаад ингэж бодож байгаа талаар нь лавлаж хариултуудыг “Яагаад?” хүснэгтэд бичнэ.

Алхам 4: Одоо сурагчдаас текстийн эхний хэсгийг уншихыг хүснэ. Зогсолт хийх хэсэгт хүрмэгцээ өөрсдийн дэвшүүлсэн таамаглалыг зохиолын хэсэгтэй харьцуулна. “Зохиолд өгүүлсэн зүйл?” хүснэгтэд сурагчдын хариултыг багш тэмдэглэнэ.

Алхам 5: Багш сурагчдын дэвшүүлсэн таамаглалыг уншиж өгөх ба аль нь зохиолын үйл явдалтай тохирсон болохыг ярилцана. Түүнчлэн сурагчдаас таамаглалыг зөв болохыг харуулсан зохиолын хэсгийг уншиж өгөхийг хүснэ.

Алхам 6: Одоо зохиолын дараагийн хэсэгт юуны тухай өгүүлэх талаар сурагчид таамаглал дэвшүүлж “Юуны тухай өгүүлэх вэ?” хүснэгтэд бичнэ. Харин “Яагаад” хүснэгтэд сурагчдын нэрлэж буй шалтгаануудыг тэмдэглэнэ. Сурагчид текстийн дараагийн хэсгүүдийг чимээгүй бие даан унших ба хэсэг бүрийн дараа өөрийн таамаглалаа зохиолын үйл явдалтай харьцуулж үзнэ. Энэ мэтээр зохиолыг сурагчид бие даан уншиж дуусгана.

Алхам 7: Төгсгөлд нь “Зохиолд өгүүлсэн зүйл?” хүснэгтэд сурагчдын хариултыг бичих ба хичээлийн эхэнд дэвшүүлсэн таамаглалуудыг зохиолд өгүүлсэн үйл явдалтай харьцуулж үзнэ.

Чиглүүлэгтэй уншлага ба сэтгэн бодохуйн дасгал арга

	Юуны тухай өгүүлэх бол?	Яагаад?	Зохиолд өгүүлсэн нь?
Зохиолын нэр, гарчгийг уншсаны дараа			
Эхний хэсгийг уншсаны дараа			
Хоёр дугаар хэсгийг уншсаны дараа			

2.3. Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй амьдрах ухааны боловсрол олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

Хичээлээс гадуурх сургалтын энэхүү агуулгын хүрээнд БСШУС-ын сайдын 2018 оны А/181 тоот тушаалаар баталсан “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр, тус оны А/467 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэнд” хичээлийн хөтөлбөр зэргийг харгалзан танхимын болон танхимаас гадуур хэлбэрээр сургуулийнхаа онцлогтой уялдуулсан үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж болно. “Эрүүл мэнд” хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх албан ёсны цаг сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байдаг учир тухайн хөтөлбөрийн агуулгаар эзэмшсэн мэдлэгээ амьдралд хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг танхимын бус

орчинд зохион байгуулж болох юм. Тухайлбал, “Эрүүл мэндэд сурагчийн оролцоо” зэрэг сурагчдын өөрийн удирдлагын клуб байж болно.

А. Эрүүл мэнд сурагчийн оролцоо

2.3.А1.Зорилго:

- Эрүүл мэндийн хичээлээр эзэмшсэн мэдлэгийг бодит амьдрал дээрх үйл ажиллагаатай уялдуулан холбох
- Эрүүл байх арга замуудыг сурталчлах, дэмжих чадвар, дадал эзэмшүүлэх
- Хамтдаа сурч, хамтдаа хөгжихөд чиглэгдэнэ.

2.3.А2.Үйл ажиллагаа:

Бага боловсролд

- Эрүүл ахуйн зөв дэглэм баримтлах
- Өөрийгөө болон бусдыг хүндэтгэх
- Эрүүл зан үйлд суралцах

Суурь, бүрэн дунд боловсролд

- Өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг дэвшүүлэх
- Өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалахад хариуцлагатай хандах

Бага боловсролын түвшинд сурагчдын өөрийн удирдлагын клуб байх шаардлагагүй ба багшийн удирдлага дор сурагчид хамтран эрүүл мэндийн мэдлэг, дадал, чадварыг бусдад түгээх, үлгэр дуурайл болох үйл ажиллагааг зохион байгуулна. Мөн холбогдох тэмдэглэлт өдрүүдийг угтсан үйл ажиллагаа зохион байгуулж болно.

Суурь, бүрэн дунд боловсролын түвшинд сургуулиуд сурагчдын өөрийн удирдлагын клуб, бүлгэм ажиллуулах нь илүү тохиромжтой.

2.3. Арга зүй

А. “Эрүүл мэндэд сурагчийн оролцоо” сурагчдын өөрийн удирдлагын клуб

Сургууль дээрх сурагчдын өөрийн удирдлагын клуб нь өөрсдийн боловсруулсан төлөвлөгөөтэй байна. Клубын гишүүд нь үйл ажиллагааны төлөвлөлтдөө орон нутаг, сургуулийнхаа онцлогт тохирсон бусад хүмүүсийн дэмжлэгтэй зохион байгуулах үйл ажиллагаанаас гадна сурагчид өөрсдийн санаачилгаар зохион байгуулах үйл ажиллагааг тусгах хэрэгтэй. Клубын үйл ажиллагаанд олон хүмүүсийг татан оролцуулах нь нэг талаас сурагчдад сонирхолтой байхын зэрэгцээ ажлын цар хүрээг өргөжүүлэх, нийтэд хүргэхэд тустай.

Зохион байгуулах үйл ажиллагааны сэдэв, агуулгыг сонгохдоо тухайн сэдэв нь ач холбогдолтой, чухал байх, хийж хэрэгжүүлэхүйц байх, сурагчдын сонирхол хэрэгцээнд нийцсэн байхыг анхаарах хэрэгтэй.

Үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтад дараах алхам, үе шатыг харгалзана.

- Үе тэнгийн сурагчид, өсвөр үеийнхний эрүүл мэндэд тулгамдсан асуудлаас зохион байгуулах үйл ажиллагааны сэдэв, агуулгыг сонгох
- Үйл ажиллагааны зорилго, зорилтыг тодорхойлох
- Холбогдох мэдээлэл цуглуулах, боловсруулалт хийх
- Үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжүүлэх
- Үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэх, тайлагнах
- Дараагийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтэд анхаарах зүйлсийг тодорхойлох

Б. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр

2.3. Зорилго: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, эрүүл аюулгүй амьдрах чадварт сургахад чиглэнэ.

2.3.Үндсэн ойлголт

Орчны аюулгүй байдал:

- Ахуй орчны аюулгүй байдал
- Нийгмийн орчны аюулгүй байдал

Гамшиг, осол, аюулт үзэгдэл

- Байгаль, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл
- Хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл

2.3. Үйл ажиллагаа:

Бага боловсролд

- Сурагч тохиолдож болзошгүй аюул, ослын төсөөлөлтэй болох
- Урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах, шийдвэр гаргах оновчтой үйл хөдлөл хийх

Суурь боловсролд

- Сурагч болзошгүй аюулт үзэгдэл, ослыг төсөөлөх
- Аюулгүй байдлын бэлтгэлтэй байх, өөрийгөө хамгаалах
- Бусдад туслах, анхны тусламж үзүүлэх
- Аюулгүй зөв сонголт бүхий үйл хөдлөл хийж чаддаг болох

Бүрэн дунд боловсрол

- Сурагч болзошгүй аюулт үзэгдэл, ослыг төсөөлж хариу арга хэмжээ авах
- Анхны тусламж үзүүлэх, сайн дурын үйл ажиллагаанд оролцох
- Дасан зохицож амьдрах чадвартай, амьдралын зөв дадал хэвшилтэй болох

Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн агуулгын ерөнхий ойлголтуудыг танхимд зохион байгуулж болох ба харин гамшгаас хамгаалах дадлага сургуулилалтыг танхимаас гадуур байгаль, нийгэм, соёлын орчинд хэрэгжүүлэх бүрэн боломжтой юм. Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлэхдээ бусад хичээл, судлагдахуутай интеграцчилан хэрэгжүүлэх агуулга, хичээлээс гадуурх сургалтын ажлын хүрээнд хэрэгжүүлэх боломжтой агуулгыг судалж, сургуулийнхаа менежмент болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулна.

2.3. Арга зүй

Загвар 1: Бага боловсролын түвшинд /3-5 анги/

Үйл ажиллагааны нэр: Гамшгийн үед хоол хүнс, ус зэрэг наад захын хэрэглээний зүйл дутагдах нөхцөл байдал бий болдог. Энэ үед хэрэглэх хүн нэг бүрийн үүргэвчинд юу байх талаар эргэцүүлэн бодуулах цаашид гэр бүлийнхэнтэйгээ ярилцах, бодитоор бэлтгэл ажлыг хангуулахад тустай үйл ажиллагаа

Зорилго: Гамшгийн үед хэрэглэх цүнх (үүргэвч)-д юу байх талаар эргэцүүлэх (хүн нэг бүрийн үүргэвч)

Сурагчдын хийх үйл ажиллагаа:

- Өглөөнөөс орой унтах хүртэлх нэг бүтэн өдрийн турш хэрэглэсэн зүйлийг жагсаан бичих
- Жагсаан бичсэн зүйлийг хэрэглэж чадахгүй нөхцөлд ямар бэрхшээл тулгарах талаар эргэцүүлэн бодох, санаагаа хуваалцах
- Хүн нэг бүрийн үүргэвчинд зайлшгүй байх 5 зүйлийг эрэмбэлэн тэмдэглэх
- Бусдадаа эдгээр 5 зүйлийг яагаад үүргэвчинд байхаар сонгосон шалтгааныг тайлбарлах
- Өөрийн сонголтдоо бусдынхаа сонгосон зүйлстэй харьцуулан бүх хүний нийтлэг хэрэглэдэг зүйл, хувь хүнд хэрэгтэй зүйл байдаг эсэх талаар ойлголттой болох
- 3 өдрийн хүнс, усны хэмжээг тооцоолон гаргах

Багшийн анхаарах зүйл: Сурагчид өөрийн өдөр тутмын хэрэглээг харгалзан 3 өдрийн хүнс, усны хэмжээг тооцоолон гаргаж байгаа эсэхийг анхаарч чиглүүлнэ.

Нэмэлт мэдээлэл:

Хүн нэг бүрийн үүргэвчид байвал зохих зүйлсийн жагсаалт¹-д ус, хатаасан болон лаазалсан хүнс, сонин, харандаа, цаас, бээлий, ороолт, дулаан хувцас, гар чийдэн, лаа, чүдэнз, шүгэл, хувийн бичиг баримт, иж бүрэн эмийн хайрцаг, жижиг радио хүлээн авагч зэрэг багтдаг байна.

Суурь боловсролын түвшинд:

Үйл ажиллагааны нэр: **Анхны тусламж**





Зорилго: Бусдад анхны тусламж үзүүлэх аргачлалд суралцана.

Орчин: Танхимаас гадуурх сургалт

Арга зүй:

Тухайн үйл ажиллагааг багш, ажилтнууд, сувилагч гэх мэт бусад мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар зохион байгуулна.

Биеийн тамирын талбай зэрэг зай, талбайтай газарт анхны тусламжийн хэд хэдэн өртөө байгуулна.

<p>Өртөө 1. Зүсэгдэн, зулгарч цус алдах үеийн анхны тусламж</p>		<ul style="list-style-type: none"> - Бугалгаас цус алдвал мөрний дунд дотор талаас нь судсыг мөр рүү дарна. - Гарын шуу, хуруунаас цус алдвал шуун дээрх хоёр судсыг дарна. - Шилбэнээс цус алдвал өвдөг дээрх судсыг дарна. - Гуянаас цус алдвал гуяны судсыг аарцагны яс руу шахаж дарна.
<p>Өртөө 2. Яс хугарах үеийн анхны тусламж</p>		<ul style="list-style-type: none"> - Ил болон битүү хугаралтын аль алинд нь (<i>цус тогтоож, ариутгаасан боолт тавьсны дараа</i>) эмч иртэл гэмтсэн мөчийг хөдөлгөөнгүй байлгана. Энэ нь өвдөлтийг багасгаж, хугарсан ясны цаашдын шилжилтийг зогсоодог. - Хөдөлгөөнгүй байлгахын тулд бэлэн чиг баригч болон саваа, банз, шугам, фанерийг ашиглана. Битүү хугаралтын үед өвчтний хувцсыг тайлах хэрэггүй ба чиг баригчийг хувцас дээр шууд тавих хэрэгтэй. - Өвдөлтийг багасгахын тулд бэртсэн газар хүйтэн жин тавих шаардлагатай.
<p>Өртөө 3. Зүрх, амьсгалын эрхтний сэргээн амьдруулалт</p>		
<p>Өртөө 4. Нарших үед авах арга хэмжээ</p>		<ul style="list-style-type: none"> - Буцалсан усыг хөргөөж задгай саванд хийж наранд халаагаад уг усаа уух буюу толгой биеийг угааж шавших, шингэн уух - Дээрх шинж тэмдэг илэрвэл эмчид яаралтай хандаж үзүүлж, зөвлөгөө авах - Нарнаас хамгаалж гэртээ чийгтэй сэрүүн орчин бүрдүүлэх - Хэрэв халуурвал хүйтэн жинг толгой, шилэн хүзүү орчимд тавьж халуунаа бууруулах; - Хоол унд хорихгүй учраас шим тэжээлтэй хоол идэх нь зүйтэй

Сурагчдын хийх үйл ажиллагаа: Сурагчид багт хуваагдан хугацааг товлон, дарааллаараа өртөөгөөр тойрон явна.

- Анхны тусламжийн хэрэгцээ, шаардлага, зорилгыг ойлгох
- Өртөөгөөр тойрч анхны тусламжийн аргачлалд суралцах, туршилт хийж үзэх
- Сурч авсан зүйлсийн талаар багаараа ярилцах өөрт төрсөн сэтгэгдлээрээ илэрхийлэн бичих, ярих

Анхаарах зүйл: Өртөө тус бүрээр аялах үед өртөө хариуцсан ажилтан анхны тусламжийн хэрэгцээ шаардлага, зорилгыг тайлбарлана. Ялангуяа гамшгийн үед хүнд өвчнүүдийг эмнэлэгт хүргэх, хөнгөн гэмтэлтэй бол хэрхэн арга хэмжээ авах талаар мэдээлэл өгнө. Мөн гарын доорх материалаар эмнэлгийн тусламж үзүүлэх аргуудыг бодитоор турших дадлага хийнэ. Тухайлбал,

Зүсэгдэх, зулгарах үед - Усаар угаах, хүнсний скочоор ороох, уяа ашиглан цус тогтоох, боолт хийх, Яс хугарах үед- Борооны шүхэр, сонин, сэтгүүл зэргээр чиг барьж скоч, уяа зэргээр боох, сойлт хийх, Булгалах үед- Нийлэг уутанд мөс хийж хүйтэн жин тавих

ГУРАВ. БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

3.1. Хүүхдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг эрчимжүүлэх

3.1.1. Зорилго. ЕБС-ийн суралцагчдад болзошгүй эрсдэл, зөрчил гэж юуг ойлгох, зөрчил, хүчирхийлэл үйлдэгдэн гарахад нөлөөлж байгаа шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга, хувь хүний хариуцлагын талаар анхан шатны мэдлэг эзэмшүүлэхэд оршино.

3.1.2. Үндсэн ойлголт

- Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголт
- Хүүхдүүд өөрсдийгөө хүчирхийллээс хамгаалахын тулд аюулгүйн дүрмийг баримталж сурах, түүнчлэн дүрмийг уншиж, хэвшүүлэх талаарх ойлголт
- Сургууль, нийгмийн орчинд өөрийгөө болон найз нөхдийгөө эрсдэлээс хамгаалах, сонирхол хэрэгцээндээ тулгуурлан болзошгүй эрсдэл, зөрчилд орох, түүний золиос болохгүй байх талаарх мэдлэг ойлголт
- Оролцогчдод аливаа зөрчлийг шийдвэрлэдэг гол хэрэгсэл нь хууль байдаг хуулийг дагаж мөрдөхийн ач холбогдол, иргэн хэдэн насандаа ямар үйлдлийг хийж болох ба болохгүй тухай хуулийн заалтууд, иргэний хүлээх үүрэг, хариуцлагын талаарх мэдээлэл
- Суралцагчдад аливаа зөрчлийг шийдвэрлэдэг гол хэрэгсэл нь хууль бөгөөд хуулийг дагаж мөрдөхийн ач холбогдол, олон нийтийн дунд биеэ зөв авч явах чадвар хандлага

3.13. Үйл ажиллагаа

Үндсэн үйл ажиллагааг суралцагчдад болзошгүй эрсдэл, зөрчил, хууль эрх зүйн талаар мэдээлэл өгч, хэлэлцүүлэг, хэлбэрээр зохион байгуулна. Хэлэлцүүлгийг хэрхэн зохион байгуулах талаар дараах жишээг санал болгож байна.

3.1.4. Арга зүй

Загвар 1. Нийгмийн харилцаа хэлэлцүүлэг

Үйл ажиллагаа:

Алхам 1. Дараах хүснэгтийг дэлгэцээр үзүүлж асуулт дэвшүүлэн ярилцана.

а	в	с
Идэр найз нартаа үргэлж худлаа ярьдаг нь батлагджээ.	Сурагч Цэвэл 11 цагийн хичээлийг шалтгаангүй тасалсан нь нотлогджээ.	Иргэн Бадарч саахалт айлын сүрэг адууг хулгайлаад баригджээ.

Асуулт :

- А, В, С хүснэгтэд байгаа тохиолдлууд ямар ялгаатай вэ ?
- Ижил төсөөтэй зүйл байна уу? гэсэн асуултад ширээний найзтайгаа ярилцан хариулах даалгавар өгнө.
- Хэсэг хугацааны дараа 2–3 хосын хариултыг сонсож хэлэлцээд гурвуулаа зөрчил мөн үүгээрээ төсөөтэй. Харин ялгаа нь: А– ёс зүйг зөрчсөн, В–сурагчийн дүрмийг зөрчсөн, С–хуулийг зөрчсөн гэсэн нэгдмэл шийдэлд хүрнэ.

Нэмэлт мэдээлэл:

Аль ч улс оронд нийгмийн харилцааг бичигдсэн ба бичигдээгүй хуулиар зохицуулж байдаг. Бичигдээгүй хууль гэдэг нь эрт үеэс уламжлан ирсэн зан заншил, ёс зүйн үйлтэй холбогдон бий болсон хэм хэмжээнүүд байдаг бол бичигдсэн хууль нь дүрэм, журам, хуулиар боловсрогдон хэрэгждэг.

Загвар 2. Хуулийн мод

Үйл ажиллагаа:

- Багш одоо бүгдээрээ хуулийн мод зурцгаая.
- Та нар хуулийг мод гэж төсөөлөөд өөрийн мэддэг хуулиа модныхоо мөчирт байрлуулаарай.
- Ямар хууль хаана хаана байрлах вэ ? Яагаад?
- Оролцогч бүр хуулийн мод зурж, бие биедээ тайлбарласны дараа багш самбарт томоор зурсан хуулийн модыг нааж үзүүлнэ.
- Энэ мод та нарынхаас ямар ялгаатай байна, Үндсэн хууль яагаад модны үндэс нь болдог вэ ? гэж асууна.
- Аливаа улсын гол хууль нь үндсэн хууль байдаг ба бусад хууль түүнд нийцэж гарах ёстой.
- Хуулийг яагаад заавал дагаж мөрдөх ёстой вэ?
- Түүний ач холбогдлыг энэ алимны дүрсэн дээр бичиж самбарт байгаа модонд наахыг хүснэ.
- Алимны дүрсүүд дэх бичвэрийг уншиж танилцуулаад дүгнэлтийг мэдээллээс авч сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулан тайлбарлана.

Нэмэлт мэдээлэл

Хүн бүрийн дагаж мөрдөх ёстой дүрэм, журмыг багтаасан баримт бичгийг хууль гэнэ. Хүүхэд та нар төрмөгцөө тухайн улсын иргэнд тооцогдох, овог нэр, төрсний гэрчилгээ авч иргэний бүртгэлд бүртгэгдсэнээр хуультай холбогдож хуулиар хамгаалагддаг. Хүний эрхийг хамгаалах, шударга ёс, дэг журмыг тогтоох, аливаа зөрчил маргааныг шийдвэрлэх шаардлагатай олон асуудлыг зохицуулах зорилгоор хууль боловсруулж улс орны амьдралд эмх замбраагүй байдал үүсэхээс хамгаалж байдаг. Хуулийг боловсруулахдаа:

- Үг өгүүлбэр нь алдаагүй, зөв бичигдсэн байх
- Товч тодорхой ойлгомжтой байх
- Бусад хуультай зөрчилдөхгүй байх
- Хэрэгжүүлэх боломжтой байх
- Зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь тодорхой, тохирсон байх г.м дүрмийг сахихыг шаарддаг.

Хуулийг үндсэн хууль, ердийн хууль буюу бусад хууль гэж ангилдаг. Үндсэн хууль нь бусад бүх хуулийн эх сурвалж, үндэс нь болж төрийн дээд байгууллагууд, тэдгээрийн бүрэн эрх, хувь хүн, төр хоёрын хоорондын харилцааг тодорхойлж байдаг бол бусад хууль нь үндсэн хуулийн үзэл санаанд нийцэн боловсрогдож тухайн салбар эрх зүйн харилцааг зохицуулдаг. Харин хүүхдүүд та нар хүмүүсийн хийж буй ямар үйлдэл түүнд тохиолдож болох асуудлууд маргаантай зүйлийг ямар хуулиар хэрхэн шийдвэрлэж болохыг сайн мэдэж байх нь чухал ач холбогдолтой.

Хүснэгт: Иргэд хэдэн насандаа юуг хийж болох эсвэл болохгүйг хуульчлан зааж өгсөн байдал

Нас	Хийж болох үйлдлүүд, эдлэх эрх хүлээх үүрэг
0-6	Нэр авах Иргэний бүртгэлд бүртгэгдэх Эрүүл мэндийн туслалцаа авах
7-13	Сургуульд орох Талх авах зэрэг ахуйн жижиг худалдаа хийх Эцэг,эхийн зөвшөөрлөөр эд зүйлээ бусадтай солих
14-15	Бусдад хохирол учруулбал өөрөө төлөх, өөрөө төлж чадахгүй бол эцэг эхээрээ төлүүлэх Эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр мэргэжлийн баримжаа олох хөдөлмөр эрхлэх Гэмт хэргийн төрлөөс хамааран эрүүгийн хариуцлага хүлээх Эцэг эхийн хяналтын дор өөрийн мэдлийн эд хөрөнгийг зарцуулах
16-17	Иргэний үнэмлэх авах Эцэг, эхийн зөвшөөрлөөр хөдөлмөр эрхлэх Бусдад хохирол учруулбал өөрөө төлөх, чадахгүй бол эцэг, эх, асран хамгаалагчаараа төлүүлэх Эрүүгийн хариуцлага хүлээх
18 ба түүнээс дээш	Сонгуульд саналаа өгөх Цэргийн алба хаах Гэрлэх Бие дааж хөдөлмөр эрхлэх,арилжаа бизнес хийх Машин жолоодох

3.2. Хүүхдийг шударга ёс, шударга байдал, нинжин сэтгэлийг эрхэмлэдэг, эцэг эх, багш, ахмад үе, үе тэнгийнхнээ болон бусад хүмүүсийг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

3.2.1. *Зорилго.* Оролцогч хүүхэд өөрт ямар нэг гэнэтийн болон таагүй асуудал тулгарсан үед ухаалгаар шийдэж, биеэ авч гарч чаддаг болох, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх, дадал, чадвартай болно.

3.2.2. *Үйл ажиллагаа*

Хүн ёс суртахууныг эрхэмлэж, хууль дүрэм журмыг мөрдөж, дагахын утга учрыг хүүхдүүдэд ойлгуулах

Монгол ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх арга зүйгээс суралцах

Монгол ардын зүйр цэцэн үгсийг ярьж, тайлбарлаж ойлгуулах, хэлэлцүүлэх

Хүүхэд өөрт ямар нэг гэнэтийн болон таагүй асуудал тулгарсан үед ухаалгаар шийдэж, биеэ авч гарч чаддаг болох,

Гэмт хэргээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх дадал, чадвартай болох

3.2.3. *Арга зүй*

Монгол ардын зүйр цэцэн үгсийн утгыг хэлэлцэх

Заавар:

- Оролцогчдод Монгол ардын зүйр цэцэн үгсийг дэлгэцэн дээр бичиж гаргана. Гэхдээ эхний удаад зөвхөн зүйр цэцэн үгсийг бичиж гарган оролцогчдоос энэ үг ямар учир утгыг агуулсан, ямар ач холбогдолтой үг болохыг асууж хэлэлцэнэ.
- Дараа нь багш зүйр цэцэн үгсийг тайлбарын хамт бичсэн дэлгэцийг гарган ийм учир утгатай, утга санааг агуулсан, бидний өвөг дээдсээс уламжилж ирсэн сургаал үгс учраас байнга санаж явахыг хэлж тайлбарлана.

Хэрэглэгдэхүүн:

“Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа” гэдэг үгийн цаана хүүхэд нас бол хүн болохын гол түлхүүр мөн. Мөн хүүхдийн төлөө эрт анхаар, түүнд анхаарал, хөрөнгө хүчийг төвлөрүүлэх нь чухал, эс тэгвэл хүн болох, хүн байх явдал алдагдалд орно гэсэн санаа агуулдаг.

“Өөрөө унасан хүүхэд уйлдаггүй” гэсэн үгийн цаана, эсвэл *“Тэм нь урдаа, гэмшил нь хойноо”* гэдэг үгийн цаана өөрийг нь урдаар мэд, тань, зөв бурууг эрт ялга, мэд, эс тэгвээс өөрөө л хохирно гэсэн утга оршдог.

“Хүн нэрээ, тогос өөдөө” гэдэг үгийн цаана нэр, төр шиг хүндтэй, юугаар ч сольж болшгүй ариун нандин чанар, хадгалж, хайрлаж явах үнэт зүйл байхгүйг, бусдыг ч энэ үүднээс үнэлж хүн чанар гаргаж явахыг сануулсан эрхэм сургаал санаа илэрдэг.

“Нэр хугарахаар яс хугар” гэсэн өөр үг ч дээрх санааг бас өгүүлдэг.

“Эрхийг сурахаар бэрхийг сур” гэсэн үг бол бэлэн бүхэн хүнийг эвддэг, бэрхшээл бүхэн нэгийг сургадаг учир мэдэхгүйг мэддэг, чадахгүйг чаддаг болгодог жам хуулийг танин мэдэхийн чухлыг зөвлөдөг.

“Ажил хийвэл ам тосдоно. Ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал” гэсэн сургамж үгийн утгыг хөдөлмөр л хүнийг хүн болгоно, ажиллаж байж л амьдрал залгана, юмыг хийсэн шиг хийж бай, замын хагаст зогсож болохгүй, үл хөдөлбөл, залхууран хойш суувал хүн өөрөө хохирно гэсэн санаагаар тайлбарлаж болно.

“Сайныг дагавал сарны гэрэл, мууг дагавал могойн хорлол” гэсэн үг бий. Үлгэр дуурайллын гүн утга санаа, ач холбогдлыг тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл сонголтоо зөв хий гэсэн үг юм. Анхааруулгын шинжтэй үгийг шог хошин, ёгт байдлаар илэрхийлэх нь сурагчдад мартахын аргагүй үлдсэн байдаг.

Энэ мэтээр амьдралын түг түмэн үзэгдлийн үүд хаалга бүхэнд нэвтрэн орж удирдамж чиг болдоггүй олон сонгомол үг байдгийг оновчтой олж ажил, амьдралаа хөтлөх нь хүн бүхэнд байгууштай шинж, зөв мэргэн залуур болно.

Гэр орон тохьтой, нэр бүтэн, үг хэл буурьтай, үзэл зөв, үйл бүтээл өгөөжтэй, мэлмий хурц, мэргэжил сайн, чадвар өндөр, сэтгэл цагаан, нэгэндээ ээлтэй, нөгөөд тустай, зөвд дэмтэй, бурууд хатуу, бүгдээр эвтэй л байвал болох нь тэр буюу гэсэн Монгол ардын уламжлалт зүйр цэцэн үгсийг байнга санаж явахыг хүүхдүүдэд ойлгуулах нь чухал юм.

3.3. Өсвөр насныхны дундах дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх сургалт, орчин нөхцөл бүрдүүлэх, зохион байгуулах

3.3.1. Үйл ажиллагаа:

- Сургууль түүний орчныг бүрэн камержуулах, камерийн хяналт, ашиглалтыг сайжруулах
- Анхаарал татсан хүүхдүүдэд хяналт тавьж, эцэг эх харьяа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, хэсгийн байцаагчид нэн даруй мэдэгдэх /102,108 дугаар утсаар, бичгээр/
- Сургуулийн удирдлагаас эрдмийн баярыг тэмдэглэх, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг эхийн туслалцааг авч тодорхой шинэлэг ажлуудыг эхлүүлэх
- Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан хүүхдийг гэмт халдлагаас хамгаалах, шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх, төрийн болон төрийн бус байгууллага, эцэг эх иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор улсын хэмжээнд хийгдэж буй үйл ажиллагаанд суралцагчдыг хамруулах
- Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, багш нартай оройн цагаар компьютер тоглоомын газруудад хяналт шалгалтыг зохион байгуулах,
- Компьютер тоглоомын газруудыг ажиллуулж байгаа иргэд аж ахуйн нэгжид оройн цагаар бага насны болон ЕБС-ийн сурагчдыг тоглуулахгүй байх талаар мэдэгдэл хүргүүлэх

Загвар хичээл 1

Ээлжит хичээлийн цаг төлөвлөлт-40 минут

Хамрах хүрээ: Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангид суралцагч

Зорилго: Болзошгүй эрсдэл, зөрчил үйлдэгдэн гарахад нөлөөлж байгаа шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга, хувь хүний хариуцлагын талаар сурагчдад анхан шатны мэдлэг эзэмшүүлэхэд оршино.

Зорилт

- Хүний эрх, эрх чөлөө, бусдын эд хөрөнгөд халдсан тохиолдолд хуулин дахь зүйл заалт, учрах гэм хор, хүлээх хариуцлагын талаар зохих мэдэгдэхүүнтэй болох
- Болзошгүй эрсдэл, зөрчилд холбогдож байгаа нь хувь хүний ухамсар, хүмүүжил, хариуцлагатай салшгүй холбоотой талаарх ойлголт
- Өөрийгөө болон бусдыг болзошгүй эрсдэл, зөрчлөөс сэргийлэхэд цагдаагийн байгууллагад мэдээ, мэдээлэл өгөх нь урьдчилан сэргийлэх ажил болох талаарх ойлголт
- Хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлдэг хандлагыг төлөвшүүлэх

Үйл ажиллагаа

- Багш оролцогчдод хандан насанд хүрээгүй хүмүүсийг зөрчил үйлдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөлийг бууруулах ямар арга зам байж болох талаар асуулт тавина.
- Багш ямар нэгэн ургамал буюу мод, цэцгийн аль нэгийг самбарт зурна. Загвар нь: сарнай цэцэг зурсан байна гэж бодъё. Тэгвэл сарнай цэцгийг ургуулах, арчлахад юу юу хамгийн түрүүнд хэрэгтэй талаар оролцогчдоос асууна. Зурсан сарнайг тойруулан нар, ус, агаар, шороо, хөрс, бордоо гэж бичиж таарна.
- Үүнтэй нэгэн адил “Болзошгүй эрсдэл, зөрчил” гэдэг манай нийгэмд бий болсон энэ асуудлыг самбар дээр тойрог хэлбэртэй, тодорхой орон зай болгон төсөөлөн зурж, үүнийг бууруулахад ямар, ямар арга зам байж болох талаар оролцогчдоос асууна. Мэдээж оролцогчид олон зүйлсийг тоочин хэлнэ.
- Хэлсэн зүйлсийг багш “Болзошгүй эрсдэл, зөрчил” гэсэн энэ тойргийн гадна талд байрлуулан сумаар заан бичиж тэмдэглэнэ.
- Энэ дасгалын хүрээнд тойргийн цөм болсон гэмт хэргийг бууруулах ямар арга зам байж болохыг хэлэлцэж ойлголтоо бататгана.
- Энэ дасгалын хүрээнд харилцан ярилцан үнэлэлт дүгнэлт өгнө.

Загвар хичээл 2

Сэдэв: Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хувь хүний оролцоо

Ээлжит хичээлийн цаг төлөвлөлт-40 минут

Хэрэглэгдэхүүн:

1. Сургалтын хөтөлбөр
2. Мэдээллийг 2-3 хувь хувилж бэлтгэнэ.
3. Проектор, дэлгэц, самбар
4. Хүснэгт- оролцогчдын тоогоор
5. А4 цаас оролцогчдын тоогоор

Арга зүй: Оролцогчдыг “А”, “Б” гэсэн 2 баг болгон хуваана. Баг болгон хуваахдаа оролцогчдыг 1, 2-оор тоолуулан хуваахаас гадна өөрсдийнх нь саналаар хувааж болно.

Үйл ажиллагаа:

Дараах хүснэгтийг дэлгэцээр үзүүлж асуулт дэвшүүлэн ярилцана.

“А”	“Б”
Хувь хүн болзошгүй эрсдэл, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ямар аргууд байж болох талаар	Хохирогч болохоос хэрхэн урьдчилан сэргийлэх талаар

Чиглүүлэх асуулт:

- “А” хүснэгтэд хувь хүн болзошгүй эрсдэл, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ямар аргууд байж болох талаар, “Б” хүснэгтэнд хохирогч болохоос хэрхэн урьдчилан сэргийлэх талаар гэсэн 2 ойлголтыг багуудад өгнө.
- Оролцогчдод энэ талаарх ойлголтыг гаргаж, багууд тус тусдаа ярилцаж хариулах даалгавар өгнө.
- Хэсэг хугацааны дараа баг тус бүрээс 2-3 оролцогчийн хариултыг сонсож хэлэлцээд багш өгөгдсөн мэдээллийн дагуу оролцогчдод ойлголтыг тус тусад нь өгч, ялгаатай зүйл болон ижил төсөөтэй зүйлийг тайлбарлан хэлнэ.
- Багуудын оролцогчид өөр өөрийн ажилласан сэдвийн хүрээнд эсрэг багаасаа асуулт тавина.
- Болзошгүй эрсдэл, зөрчилд холбогдохгүй байх арга зам, хувь хүний хүмүүжил, зан төлөв, бусдын нөлөө, хайхрамжгүй, бодлогогүй байдлын эцэст юунд хүргэж болохыг дүгнэж ярих.

Нэмэлт мэдээлэл:

Өсвөр насны хүүхдүүдэд зориулсан аюулгүйн дүрэм

Хүүхдүүд өөрсдийгөө хүчирхийллээс хамгаалын тулд дараах аюулгүйн дүрмийг баримталж сурах хэрэгтэй. Аюулгүйн дүрмийг уншиж, хэвшүүлснийхээ дараа найзууддаа болон дүү нартаа зааж өгөөрэй гэж зөвлөөрэй.

Оройн цагаар ганцаараа битгий яв

Сургууль дугуйлан нь орой харанхуй болсон үед тарсан бол гэр ойр байдаг найзуудаараа хамт яваарай. Мөн аав, ээж, ах, эгчээрээ үргэлж тосуулж байгаарай. Гэртээ ганцаараа хонож байгаа тохиолдолд энэ талаар гэрийнхнээсээ өөр хүнд битгий хэлээрэй. Ганцаар оройн цагаар битгий гар. Танихгүй хүн гэртээ авч ирж хэзээ ч болохгүй. Оройн цагаар лифтэнд цуг суух гэж буй хүн чинь таагүй санагдсан бол хамт битгий суу гэх мэт зөвлөгөөг сануулж байх хэрэгтэй.

Сайн танихгүй хүнтэй битгий яв. Хувийн мэдээллээ битгий өг

Дөнгөж танилцсан шинэ найз эсвэл сайн танихгүй хүн чамд зугаалах санал тавьбал эелдгээр татгалз. Мөн тэдэнд нэр, гэрийн хаяг, нас, сургууль, анги, утасны дугаар зэрэг хувийн мэдээллээ өгч болохгүй. Ганцаараа мөн найзуудтайгаа явж байсан ч танихгүй хүний машинд хэзээ ч битгий суу.

Үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтээс өөрийгөө хамгаал

Хүүхэд бүр аюулгүй орчинд амьдрах эрхтэй учир хэнийг ч битгий дарамтал, бүү дээрэлх. Үе тэнгийнхэн чинь чамайг дарамталж дээрэлхвэл өөрийгөө хамгаал, тусламж ав. Хэн нэгэн хүүхэд дарамтлуулж, дээрэлхүүлж байхыг харвал тусламж дууд

Аюултай нөхцөлд орвол тусламж дууд

Шаардлагатай нөхцөлд бусдаас тусламж гуйхад ичих зүйл байхгүй гэдгийг санаарай. Өөрийгөө хүнд нөхцөлөөс аврах энгийн арга бол хүмүүсийн анхаарлыг өөртөө татаж, чанга орилох явдал юм. Чанга орилоход хүмүүс чамайг аюулд орсон гэдгийг шууд мэдэх болно. Гадаа гудамжинд явж байгаад аюулд учирвал, ойр орчимд байгаа том хүмүүсээс тэр дундаа хүүхэдтэйгээ яваа хүмүүсээс тусламж хүсээрэй. Хүүхдийн тусламжийн 108 утас нь зөвхөн хүүхдэд зөвлөгөө мэдээлэл, тусламж үзүүлэх зорилгоор 24 цагийн турш үнэ төлбөргүй ажилладаг утас юм. Тиймээс хүүхдүүд та нар өөрт чинь, найз нөхөд эсвэл хэн нэгэн хүүхдэд тусламж шаардлагатай байгааг мэдвэл 108 утсанд хандаарай.

Аав ээжээсээ нуух нууц гэж байхгүй.

Чамд ямар нэгэн асуудал тулгарвал аав, ээж хоёроосоо нууж хэзээ ч болохгүй. Аав ээж чинь чамайг хэнээс ч, юунаас ч хамгаалах үүрэгтэй гэдгийг санаарай. Чи аав ээждээ хэлэхгүй бол тэд чамд тусламж хэрэгтэй байгааг мэдэхүй.

Өсвөр насны хүүхдүүдэд зориулсан аюулгүйн дүрэм

Хүүхдүүд өөрсдийгөө хүчирхийллээс хамгаалахын тулд дараах аюулгүйн дүрмийг баримталж сурах хэрэгтэй. Аюулгүйн дүрмийг уншиж, хэвшүүлснийхээ дараа найзууддаа болон дүү нартаа зааж өгөөрэй гэж зөвлөөрэй.

3.4. Замын хөдөлгөөний дүрмийг сурталчлах, таниулах

3.4.1.Зорилго: Суралцагчдад замын хөдөлгөөний дүрмийн анхан шатны мэдлэг олгох, авто тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх анхан шатны ойлголттой болох

3.4.2.Үндсэн ойлголт

- Хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх ойлголт
- Хүүхдүүдэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг сурталчилах

3.4.3.Үйл ажиллагаа:

- Сургуулиудад хөдөлгөөний аюулгүй байдлын кабинет байгуулах
- Жолооны курс, сургалтын төвүүдтэй хамтран ажиллах, мэдээлэл сурталчилгаа хийлгэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах
- Байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Суралцагчдад замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг илэрхийлсэн зурагт үзүүлэн, санамжийг харуулж, ярилцах
- Зөв буруу үйлдлийг хэлэлцүүлэх дасгал ажлыг хийлгэх

3.4.4.Арга зүй

Дасгал 1. Дараах дүрмийг танилцуулж, заалт бүрийг нь сурагчидтай ярилцана.
Явган зорчигч нь зорчих хэсгээр явж байхдаа²:

- Утсаар ярих,
- Гар утас болон түүнтэй ижил төстэй тоглоом, хэрэгсэл оролдож ширтэх,
- Зохицуулагчийн шүглийн чимээ, бусдын дуут дохио, анхааруулгыг сонсох боломжийг хязгаарласан чихэвч зүүх,
- Ном, сонин гэх мэт зүйл унших,
- Зорчих хэсэг дээр дугуйт тэшүүр, дугуйт хавтан болон түүнтэй ижил төстэй, биеийн тамир, спорт, тоглоомын зориулалттай хэрэгслээр явахыг хориглосон байна.

Жолооч, зорчигчтой холбоотой:

- Хороолол дотор гүйцэж түрүүлэх үйлдэл хийхийг жолоочид хориглолоо.
- Жолооч явган хүний гарцаар гарч байгаагаас гадна мөн гарахаар завдаж байгаа явган зорчигчид зогсож зам тавьж өгөх үүрэг хүлээнэ.
- Долоон нас хүрээгүй хүүхдийг насанд хүрсэн харгалзах хүнгүйгээр тээврийн хэрэгсэлд үлдээхийг хоригложээ.
- 10 хүртэлх насны хүүхдийг тээвэрлэхдээ биеийн жин, өсөлтөд нь тохирсон зориулалтын нэмэгдэл суудал буюу хамгаалах хэрэгсэл ашиглана.
- Харааны бэрхшээлтэй хүний цагаан таяг нь харанхуй үед гэрэл ойлгодог буюу гэрэлтдэг гадаргуутай байх шаардлагыг тусгажээ.
- Явган зорчигчийн гэрлэн дохио харааны бэрхшээлтэй хүмүүст явган хүний гарцын байршлыг мэдэгдэх нэмэгдэл дуут дохиотой байж болно.
- Өөрийн үйлдлийг хянах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй /сэтгэцийн өвчтэй/ хүнийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд явганаар оролцуулахгүй.
- Автобусаар зорчигчийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс хаалгыг жолоочийн суудлаас удирддаг бол гүйцэд зогсоогүй байхдаа хаалга нээхийг хориглолоо.

Дасгал 2 Дараах тэмдэг, санамжийг сурагчдад дэлгэцээр харуулж, утгыг хэлэлцэнэ.



Нэмэлт мэдээлэл

Машин болон авто замаар хөдөлгөөнд болгоомжтой оролц

Авто замаар гарахдаа заавал гарцтай газраар ногоон гэрлээр гарч байгаарай. Машинаар явахдаа суудлын бүс заавал зүүж хэвш. Гэр бүлийнхэндээ ч суудлын бүсээ даруулахыг сануулж байгаарай. Мөн бага насны дүүгээ урд талын суудалд хэзээ ч битгийг суулгаарай. Машин зам гарахдаа хөгжим сонсож чихэвчтэй явж болохгүй. Хэрэв суух машины жолооч согтуу байвал тэр машинаар хэзээ ч битгий зорчоорой.

10 хүртэлх насны хүүхдийг

- Харгалзах хүнгүйгээр тээврийн хэрэгсэлд үлдэх
- Мотоциклийн арын суудалд тээвэрлэх
- Харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд явганаар оролцуулах
- Унадаг дугуйгаар замын хөдөлгөөнд оролцох
- Зориулалтын бүс суудал дээр тээвэрлэх

ДӨРӨВ. БИЕ БЯЛДАР, АВЬЯАС ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ

- 4.1. Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан-танин мэдэхүй, зохион бүтээх чиглэлийн үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэх
- 4.2. Олон нийтийг хамарсан спортын арга хэмжээнд оролцох, эерэг жишээг сурталчлах, дэлгэрүүлэх

Хичээлээс гадуурх сургалтын ажлын энэхүү чиглэл, агуулгын хүрээнд танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, бие бялдар, авьяасыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон урлаг, спортын мэдээлэл сурталчилгаа, уралдаан тэмцээн, уулзалт ярилцлага, өдөрлөг, үдэшлэг, төрөл бүрийн секц, дугуйлангийн үйл ажиллагааг сургуулийнхаа онцлог, нөөц боломжид тулгуурлан төлөвлөн хэрэгжүүлж болно. Ерөнхий боловсролын сургуулиудад энэ чиглэлээр IQ болон оюуны ухааныг

2 Замын хөдөлгөөний шинэчлэгдсэн дүрмийг 2018 оны арваннэгдүгээр сарын 1-нээс мөрдсөн.

хөгжүүлэх, урлаг, соёлын арга хэмжээ, дүрслэх урлаг, дизайн, зохион бүтээх болон төрөл бүрийн спортын уралдаан, тэмцээн, секц, дугуйлангийн үйл ажиллагааг зохион байгуулж байна.


Бүтээлч төсөлт ажил хийх нь сурагчдын танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, авьяасаа нээн хөгжүүлэх үр дүнтэй үйл ажиллагаа юм.

Бүрэн дунд боловсролын түвшинд:

Загвар 1. “Сургуулийн гадна орчны дизайны шийдэл” төсөлт ажил

Зорилго: Сурагчдын танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах зохион бүтээх, бүтээлч үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэхэд чиглэнэ.


Төсөлт ажлыг дараах үе шатаар хэрэгжүүлнэ.



Арга зүй

Сурагчдын хийх үйл ажиллагаа

Алхам 1. Төслийн ажлын хэрэгцээ, зорилгыг тодорхойлох



Аливаа асуудлыг шийдвэрлэхдээ байгаль орчинд аюулгүйн талаас нь авч үзэхийг анхаарна.

Алхам 2. Мэдээлэл цуглуулах, судалгаа хийх

- “Сургуулийн гадна орчны тохижилт” сэдвээр ярилцлага хийх, багш, ажилтан, сурагч, эцэг, эхчүүдээс санал авах
- Сургуулийн гадна орчны тохижилтын жишиг загваруудын судалгаа хийх (өөрийн болон бусад улс орны сургуулиудын жишээн дээр)


Судалгааг хийхэд анхаарах зүйл:

Эдийн засгийн шаардлагын хүрээнд үнэ өртөг бага шаардсан эд зүйлсээр тохижуулсан байдал, гоо зүйн шаардлагын хүрээнд, гадна орчны тохижилтын хийсэн зүйлсийн харагдах байдал, хэлбэр, өнгө дизайны шийдэл болон осол аюулгүйн шаардлага хангасан байдал зэргийг харгалзан үзнэ.




- Сургуулийнхаа гадна орчны хэрэгцээ, үндэслэлийг тодорхойлох
- Юуг, яаж хэрхэн шийдвэрлэх талаарх санааг тодорхойлох, гадна орчны төлөвлөлтийн тойм зураг зурах





Алхам 3. Дизайны шинэ санаа, шийдэл гаргах

- Судалгаа болон баримт мэдээлэл үндэслэн сургуулийн орчны төлөвлөлтийн план зураг зурах
- Төлөвлөлт, санаагаа сайжруулах, хөгжүүлэх (Олон нийт болон мэргэжлийн хүмүүсийн санал, зөвлөгөөг авах)



Алхам 4. Бүтээх, турших

- Сургуулийн орчны төлөвлөлтийн макет хийх материал, нөөц, технологи дарааллыг төлөвлөх
- Төлөвлөлтийн дагуу макет хийх



Ногоон байгууламж нь агаарыг цэвэршүүлж, чийгшүүлэх, тоосжилтыг багасгах, агаарыг бохирдлоос хамгаалах, дуу чимээг шингээх, ажиллаж, амьдрах тохьтой нөхцлийг бүрдүүлэх экосистемийг зохицуулдгаараа өндөр ач холбогдолтой. Ногоон байгууламж хийх цэцэрлэгжүүлэх төлөвлөгөөг гаргах хэрэгтэй. Иймд түргэн ургадаг мод, сөөг тарих, хөрсний бичил орчин бүрдүүлэх, шилмүүст мод болон бусад тохиромжтой ургамал тарих талаар судлах хэрэгтэй.

Алхам 5. Үнэлэх, үр дүнгээ танилцуулах

- Сургуулийн орчны төлөвлөлт төсөлт ажлын үр дүнг сургуулийн удирдах ажилтан, багш, сурагч, эцэг эхчүүдэд танилцуулах, санал авах
- Төслийг хэрэгжүүлэх санхүүгийн болон бусад нөөц боломжийг ашиглах санал дэвшүүлэх
- Цаашид хийх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох



Цахим хэрэглэгдэхүүн:

- Gservis projektu a domy, "Projekty rodinnych domu" цахим сэтгүүл, CZ 2018.
- <https://www.pinterest.com>
- www.gservis.czen.wikipedia.org

4.3. Уламжлалт өв соёл, түүн дотроо соёлын биет бус өвийг өвлүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх

4.4. Орчин үеийн цаашилбал дэлхийн урлаг, уран сайхны бүтээлийг сурталчлах зорилготой хүүхдийн урлаг, соёлын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх, дэмжин хөгжүүлэх

Зорилго. ЕБС-ийн суралцагчдад болзошгүй эрсдэл, зөрчил гэж юуг ойлгох, зөрчил, хүчирхийлэл үйлдэгдэн гарахад нөлөөлж байгаа шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга, хувь хүний хариуцлагын талаар анхан шатны мэдлэг эзэмшүүлэхэд оршино.

Үндсэн ойлголт

- Соёлын биет бус өвийн тухай
- Соёлын биет өвийн тухай
- ЮНЕСКО-д бүртгэгдсэн Монголын өв
- Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч гэж хэн бэ?

Үйл ажиллагааны чиглэл:

Соёлын өвийг хамгаалах тухай хуулинд заахдаа: Ард түмний билэг авъяас, мэдлэг, туршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болон биет бусаар өвлөгдөн уламжлагдаж ирсэн түүх, угсаатны судлал, ардын билэг, зан үйл, ур хийц, арга барил, дэг сургууль, урлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий дараахь оюуны соёлын үнэт зүйлийг соёлын биет бус өвд хамааруулна гэж заасан байдаг.

4.1.1. эх хэл, бичиг, түүний хүрээний соёл

4.1.2. аман зохиол

4.1.3. ардын уртын болон богино дуу, тууль, тэдгээрийг дуулах, хайлах арга барил

4.1.4. хөдөлмөр, зан үйлийн холбогдолтой уриа дуудлага

4.1.5. хөөмий, исгэрээ, аман болон тагнай ташилт зэрэг өгүүлэхийн эрхтний шүтэлцээт урлаг, тэдгээрийг илэрхийлэх арга барил

4.1.6. үндэсний хөгжмийн зэмсгийг урлах, хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил

4.1.7. ардын уламжлалт бүжиг, бий, биелгээ

4.1.8. уран нугаралт болон циркийн үзүүлбэрийг илэрхийлэх гоц авъяастны ур чадварын арга барил

4.1.9. ардын гар урлалын дэг сургууль

4.1.10. ардын ёс заншил, зан үйлийн уламжлал

4.1.11. эрдэм ухааны уламжлал

4.1.12. ардын бэлгэдэх ёсны уламжлал

Тэгэхлээр эдгээр биет бус өвийг өвлүүлэх, суратчилах, түгээн дэлгэрүүлэх олон талт үйл ажиллагааг тухайн орон нутгийн онцлог, багшлах боловсон хүчний нөөцөд тулгуурлан зохион байгуулах боломжтой юм.

Нэмэлт мэдээлэл

ЮНЕСКО-д Монголын дараах өвүүд бүртгэгдсэн байна.

- 2008 он Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг
- 2008 он Монгол ардын уртын дуу
- 2009 он Монгол тууль
- 2009 он Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг
- 2009 он Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг
- 2010 он Монгол наадам
- 2010 он Монгол ардын Хөөмэйн урлаг
- 2010 он Шувуучлахуй буюу бүргэдээр ан хийх зан үйл
- 2011 он Монгол Лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил –битүү амьсгаа
- 2011 он Алтан товч
- 2011 он Монгол Данжуур
- 2013 он Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл
- 2013 он Монгол уран бичлэг
- 2014 он Шагайн харваа
- 2015 он Ботго авахуулах зан үйл

ТАВ. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЁС ЗҮЙТЭЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ

5.1 Уламжлалт соёл, ёс зүй, гэр бүлийн үнэт зүйлийг мэдээллийн орчинд сурталчлахад дэмжтлэг үзүүлэх

5.2 Интернетийн орчинд хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилтөд хортой нөлөөлж болохуйц мэдээллээс хамгаалах төрөл бүрийн арга, орчин нөхцөл бүрдүүлэх

5.1.1. *Зорилго:* Мэдээллийн орчны нөлөө хүүхдийн хүмүүжил төлөвшилд хэрхэн нөлөөлөх, гэр бүл болон сургуулийн орчинд цахим хэрэгслийг зохистой ашиглах дүрэм журам баримтлах, зөв хэрэглэх, эерэг нөлөөг нэмэгдүүлэх хандлагыг төлөвшүүлэхэд оршино.

5.1.2. Үндсэн ойлголт

- Цахим мэдээллийн орчны тухай ойлголт
- Цахим орчин дахь сурч хөгжих боломжууд
- Цахим мэдээллийн хэрэгсэл ашиглах гэр бүлийн дэг, дүрэм баримтлах талаар ярилцах, өөрсдөө зохиох
- Цахим орчин дахь эрсдэлүүдийг таньж мэдэх
- Цахим эрсдэлээс өөрийгөө хамгаалах чадварт суралцах
- Цахим хэрэгслийг зохисгүй хэрэглэснээс үүдэлтэй хэн нэгний эрх хохирсон загвар баримт, асуудлыг өөрсдөө дүгнэж ярилцах, тайлбарлах
- Сургуулийн орчинд цахим хэрэгсэл ашиглах, анги хамт олны цахим группын дүрмийг харилцан ярилцаж зохиох
-
- Уламжлалт соёл, ёс зүй, гэр бүлийн үнэт зүйлийг мэдээллийн орчинд сурталчлах
- Видео аудио хичээлээр авьяас сонирхлын дагуу өөрийгөө хөгжүүлэх,
- Өөрийн цахим хуудсаараа сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх, гомдсон, уурласан, сэтгэлээр унасан үеийн зан байдлаа илэрхийлэх талаар хамтран хэлэлцэх
- Бусдын цахим хуудсанд шүүмжлэлттэй хандаж өөрийн санал бодлыг зохимжгүй үг хэллэгээр илэрхийлэх талаар харилцан ярилцах

5.1.3. Үйл ажиллагаа

а. Бага боловсролд

- Цахим мэдээллийн орчноос дуу, хөгжим, шүлэг, үлгэр, домог, хүүхэлдэйн кино, урлан бүтээх, гадаад хэл зэргийн видео, аудио хичээлийг дагалдан суралцах
- Хүүхдийн үзсэн үлгэр, хүүхэлдэйн киноны талаар санаа бодлыг нь яриулах, харьцуулах дүгнүүлэх, асуултад хариулах байдлаар сэтгэхүйн үйлүүдийг хөгжүүлэх
- Цахим зөв зохистой хэрэглээний дадал хэвшилд сургах, дэлгэцийн хамаарлаас урьдчилан сэргийлэх, эцэг эх гэр бүл нь цахим хэрэглээндээ зөв зохистой үлгэр дууриал үзүүлэх

- Мэдээллийн орчинд ёс суртахуунтай байх, хувийн мэдээллээ хамгаалах, үл таних хүний учруулж болох эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг ойлголт, чадвартай болгох

б.Суурь боловсролд

- Мэдээллийн орчинд байгаль, нийгмийн ухааны хичээлийг гүнзгийрүүлэн үзэх, алдартай хүмүүсийн амжилтад хүрсэн түүхээс судлах, зөв зохистой ашиглах боломжийг бүрдүүлэх
- Эрдэмтэн судлаачидтай уулзалт хийх, ирээдүйн мэргэжлийн чиг баримжаа, хувийн чадвар, нөөц боломжоо тодорхойлоход дэмжлэг үзүүлэх
- Мэдээллийн орчин дахь зохисгүй агуулга болон харилцаанд шүүмжлэлтэй хандахад чиглүүлэх

в.Бүрэн дунд боловсролд

- Цахим орчны нээлттэй нөөцүүдээс суралцах, өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр багшийн чиглүүлгээр тодорхой даалгавруудыг гүйцэтгэх, хамтын судалгаа хийх, тайлагнах
- Мэдээллийн орчин дахь харилцаа, мэдээлэл хүлээж авах олон хэлбэрүүдийг судлах, бусад хичээлтэй холбож багш нартай хамтран ажиллах
- Өсвөр насныхан бусдын хараа хяналтгүй цахим мэдээллийн орчноос шинэ найз нөхөд хайж олох, өөрийн үе тэнгийнхэнтэй харилцаа холбоо тогтоох хүсэл эрмэлзлэл ихтэй тул сониуч зан, сэтгэл хөдлөлөө хянахад дэмжлэг үзүүлэх

5.1.4.Арга зүй

Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд: Мэдээллийн орчны зохистой, соёлтой хэрэглээг хэвшүүлнэ.

Интернэт, гар утас, бусад цахим мэдээллийн хэрэгсэл хүүхэд, өсвөр үеийнхэнд сурч боловсрох, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох, хөгжих мэдээлэл авах, нийгмийн сүлжээгээ өргөжүүлэх, хувийн мэдээллийн санг бий болгох, бүтээлч байдлаа хөгжүүлэх эерэг боломжуудыг олгох зэрэг олон ашиг тустайн зэрэгцээ бас аюул, эрсдэл дагуулж байна.

Цахим орчинд аюулгүй байхын тулд хүүхдүүд юу мэдэх, юу хийх шаардлагатай вэ?

Загвар 1: Дүрэм зохиох

Сэдэв: Цахим мэдээллийн орчны зохистой хэрэглээний дүрэм

- 1-5 дугаар ангийн хүүхдүүд-Гэр бүлдээ мөрдөх дүрэм зохионо.
- 6-8 дугаар ангийн хүүхдүүд-Сургуулийн орчинд дагаж мөрдөх дүрэм зохионо.
- 9-12 дугаар ангийн хүүхдүүд-Цахим группын дүрэм \Фэйсбүүк групп\ зохиож мөрдөнө.

Зорилго: Дүрэм зохиоход суралцах, дүрмийн тухай мэдлэгээ баяжуулах

Багш дүрмийн талаар ярилцана. Дүрэм нь хүмүүсийг бие биеэ ойлгох, хамтран суралцах, ажиллах, харилцан дэмжихэд тусалдаг. Дүрэм нь заалтуудаас бүрдэх бөгөөд заалтууд нь зөвшөөрсөн, хориглосон эсвэл үүрэг болгосон байдаг. Дүрмийг хэлэлцэж гаргахад тодорхой үе шат бий. Дүрэм гаргахын тулд уг дүрмийг хэрэглэх хүмүүс байгууллагыг оролцуулж саналыг нь авах хэрэгтэй. Хүн бүр дүрмээ мэдэж байх нь түүнийг хэрэгжүүлэх нэг үндэс болно. Дүрмийн хориглосон заалтыг зөрчвөл уг зөрчилд тохирсон хариуцлага оногдуулдаг. Зөрчил гаргасан бол хариуцлага хүлээх нь шударга ёсонд нийцнэ.

Эргэцүүлэх асуулт:

1. Дүрэм гэж юу вэ? та бүхэн гэртээ зурагт үзэх, гар утас таблет ашиглах болон сургууль дээр хичээлийн үеэр гар утас хэрэглэх, ангийн болон найзуудын фэйсбүүк групп дээр ямар, ямар дүрэм мөрддөг вэ?
2. Дүрэмтэй байх нь хүмүүс хоорондын харилцаанд хэрхэн нөлөөлдөг вэ? Загвар гарган тайлбарлана уу? Ангийн фэйсбүүк группын болон сургуулийн дүрэм ямар ялгаатай вэ? Яагаад ялгаатай байдаг вэ?
3. Дүрмийн талаар шинээр мэдэж авсан зүйлээ тэмдэглээрэй.
 - Ярилцсаны дараа хүүхдүүдийг баг болгон хувааж (ангиас хамаарч гэртээ, сургууль дээр, фэйсбүүк групп дотор) ямар дүрэм мөрдөх талаар ярилцана.
 - Баг тус бүр мөрдөх дүрмүүдийг ярилцаж, жагсаан бичиж танилцуулна.
 - Эцэст нь багуудын дүрмийг нэгтгэж, хамгийн чухал гэсэн 10 заалтыг авч нэгтгэн мөрдөхийг санал болгоно.

Өөрийн сурдаг сургууль болон анги хамт олондоо цахим орчинд дарамт, доромжлолд өртөж эрх нь зөрчигдсөн хүүхдийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах клуб, бүлгэм байгуулна. Тэрхүү клубуудыг нэгтгэсэн “Сургууль, орон нутгийн хамгааллын сүлжээ”-г бий болгох боломжтой.

Загвар 2:

1. Клубын нэр—“Цахим орчны соёлтой хэрэглээг хэвшүүлэх клуб”
2. Клубын зорилго—Интернэт, гар утас, бусад цахим мэдээллийн хэрэгсэл хүүхэд, өсвөр үеийнхэнд сурч боловсрох, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох, хөгжих мэдээлэл авах, нийгмийн сүлжээгээ өргөжүүлэх, хувийн мэдээллийн сангаа бий болгох, бүтээлч байдлаа хөгжүүлэх эерэг боломжуудыг олгоход чиглэгдэнэ.
3. Хамрах хүрээ – 6-12 дугаар анги
4. Үйл ажиллагааны чиглэл—Клубын зорилготойгоо уялдуулан үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлно.
5. Клубын ажлын чиглэл
 - сургууль дээр, анги доторх фэйсбүүк бүлгэмүүдэд бусдыг шоолж тохуурхсан, хэл амаар доромжилсон, гадаад төрхийг нь шүүмжилсэн, хувийн орон зайд нь хэт халдсан өнгө аяс, хандлага байгаа эсэхийг таньж илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг авдаг байх,
 - эерэг зөв харилцаа хандлагыг төлөвшүүлэх сургалт сурталчилгаа нөлөөллийн ажлууд зохион байгуулах
 - хүн бүр тэгш эрхтэй ч хүн бүр ялгаатай байдаг бөгөөд түүний онцлогийг хүндэлж хүлээн зөвшөөрөхийн чухлыг бусдад ойлгуулах
 - хэн нэгнийгээ цахим орчинд шүүмжлэх, шоолох, гадуурхах, зохисгүй үг хэллэгээр гомдоох явдлын эсрэг аян, хөдөлгөөн өрнүүлэх
 - хүүхдүүдэд бусдыг байгаагаар нь хүлээн зөвшөөрч, ойлгох чадвар бий болгоход анхаарах

Хүүхэд цахим орчин дахь дарамт, хүчирхийлэлд өртсөн буюу өртөж болзошгүй эсэхийг шалгахдаа дараах асуулгыг хэрэглэж болно. Тухайлбал:

1. Хүүхэд хэн нэгнээс өөрийг нь үзэн ядсан, заналхийлсэн зурвас,
2. и-мэйл, фэйсбүүкийн зурвас болон бусад олон нийтийн сүлжээний хэрэглэгчээс зурвас авсан уу?
3. Хэн нэгэн хүн хүүхдэд онлайнаар ямар нэг зүйл бичиж доромжилсон уу? Тэр зүйлд нь бусад хүн сэтгэгдэл бичсэн үү? Бусдад тараасан уу?
4. Хэн нэгэн тэдний зурвас, и-мэйл хаягийг зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулсан уу?
5. Хэн нэгэн тэдний зургийг доромж буюу гутаах байдлаар ашигласан уу? Тэр зургаа бусдад үзүүлэхээр онлайнаар нийтэлсэн үү?
6. Хэн нэгэн тэдний хувийн хаягийн нэвтрэх нууц үгийг хулгайлсан уу? Тэрийгээ зурвасаар илгээж, тараасан уу?
7. Хэн нэгэн тэднийг ангийн болон сургуулийн фэйсбүүк бүлгэм, бусад онлайн бүлгээс хассан уу? тэр нь хүүхдийн тухай цуу үг болж тарсан уу?
8. Хэн нэгэн таны хүүхдийн тухай цуу үг тараах, сөрөг зүйл ярих зорилгоор доромжилсон блог, фэйсбүүкийн хуудас, твиттерийн онцлох тэмдэглэгээ (# тэмдэглэгээ) ашигласан уу?

Хэрэв хүүхэд дээрх асуултын аль нэгийг хэлж айдас түгшүүртэй байгаа тохиолдолд та хүүхэдтэй ярилцаж, түүнтэй зөвлөх буюу сэтгэл санаагаар дэмжих, уг асуудлыг АУБ, эцэг эх болон холбоотой бусад хүнд мэдэгдэх хэрэгтэй. Хэрэв шалгах асуултуудын нэг буюу түүнээс илүүг баталгаажуулж байгаа бол цахим орчин дахь дарамт, хүчирхийлэлтэй яаралтай тэмцэх, урьдчилан сэргийлэх шаардлагатай болжээ.

Эцэг эх, багш нарт:

3-9 насны хүүхдүүд: *Техник технологитой харьцаж сурах үе*

Эцэг эх асран хамгаалагчийн аль нэг нь шаардлагатай тохиолдолд багш хяналт тавьж байх шаардлагатай. Гэрийн нөхцөлд зурагтын шүүлтүүртэй сувгуудын багцыг хэрэглэх, цахим орчинд аюулгүй сайтуудын жагсаалтыг гаргах нь зүйтэй. Энэ насны хүүхдүүдийн аюулгүй байдлыг хамгаалах гол зүйл нь зурагт, гар утасны зөв зохистой хэрэглээний дадал хэвшилд сургах, дэлгэцийн хамаарлаас урьдчилан сэргийлэх, эцэг эх асран хамгаалагчид өөрсдөө гэр бүл, нийгмийн орчин дахь цахим хэрэглээндээ зөв зохистой үлгэр дуурайл үзүүлэх, интернэт дэх аюулгүй байдлын үндэс, мэдээллийн орчин дахь ёс зүйн ерөнхий ойлголтыг бий болгоход оршино. Энэ насныхан нь цахим мэдээллийн орчны тусламж дэмжлэг

хэрэгтэй хамгийн залуу хэрэглэгчдийн бүлэг юм.

10-14 насны хүүхдүүд: Энэ үеийнхэн шилжилтийн насны хүүхдүүд байдаг. Тэд цахим мэдээллийн орчны талаар анхны ойлголт туршлагатай болсон үе. Залуу хүн болж төлөвших насныхан тул тэдэнд ойлгож сонирхсон маш олон асуудлууд байдаг бөгөөд тэрэндээ хариу авах сонирхолдоо хөтлөгдөн одоо байгаа хязгаараасаа давж болзошгүй. Шүүлтүүрийн программ болон өөр бусад техник хэрэгслийг хэрэглэх нь ашигтай. Энэ насныхан мэдээллийн орчин дахь зохисгүй агуулга болон зохимжгүй харилцаанд шүүмжлэлтэй ханддаггүй нь элдэв асуудалд татагдах магадлалыг нэмэгдүүлдэг.

15 ба түүнээс дээш насныхан: Энэ насны бүлгийнхэн мэдээллийн орчинд цахим технологийг хэн нэгний хараа хяналтгүйгээр ашигладаг залуу үеийнхэн юм. Шүүлтүүрийн программ ач холбогдол багатай ч нэмэлт үүргээ гүйцэтгэсээр байх болно. Өөрийн хувийн амьдралд бусдын хараа хяналтыг оролцуулахгүй байх, цахим мэдээллийн орчноос шинэ найз нөхөд хайж олох, үе тэнгийнхэнтэйгээ харилцаа холбоо тогтоох гэсэн асар их хүсэл эрмэлзлэлтэй. Мөн сониуч хэрэгт дурламтгай байдалдаа хөтлөгдөн аюултай байдалд өөрсдийгээ оруулж болзошгүй байдаг. Энэ тохиолдолд тэднийг өөрсдийгээ яаж аюулгүй байлгах вэ? гэдгийг ойлгуулах шаардлагатай.

ЗУРГАА. НИЙГЭМ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ

- 6.1. Хүүхдийн эрх зүйн мэдлэг, соёлыг дээшлүүлэх, тэдний эрх, ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргахад чиглэсэн ажлыг эрчимжүүлэх
- 6.2. Сурагчдыг нийгэмд тустай үйл ажиллагаанд бүтээлчээр оролцоход дэмжлэг үзүүлэх
- 6.3. Боловсролын байгууллагуудтай хүмүүжлийн асуудлаар хамтран ажилладаг эцэг эхийн болон олон нийтийн бусад байгууллагын ажиллагааг хөхүүлэн дэмжих

6.1.1. Зорилго: Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, эцэг эх, гэр бүлтэй хүүхдийн эрх, хөгжил хамгааллын чиглэлээр нийгэм олон нийтийн үйл ажиллагаанд үр дүнтэй хамтран ажиллах, хүүхдийн оролцоонд дэмжлэг үзүүлэхэд оршино.

6.1.2. Үндсэн ойлголт

1. Оролцоо хэмээх ойлголт
2. Хүүхдийн оролцооны тухай ойлголт
3. Хүүхдийн оролцооны зарчмууд
4. Хүүхдийн оролцооны байгууллагуудын үйл ажиллагаа
5. Хүүхдийн оролцооны түвшин
6. Оролцооны хэлбэрүүд
7. Оролцоог дэмжих нь
8. Хүүхдийн оролцоонд тулгарах саад бэрхшээл
9. Хүүхдийн оролцоо эрхийн хэрэгжилтэд гарсан ахиц дэвшилд үнэлгээ хийх

6.1.3. Үйл ажиллагаа

а.Бага боловсролд

- Өөрийгөө тодорхойлох, бусдыг сонсох, өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлэх, бусдад хүндэтгэлтэй хандах
- Өөртөө итгэлтэй байх, өөрийгөө үнэлэх
- Өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрх үүрэг хэрэгцээгээ мэддэг байх

б.Суурь боловсролд

- Өөрийн нөөц боломжийг тодорхойлох, бусдыг сонсож ойлгохын ач холбогдол, өөрийн ирээдүйн зорилгоо тодорхойлох, өөрийгөө удирдах болон сэтгэлийн хөдөлгөөнөө хянах
- Бусадтай хариуцлагатай мэдрэмжтэй нөхөрсөг харилцах, хүндэтгэлтэй хандах, зөрчилдөөнтэй үед асуудлыг хүчирхийлэлгүй эерэг аргаар шийдэх

в. Бүрэн дунд боловсролд

- Өөрийн итгэл үнэмшилд суурилан зорилгоо тодорхойлох, бусдыг сонсож ойлгон, чин сэтгэлээсээ хандах амьдралын зорилгоо тодорхойлж, ирээдүйгээ төлөвлөх, мэргэжлээ сонгох
- Бусдын ялгаатай байдалд мэдрэмжтэй хандах, өөр соёл, үндэстнүүдийн талаар мэдлэг ойлголттой байх, тэнцвэртэй харилцах

6.1.4. Арга зүй

Бага боловсролын түвшинд

Оролцооны тухай ойлголт өгөх, хүүхэд өөрийн хүсэл мөрөөдлийнхөө тухай бусадтай хуваалцах, үзэл бодол байр сууриа илэрхийлэх, шийдвэр гаргах, хамтран ажиллах үйл явцад суралцах боломжтой.

Загвар 1: Би том болоод.

Зорилго: Хүүхэд бүр өөрийн хүсэл мөрөөдөл давуу талаа олж мэдэхэд суралцана.

Хэрэглэгдэхүүн: Ангийн бүх хүүхдүүд чөлөөтэй тоглох боломжтой өрөө тасалгаа

Заавар: Бүх оролцогчид тойрог болон сууна. Хүүхдүүд нэг нэгээрээ тойргийн голд гарч “Би том болоод..... ийм мэргэжилтэй хүн болно” хэмээн ирээдүйд өөрийн эзэмшихээр хүсч буй ажил мэргэжлээ ярьж хэлэлгүй зөвхөн үйл хөдлөлөөрөө хийж үзүүлнэ. Бусад хүүхдүүд түүний үйл хөдлөлөөр ямар мэргэжилтэй болохыг хүсч байгааг таана. Загвар барилгачин, эмч, тогооч, хуульч, багш гэх мэт. Үйл ажиллагааны төгсгөлд багш мэргэжил бүхний талаар харилцан ярьж тайлбарлаж өгнө.

Суурь, бүрэн дунд боловсролын түвшинд

Хүүхдийн байгаль экологийн оролцоог идэвхижүүлэх үйл ажиллагааны загвар санал болгож байна. Энэ санааг оролцооны өөр хэлбэр, хувилбарт хөрвүүлэн ашиглах боломжтой.

Загвар 2: “Хүрээлэн буй орчноо сайжруулах” төсөл

Зорилго: Хүүхдүүд өөрсдийн хүрээлэн буй орчин, экосистемийг бүрдүүлэгч амьтад, ургамал, ус, ой мод, хөрс шороо болон өөрсдийнх нь амьдралд ямар нэгэн асуудал байгаа эсэхийг тодорхойлон, асуудлыг шийдвэрлэн хүрээлэн буй орчноо сайжруулах төсөл боловсруулан хэрэгжүүлэх арга замд суралцана.

Хэрэглэгдэхүүн: Самбар, ватум цаас, өнгийн харандаа, үзэг, цавуу, фломастер, скоч

Үйл ажиллагаа:

Энэ ажил нь сурагчдад урьд өмнө судалж мэдсэн хүрээлэн буй орчны талаарх мэдлэг, мэдээллээ бодитоор хэрэглэх боломж олгоно. Үндсэн зорилго нь сурагчид сурсан мэдлэг, чадвараа ашиглан өөрийн орон нутаг, хүмүүс болон амьд байгаль зэрэгцэн сайн сайхан амьдрах орчныг сайжруулан өөрчлөх төсөл хэрэгжүүлэх юм. Багийн гишүүн бүр төсөл хэрэгжүүлэхэд оролцох ёстой. Хүн бүрийг оролцуулан, тохирсон ажлыг хуваарилан хариуцуулах, хийх ажил, хугацаа, хариуцах хүнийг тодорхойлон ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэхдээ дараах 6 алхмыг хэрэглэх нь хүүхдэд илүү ойлгомжтой, хялбар байх болно.

Алхам-1 Багаар буюу бүлгээр ажиллан асуудлыг тодорхойлох.

Ингэхдээ дараах асуултыг асуун хэлэлцээрэй. Та бүхнийг хүрээлэн буй орчинд (сургуулийн гадаад, дотоод) болохгүй, чамд таалагдахгүй, өөрчилмөөр ямар асуудал байна вэ? Хүүхэд бүр нэг асуудал гаргаж ирнэ.

Асуудлыг самбар дээр дараалуулан бичих эсвэл хүүхэд бүр өнгийн цаасан дээр бичээд самбарт наана. Хамгийн чухал, цаг хугацаа, санхүү болон хүн хүчний хувьд 1 сарын хугацаанд хэрэгжих боломжтой нэг асуудлыг сонгон авахад багш тусална. Хүүхэд бүр гаргасан жагсаалтаас нэг ажлыг өөрийн сонголтоороо тэмдэглэж саналаа илэрхийлнэ.

Дараа нь саналыг тоолж олон санал авсан ажлуудыг сонгоно. Цөөнх болсон хүүхдүүдэд өөрийн санааг илэрхийлэх, олонх өөрийн санааг нотлох боломжийг олгон ил тод байдлаар санал асуулга явуулан багийн шийдвэрлэх асуудал буюу төслийн санааг сонгоно.

Алхам-2. Сонгосон асуудлаар мэдээлэл цуглуулах:

Бусад хүүхдүүд, сургуулийн багш, ажилтнуудаас санал асуулга, товч судалгаа авах, боломжтой бол хэвлэл мэдээлэл, ном, сурах бичиг, хууль дүрэм судлах аргаар шаардлагатай мэдээлэл цуглуулна. Шаардлагатай бол багш, ажилтнууд нэмэлт мэдээлэл сурагчдад өгөх

хэрэгтэй. Энэ мэдээлэл нь тэдэнд тухайн асуудлыг шийдвэрлэх шаардлага хэрэгцээ байгаа эсэх, хэрхэн шийдвэрлэх ёстойг тодорхойлоход туслах баримт нотолгоо болно.

Алхам-3. Тодорхой мэдээлэлтэй болсоны дараа асуудлыг шийдвэрлэх арга зам буюу шийдлийг боловсруулах

Хүн бүрийн оролцоо маш чухал. Бүгд өөрсдийн хувилбарыг дэвшүүлэн санал хурааж, багаараа боломжит хувилбаруудыг сонгон авна. Тэгээд цаг хугацаа, хэрэглэгдэхүүн, сургуулийн нөхцөл байдлын хувьд хамгийн боломжтой нэг хувилбарыг сонгоно.

Алхам-4. Арга замаа сонгосны дараа ажлын төлөвлөгөө боловсруулах

Ажлын төлөвлөгөө нь шийдэлд хүрэх арга замууд байна. Хийх ажлуудыг жагсаан хариуцах хүн, цаг хугацааг тодорхой болгосон төлөвлөгөө боловсруулна. Ингэхдээ нэг нэгнийхээ санал хүсэлтийг харилцан сонсож хамтын шийдвэр гаргах ёстойг мартаж болохгүй.

Алхам-5. Төлөвлөгөөгөө ажил хэрэг болгох

Үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэх, бусад хүмүүсийг үйл ажиллагаанд татан оролцуулна. Багийн гишүүн бүр өөр өөрийн хүлээсэн үүрэг хариуцлагаа гүйцэтгэх нь чухал гэдгийг хүүхдүүдэд сайн ойлгуулах хэрэгтэй. Тиймээс хүүхдүүд өөрийн хийж чадах ажлыг сонгон авах нь зүйтэй.

Алхам-6. Төслийн үйл ажиллагааг үнэлэх

Төслийн үр дүнг сургууль дээр олон нийтэд танилцуулна. Багш, ажилчдаас бүрдсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй шүүгчид төслийг тодорхой шалгуураар үнэлж төслийн хаалтын ажиллагаан дээр дүнг танилцуулж, шагнал гардуулна.

Энэ ажлыг хийхдээ багш дээрх алхмуудыг хүүхдүүдэд тайлбарлан ойлгуулж асуудал сонгох хүртэл чиглүүлнэ. Түүнээс цааш хүүхдүүд багаар өдөр өдөрт ажлаа хуваарилан ажиллана. Мэдээж багш болон сургуулийн бусад ажилтнуудаас тусламж авч болно. Улирлын амралт эхлэхээс 1-2 хоногийн өмнө төслийн үр дүнг ханын сонин бэлтгэн олны өмнө танилцуулна. Энэ хугацааг эхлээд хүүхдүүдтэй тохирох хэрэгтэй.

Төслийн хэлэлцүүлэг

Алхам-1. Хүүхдүүдээс тэдний хүрээлэн буй орчинд өөрчлөх, сайжруулах шаардлагатай зүйлс байгаа эсэхийг асуун ярилцаарай. Хүрээлэн буй орчныг сайжруулах нь орон нутагт болон хүүхдүүдэд, оршин суугчид, амьтан ургамалд үр ашигтай эсэх, тийм хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг асуугаарай. Хэрвээ тэд санал нэг байвал энэ төслийн үйл ажиллагаа нь тэр ажилд тус нэмэр болно гэдгийг тайлбарлана. Хэрэгцээ шаардлага байгаа нь тодорхой бол төслийн цар хүрээ хамгийн гол асуудал болно. Хүрээлэн буй орчныг сайжруулах төсөл нь жижиг, том байж болно. Хэрвээ энэ дасгал ажлаас улбаалан төсөл хэрэгжүүлэх болбол дараах зүйлсийг анхааран үзэх ёстой. Хүүхдүүдэд дараах зөвлөмжүүдийг өгч чиглүүлээрэй.

- Төслийг амжилттай хэрэгжүүлэх боломжтой цар хүрээтэй, арга замыг сонгон хэрэглэх
- ёстой.
- Төслийн үр дүн орон нутаг, амьд байгальд, хүмүүст ашигтай байх ёстой.

Алхам 2. Ерөнхий хэлэлцүүлэг хийсний дараа сурагчдыг 8-10 гишүүнтэй багт хуваана. Тэгээд баг бүрийг хүрээлэн буй орчныг сайжруулах төслийн загвар боловсруулахыг даалгана. Тэдэнд дараах асуултын дагуу ярилцаж, бэлдэх хангалттай хугацаа өгөөрэй. Асуудлыг нухацтай хэлэлцэн 1, 2 алхмын дагуу асуудлаа тодорхойлох даалгавар өгнө.

- Өөрчлөх сайжруулах шаардлагатай ямар асуудал байна вэ?
- Аль асуудал нь хамгийн чухал асуудал вэ?
- Уг асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх боломжтой юу?
- Тухайн асуудлыг шийдвэрлэхэд мөнгө санхүү шаардлагатай юу?
- Тухайн асуудлыг хүүхдүүд дангаараа шийдвэрлэх боломжтой юу? Туслалцаа авах боломж хэр байна вэ?
- Асуудлыг шийдвэрлэх нь хэнд ашигтай вэ? Хэнд ашиггүй вэ?
- Хэн та нарыг дэмжих, хэн дэмжихгүй вэ?

Алхам 3. Төслийн дараагийн алхмуудыг хүүхдүүд дараагийн өдрөөс эхлэн бие даан багаар хийж гүйцэтгэнэ. Хүүхдүүд өөрсдөө хэрэгжүүлэн хийх ёстой, багш зөвхөн шаардлагатай үед зөвлөгөө өгөн чиглүүлнэ. Төслийн танилцуулга болохоос өмнө хүүхдүүд багаар ажлын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэн ханын сонин бэлдэж дууссан байх ёстой. Мөн ханын сонингийн 4 хэсгийг багийн гишүүд хуваан авч танилцуулахаар бэлдэнэ.

Төслийн танилцуулга. Төслийн танилцуулгад сургуулийн багш ажилтнууд, удирдлага, орон нутгийн хүмүүс, байгаль хамгаалагчийг урьж болно. Төслөө танилцуулахдаа багийн гишүүд бүгд оролцоно. Төсөл 1 сарын дотор бүгд хэрэгжих боломжгүй. Иймд асуудлыг хэрхэн шийдвэрлэх сайн боловсруулсан төлөвлөгөө байж болно. Зарим нь хийж дуусгасан ч байж болно. Зарим хүүхдүүд гэртээ буцаж очоод хийж дуусгах ажил байж болно.

Асуулт хариулт- дүгнэлт

Дараах шалгуураар үнэлэн бусдаас илүү сайн хийсэн “Хүрээлэн буй орчноо сайжруулах төсөл”-ийн эхний 2-3 байрыг шалгаруулна.

- Багийн хамтын ажиллагаа
- Асуудал шийдвэрлэх арга зам хэр оновчтой
- Баримт нотолгоо, мэдээлэл хэр цуглуулсан
- Хууль дүрэм журамтай хэр нийцэж байгаа эсэх
- Ханын сонингийн бүтэц
- Төслийн хэрэгжих боломж
- Танилцуулгаа хүмүүст хүргэх байдал

Бидний санал болгож буй энэ ажлын алхам бүрт хүүхдийн оролцоог дэмжих ойлголтуудыг суулгаж өгсөн байгаа гэдгийг санаарай. Урамшуулал нь үнэтэй биш энгийн, хүүхдийн оролцоо, идэвхийг үнэлсэн бусдыг гомдоох учиргүй. Болж өгвөл бүх хүүхдийг ямар нэгэн байдлаар урамшуулах нь зүйтэй. Энгийн сертификат хэвлэн өгөх, багийн хамт олны зургийг угаалган өгөх, ямар нэгэн амттан ч байж болно.

Хүүхдийн оролцооны байгууллагын удирдагч багшид нарт:

А. Аливаа үйл ажиллагааг чанар үр дүнтэй зохион байгуулахад хэрэглэгддэг арга зүйн элементүүд:

1. Анхаарлыг төвлөрүүлэх - Аливаа үр дүнтэй сургалт, үйл ажиллагааг эхлэхдээ оролцогчдын сонирхлыг татсан эсэхээс ихээхэн шалтгаалдаг. Иймд үйл ажиллагаа, сургалт хичээлийг эхлэхийн өмнө суралцагчдын сонирхлыг татдаг олон аргуудаас суралцах хэрэгтэй болдог. Тухайлбал:
 - Сургалт, үйл ажиллагааны гол үзэл санааг танилцуулах ямар нэгэн үйл ажиллагаагаар эхлэх
 - Тэдний амьдралын туршлага дээр үндэслэх бөгөөд сэдэвтэй уялдах асуулт, ямар нэгэн түүхээс эхлэх
 - Үйл ажиллагаа, сургалтын сэдэв буюу товч асуудлыг танилцуулах (жишээлбэл: тухайн сэдэвтэй холбоотой нийтлэл, өгүүлэл унших) гэх мэт
 2. Үйл ажиллагаа, сургалтын үр дүнгийн талаар мэдэгдэл хийх – тэднээс юуг хүсэн хүлээж байгааг оролцогчдод мэдэгдэнэ. Оролцогчдын амжилт нь “Энэ үйл ажиллагааны дүнд би тэднийг юу мэдсэн байгаасай гэж хүсэж байна вэ?” гэсэн асуултын хариулт байх болно.
 3. Хүлээгдэж буй үр дүн нь танин мэдэхүйн, зан төлөвийн, үнэт зүйл, хандлагын гэсэн төрлүүдтэй байдаг. Танин мэдэхүйн гэдэг нь суралцагчид юу сурах, тэр нь яагаад чухал болохыг мэддэг байх юм. Зан төлөвийн гэдэг нь суралцагчид тодорхой ур чадварыг сурч хэрэглэж түүнийгээ харуулж чаддаг байхыг хэлдэг бол үнэт зүйл хандлагын хүлээгдэж буй үр дүн нь суралцагчдын аливаа зүйлс болон хүмүүсийн харилцааны талаарх бодол мэдрэмж, харилцаа хандлага өөрчлөгдөх тухай асуудал юм.
 4. Мэдээллээр хангах, мэдээлэл хуваалцах–багш сургалт, үйл ажиллагаанд холбогдох мэдээллийг өгөхөөс гадна оролцогчдыг тухайн сэдвээр өөрийн мэдлэг, мэдээллийг бусадтай хуваалцах, нэмэлт мэдээллийг хаанаас олж болох буюу эх сурвалжийг нь тодорхой зааж өгөх хэрэгтэй.
 5. Хамтын ажиллагааны стратеги хэрэгжүүлэх–энэ нь хичээлийн хамгийн чухал хэсэг бөгөөд оролцогчид хооронд болон багш суралцагчдын хамтын үйл ажиллагаа маш чухал байдагтай холбоотой.
 6. Дүгнэлт хийх – Сургалт, үйл ажиллагаа зорилгодоо хүрч чадсан эсэхийг тодорхойлох болон тухайн үйл ажиллагааны арга зүйн, зохион байгуулалтын алдаа дутагдал, цаашид анхаарах асуудлуудыг ярилцан тодорхойлж болно. Суралцагчид сурсан мэдлэг, чадвараа нөхцөл байдалд хэрхэн хэрэглэж байгаагаар дүгнэлт үнэлгээг хийх нь чухал.
- Б. Сургалт, үйл ажиллагааны явцад бүлгээр ажиллахыг дэмжих- Бүлгээр ажиллахад суралцагч бүрийн оролцоо чухал бөгөөд тэд оролцооны аргад суралцаад зогсохгүй бусадтай зөв харилцах чадварыг хөгжүүлнэ. Тиймээс бүлгийн ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх чухал үүрэг багшид оногдоно.

- Хоёр гишүүнтэй бүлэг – Мэдээллийг маш сайн солилцдог, маргаанаас зайлсхийхэд тохиромжтой. Гэвч маргаан гарсан тохиолдолд аль нэг талыг дэмжих тал байхгүйгээс мухардалд орох магадлалтай.
- Гурван гишүүнтэй бүлэг - Нэг хүнийг хоёр нь олонхийн зарчмаар давамгайлах сул талтай. Гэвч гурван гишүүнтэй бүлгийг гишүүдийг өөрчлөн хэрэглэвэл хамгийн тэнцвэртэй бүлэг гэж үзэж болно.
- Тэгш тоотой гишүүнтэй бүлэг - Тэгш тоотой гишүүдтэй бүлэгт хамгийн их санал зөрөлдөөн гардаг. Дахин тэгш дэд бүлэгт хуваагдан мухардалд орох магадлалтай.
- Таван гишүүнтэй бүлэг - Сургалтад хэрэглэхэд хамгийн тохиромжтой хэмжээ. Асуудал дээр санал хуваагдахад 2:3 харьцаа нь цөөнхөд дэмжлэг авах боломж өгдөг.
- Таваас дээш гишүүнтэй бүлэг - Бүлгийн хэмжээ нэмэгдэх тусам бүлгийн мэдлэг, чадварын хэмжээ төдий чинээ нэмэгддэг. Гэвч бүлгийн бүх гишүүдийг дуулгавартай байлгах, бүгдэд үг хэлэх боломж өгөх, бүлгийн ажлыг зохицуулахад бэрхшээлтэй байдаг.

Загвар 3: Асуудал ба шийдэл

Зорилго: Хүүхэд өсвөр үеийнхэнд тулгамдаж байгаа асуудлаа шийдэхэд гарц олоход туслах, хамтын ажиллагааг дэмжихэд оршино.

Хамрах хүрээ: 14-18 нас

Хэрэглэгдэхүүн: Цаас харандаа

Заавар: Хүүхдүүдийн өмнө тулгамдаж буй асуудлыг хамгийн хэцүү гэж бодож байгаагаас нь эхлэн эрэмбэлж бичүүлнэ. Баг болон хуваагдаж, хамгийн чухал асуудлуудыг сонгон авч шийдвэрлэх гарцыг багаараа ярилцан тодорхойлж жүжигчилсэн тоглолт зохион байгуулна.

ДОЛОО. ЭХ ОРОНЧ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ХҮМҮҮЖЛИЙГ ДЭМЖИХ

7.1 Хүүхдэд эх оронч хүмүүжил олгох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

7.1.1.Зорилго: Хичээлээс гадуурх сургалтын ажлын нэг онцлог нь сурагчдад эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх явдал бөгөөд өөрсдийн орчин тойрон дахь тодорхой асуудлыг анги, баг, хамт олноороо шийдвэрлэх чадварт суралцахад дэмжлэг үзүүлэх юм.

7.1.2.Үндсэн ойлголт:

1. Эх орны тухай ойлголт
2. Эх оронч үзэл гэж юу вэ?
3. Эх оронч үзлийг төлөшүүлэх нь
4. Эх оронч хүмүүжил олгох ажлын хэлбэрүүд

7.1.3.Үйл ажиллагаа:

Хүүхдэд эх оронч хүмүүжил, түүний дотор цэрэг-эх оронч хүмүүжил олгохдоо дараах хөтөлбөрүүдтэй уялдуулан үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх. Тухайлбал:

- Аюулгүй, амьдрах ухаан хөтөлбөр
- Иргэний ёс зүйн боловсрол хөтөлбөр

Энэхүү зорилтын хүрээнд дуут жагсаалын үзлэг, өсвөрийн аврагч, цэрэг спортын “Дөл”, “Шонхор” тэмцээн, сурагч миний нэрийн хуудас зэрэг ажлуудыг зохион байгуулж болно.

Хүүхдийн клуб, бүлэгтэй ажиллах багш бол идэвхжүүлэгч, чиглүүлэгч бөгөөд хүүхдийн бодол санааг сонсогч, суралцагч, нэгтгэгч, дүгнэгч гэдгийг ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл хүүхдэд заах биш харин хамтран суралцах байрнаас хандах нь илүү үр дүнтэй юм.

7.2. Суралцагчдад суралцах чиглэл, мэргэжлээ тодорхойлж, ухамсартай сонгоход дэмжлэг үзүүлэх

7.3. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх

7.2.1. *Зорилго:* Сурагчдыг ирээдүйн ажил мэргэжлээ төлөвлөх, шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

7.2.2. Үндсэн ойлголт:

- Ажил мэргэжил гэж юу вэ?
- Ажил мэргэжлээ хэрхэн төлөвлөх вэ?
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох гэж юу вэ?
- Суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны ач холбогдол юу вэ?
- Эцэг эх асран хамгаалагч ямар үүрэгтэй вэ?
- Сургууль ямар үүрэг хүлээж, дэмжлэг үзүүлэх вэ?
- Ажил олгогч гэж хэнийг хэлэх вэ?
- Ажил олгогч сургууль, сурагчдад ямар дэмжлэг үзүүлэх вэ?

7.2.3. Үйл ажиллагаа:

- Монгол улс дахь ажил мэргэжлийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа
- ЕБС-ийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны талаарх судалгаа
- Ажил мэргэжлийн баримжаа олгох ажлын зохион байгуулалт
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны төрөл, агуулга
- Сургуулийн түвшинд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хяналт шинжилгээ
- Ажил мэргэжлийн сонголт хийхэд сурагч, багш, эцэг эхэд үзүүлэх дэмжлэг
- Ажил мэргэжлийн баримжаа олгох чиглэлээр хамтарч ажилладаг орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа, дэмжлэг

Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ БСШУЯ болон АХБ-ны хөдөлмөр эрхлэх, ур чадварыг дээшлүүлэх төслийн хүрээнд гаргасан ЕБС-ийн 8, 9, 10 дугаар ангийн суралцагчдад суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх багш, сурагч, эцэг эхийн гарын авлагыг хэрэглэнэ.

7.2.4. *Арга зүй:*

Ажил мэргэжлийн сонголт хийхэд нь сурагчдад дэмжлэг үзүүлэхийн тулд янз бүрийн мэргэжилтэй хүмүүстэй санал бодлоо солилцох, тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэх зорилгоор уулзалтыг зохион байгуулж болно.

Загвар 1. Уулзалт ярилцлага зохион байгуулах арга зүй

Уулзалтыг амжилттай явуулахын тулд төлөвлөлт болон бэлтгэл ажил чухал юм.

Уулзалт зохион байгуулахад дараах зүйлсийг анхаарч ажиллана. Үүнд:

- Уулзалтад оролцож буй оролцогчдод өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгох
- Эерэг харилцааг мэдэрч, сонирхолтой, хөгжилтэй болгох орчинг бүрдүүлэх
- Хүн болгоныг оролцуулах гэж нурших хэрэггүй
- Уулзалтад хамааралгүй зүйлсийн талаар ярихгүй байх
- Уулзалт 1 цагаас илүү үргэлжлэх бол завсарлагааны цагийг төлөвлөх

Дасгал

Суралцагчид өөрсдийн ур чадвараа үнэлж, сонирхсон ажил мэргэжлээ сонгоход баримжаа болгож болно. Энэхүү дасгал нь таны ур чадварууд, хийх дуртай ажлыг тодорхойлон, зорилго мөрөөдлийг ажил хөдөлмөртэй уялдуулах нэгэн алхам болох юм.

1- Муу 2- Багавтар бий 3- Дундаж 4- Сайн 5- Маш сайн ¹

Ур чадварууд	Оноо
Нийтлэг ур чадвар	
1 Хүмүүстэй хамт байх 2 Сонсох 3 Хүнийг ойлгож нөхөрлөх 4 Бусдыг хүндэтгэх 5 Хүмүүст туслах 6 Бусдыг хүлээн зөвшөөрөх 7 Бусадтай хамтран ажиллах 8 Бусдад нийцэмжтэй байх 9 Хошигнох <p style="text-align: center;">Аман ба бичгийн харилцаа</p> 1 Өөрийн үзэл бодлоо илэрхийлэх 2 Ойлгомжтой, цэгцтэй байх 3 Мэдээллийг бусдад танилцуулах, илтгэх 4 Тод, уран яруу ярих 5 Тайлбарлах, тодорхойлох 6 Гадаад хэлээр ярих <p style="text-align: center;">Манлайлах</p> 1 Бусдыг урамшуулах, сэдэл тэмүүлэл бий болгох 2 Өөрөө үлгэр дууриал үзүүлэх 3 Дарга, удирдагчгүйгээр ажиллах 4 Шинэ санаа санаачлах 5 Яаралтай үед самбаачлах 6 Асуудлыг олж илрүүлэн, шийдвэрлэх 7 Шинэ нөхцөл байдалд дасах 8 Үүрэг, хариуцлага хүлээх <p style="text-align: center;">Бүтээн туурвих, зөн билэгийн</p> 1 Гярхай ажигч 2 Шинийг санаачлах 3 Шүүмжлэх 4 Аливаа юмс үзэгдлийн учир шалтгааныг олох 5 Алсын хараа 6 Бүтээлчээр сэтгэх 7 Төсөөлөн бодох <p style="text-align: center;">Суралцах</p> 1 Тэмдэглэх, ажиглах судлах 2 Нэгтгэн дүгнэх ¹	
Тоо, тооллын	Оноо
1 Цээжлэх 2 Унших, бичих 3 Асуулт дэвшүүлэн үнэлж дүгнэх <p style="text-align: center;">Тоолох, тооцоолох</p> 1 Статистик тоо баримт хэрэглэх 2 Мөнгийг зөв зарцуулах 3 Нягтлан тооцоолох, баримт бичиг хадгалах 4 Төсөв зохиож, хэрэгжүүлэх 5 Урьдчилан тооцоолж, дүгнэх 6 Гарын ур дүй	
Мужаан урлал	ОНОО
1 Багаж, хэрэгслэлийн хэрэглээ 2 Хоол хийх 3 Цэцэрлэгжүүлэх 4 Засах, сэлбэх 5 Нягт нямбай <p style="text-align: center;">Заавар, дүрэм журмыг сайн дагаж мөрдөх</p> 1 Цагаа зөв хуваарилан баримтлах 2 Эцсийн хугацааг хүлээх 3 Мэдээллийг тэмдэглэх 4 Үүрэг даалгаврыг биелүүлэх 5 Ажлыг зохион байгуулах 6 Уншиж ойлгох 7 Өгөгдөл тоо мэдээлэл оруулах 8 Ачаалал дааж ажиллах 9 Тэмдэглэл хөтлөх 10 Урлаг уран сайхан	
Дүрслэх туурвих	ОНОО
1 Дизайн, зохион бүтээх 2 Фото зураг авах 3 Уран сэтгэмж 4 Хөгжөөх 5 Зурах, дүрслэх, бодох 6 Зурах, дүрслэх, будах	

Дээрх жагсаалтыг дахин харна уу. Хийх дуртай, гүйцэтгэх сонирхолтой ажлаа дугуйлан тэмдэглээрэй. Жагсаалтыг уншин тэмдэглэж дууссаны дараа 4 ба 5 гэсэн үнэлгээ өгсөн мөрүүдээ дахин дугуйлан тэмдэглэнэ. Учир нь таны давуу талуудыг илрүүлэх нь цаашид суралцах, ажиллахад тустай болно. Та хийж гүйцэтгэх дуртай, илүү сонрхдог зүйлсээ тодорхойлж байх явцад тэдгээр ур чадвар, туршлагаа хаана хэрхэн сурсан, хэрэглэж байсан тухайгаа санан, эргэцүүлэн бодоорой. Эдгээр туршлага нь магадгүй таны сургалтын явцад хуримтлагдсан бөгөөд эдгээр нь таныг суралцах, ажил хайх, мөн ажил мэргэжлээ сонгоход сайн жишээ, түүх болох юм.

Ажлын хуудас

БИ ХЭН БЭ? (Товч, жагсаан бичнэ үү)

Би ямар авьяас, ур чадвар, давуу чанартай вэ? -----

Миний сонирхол юу болох, юунд илүү идэвхитэй ханддаг, үнэт зүйл юу вэ? -----

Миний зорилго, мөрөөдөл буюу 1-2 жилийн дараа би юу сурч эзэмшсэн, эсвэл туршлага цуглуулсан, хаана ямар хөдөлмөр эрхлэх вэ? -----

Миний зан төлвийн сайн ба муу гурван чанар юу болох? -----

НАЙМ. БАЙГАЛЬ, ЭКОЛОГИЙН ХҮМҮҮЖЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ

8.1. Хүүхдэд байгаль дэлхий, эх орон газар нутгаа хайрлах хандлага төлөвшүүлэх ажлыг дэмжих

8.1.1. Зорилго: Сурагчид үйл ажиллагааны явцад бусдаас суралцах, бусдын үзэл бодлыг ойлгож, хүндэтгэх, хамтын оролцоонд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх, зохицуулах чадварт суралцах юм.

8.1.2. Үндсэн ойлголт:

- Тогтвортой хөгжил гэж юу вэ?
- Тогтвортой хөгжлийн боловсрол гэж юу вэ?
- НҮБ, Эх дэлхийгээ хувирган өөрчилъё: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр – 2030 (17 зорилго)
- Монгол улсын ногоон хөгжлийн бодлого³
- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал⁴
- ЕБ-ын сургалт үйл ажиллагаанд ТХБ-ын үзэл санааг тусган хэрэгжүүлэх үндсэн чиглэл, шаардлага⁵
- Байгаль орчны тогтвортой байдал
- Байгалийн нөөц баялгийн зохистой хэрэглээ
- Экологийн асуудлууд
- Хүн, байгалийн харилцан хамаарал
- Уур амьсгалын өөрчлөлт
- Гамшгийн хор уршиг, эрсдэлийг бууруулах
- Тогтвортой хэрэглээ, үйлдвэрлэл

8.1.3. Үйл ажиллагаа:

- Тогтвортой хөгжил болон ТХБ-ын хоорондын хамаарал, ялгааг таниулах

3 УИХ, 2014/43

4 УИХ, 2016/19

5 БСШУСЯ, 2015, А/458

- Тогтвортой хөгжлийн 17 зорилго, тэдгээрийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга аргачлал, менежмент
- Орон нутгийн уур амьсгалын өөрчлөлт хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалдаг талаарх ойлголтыг өгч, суралцагч байгальтай зөв харилцахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлнэ.
- Уур амьсгалын үндсэн ойлголт, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар хэлэлцүүлэг хийж болно.
- Хог хаягдлын талаарх мэдлэг, ойлголт, эрүүл цэвэр орчинд ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.
- Байгальтай харилцан зохицсон аж амьдралын уламжлал
- Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх ажлын хүрээнд ургацын баяр, цэцгийн баяр, мод тарих, цагаан цэцэг, шувуу тэжээх, миний нүдээр гар зургийн уралдаан, эко клуб, бүлгийг ажиллуулж болно.

8.1.4.Арга зүй:

Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх ажлыг хичээл, үйл ажиллагаатай интеграцчилан, сургалтын орчин, багшийн чадавхид илүүтэй анхаарч ажиллах хэрэгтэй.

Загвар 1. Эх дэлхийн байгаль цаг уурын өөрчлөлтөд чиний оруулах хувь нэмэр юу вэ? хэлэлцүүлэг зохион байгуулах

Хэлэлцүүлэг нь маргаантай асуудлыг шийдвэрлэх, хичээлийг сонирхолтой, үр дүнтэй болгоход чухал нөлөөтэй байдаг ч зарим асуудлыг анхаарахгүй бол эмх замбараагүй, үр дүнгүй байдалд хүргэдэг.

Хэлэлцүүлэг хийхэд хувь хүнд анхаарахаас илүү үзэл бодол, байр суурийг хэлэлцэж шийдвэрлэх хэрэгтэй.

Хүмүүсийн эсрэг бус учир шалтгаан, санаа бодлын эсрэг маргалдах хэрэгтэй.Багш санал нэгдэх, эсвэл санал зөрж байгаа үндэслэл, хэзээ хаана харилцан буулт хийх, болох болохгүйг ялган танихад сурагчдад туслах үүрэгтэй.

Багийн хэлэлцүүлгийн дүрэм

- Үзэл бодлоо илэрхийлэх үедээ засч сайжруулахад бэлэн байх
- Бусдын үзэл бодлыг эелдэг, хүндэтгэлтэй сонсох
- Бүх хүнд ярих боломж өгөх
- Хэрэв байр суурь чинь өөр байгаа бол хүмүүсийн эсрэг бус учир шалтгаантайгаар мэтгэлцэх
- Өөрийн үзэл бодлоо хэзээ ч өөрчилж болно. Түүнийг өөрчилсөн учир шалтгаанаа тайлбарлахад бэлэн байх
- Санал хураалтаар шийдвэр гаргах тохиолдолд цөөнхийн үгийг заавал сонсох, дараа нь дахин санал хураах мэтгэлцэх
- Өөрийн үзэл бодлоо хэзээ ч өөрчилж болно. Түүнийг өөрчилсөн учир шалтгаанаа тайлбарлахад бэлэн байх
- Санал хураалтаар шийдвэр гаргах тохиолдолд цөөнхийн үгийг заавал сонсох, дараа нь дахин санал хураах

Хэлэлцүүлэг хийхэд чиглүүлэгч юуг анхаарах хэрэгтэй вэ? Үүнд:

- Зааварчилгаа нь сайн ойлгогдсон эсэхийг хянаж, үйл ажиллагааны заавраа хүүхдүүдэд ойлгомжтой хэлбэрээр өгөх
- Бүлэгт тэгш хуваах
- Бусад бүлэгт (өөр бүлгүүд байгаа бол бүлгийн ахлагч нартай ярилцан) хэлэлцүүлэг яаж явагдаж байгааг шалгах
- Уйдаж байгаа, анхаарахгүй байгаа хэн нэгэнд нь анхаарал тавих
- Бусадтайгаа хуваалцаж санал авах боломжийг хамгийн тааламжтай байдлаар зохион байгуулах
- Хүүхдэд бодох, хоорондоо ярилцах цаг, орон зайг өгөх
- Тэвчээртэй хариуцлагатай, зэрэгцэн ярихгүй байх
- Хэн нэгэн голлож, бусдадаа ярих боломж өгөхгүй байгааг зохицуулах
- Хэрэв хэлэлцүүлэг цагаасаа эрт эсвэл оройтож дуусвал яах тухай хэлэлцэн, тохирсон арга хэмжээг авах

- Орчин болон сандал ширээний байрлал нь тохиромжтой байх
- Хүүхдийн өмнөөс хариулахгүй эсвэл өгүүлбэрийг нь дуусгахгүй яаруулахгүй байх
- Хүүхдүүдийг түр зуур ярихаа больсон байхад хэт их ярихгүй байх
- Хүүхдүүд дохио зангаагаар ярилцлагад саад болж магадгүй учраас тэднийг ажиглах, өөрийнхөө үйл хөдлөлийг анхаарах
- Цагт хяналт тавих
- Дуусгах хамгийн тохиромжтой цагийг тодруулах
- Хэлэлцүүлгийг ерөнхийд нь дүгнэх эсвэл хаах

Суурь боловсролд

Сурагчид байгалийн гаралтай хоол, хүнсний талаар судалгаа хийж, түүний үр дүнд үндэслэн сургуулийн цайны газрын болон үдийн хоол хөтөлбөрийн цэсэнд өөрчлөлт оруулдаг байх

Судалгаа хийх арга зүй

- Судалгаа хэрэглээ, зорилго, шалтгаан, мэдээлэл цуглуулах арга, цаг хуагцаа, үр дүнгээсээ хамааран харилцан адилгүй байна. Судалгааг
- *зорилгоор* нь нээх, тодорхойлох, тайлбарлах;
- *шалтгаан, мэдээлэл цуглуулах арга, цаг хугацаагаар* нь энгийн, шинжлэх ухааны;
- *үр дүнгээр* нь тоон ба чанарын судалгаа гэж хуваадаг.

Загвар 2: Судалгаа хийх үйл ажиллагааны төлөвлөлт



Судалгааны үр дүнг тайлан болгосны дараа бусдад түгээхдээ дараах аргуудыг хэрэглэж болно. Үүнд:

Тайлбарлах, тайлагнах аргууд

- Судалгааны ажлын гол дүнг тоймлон бичсэн хураангуйг танилцуулах (сонирхолтой товчхон бичнэ)

Бодит байдлыг бичлэг хэлбэрээр танилцуулах

- Видео бичлэг хийж тараана.
- Ухуулга, сурталчилгаа, санамж байдлаар хүргэнэ.

Уулзалт, олон нийтийн хурал дээр танилцуулах

- Эцэг эхийн өдөрлөг, байгууллагын хуралд оролцогчдод танилцуулна.
- Оролцогчид ямар ажил хийж болох талаар санал, зөвлөмжийг гаргаж болно.
- Өдөрлөг, үдэшлэгийн хөтөлбөрт тусган хөгжилтэй байдлаар хүргэнэ.
- Хэвлэл мэдээлэлд нийтлэлээр хүргэж болно.

Бүрэн дунд боловсролд

Тухайн орон нутагтаа мөхөх устах аюулд өртсөн, ховордсон амьтан ургамлын талаар эцэг эх болон байгууллагуудтай хамтран судалгаа хийж, төсөл хэрэгжүүлэх. Судалгааны үр дүнд ховордсон ан амьтдыг хамгаалах аян өрнүүлэх

Загвар 3: Уур амьсгалын өөрчлөлт


Орон нутагтаа мөхөх устах аюулд өртсөн, ховордсон амьтан ургамлын талаар хийсэн судалгааны үр дүнг танилцуулах ухуулга сурталчилгааг зохион байгуулах

Ухуулга сурталчилгаа хийх арга зүй

Сурталчилгааг мэдээлэл сургалт болон ухуулга гэж 2 хуваадаг. Мэдээлэл сургалт сурталчилгаа нь зориуд сонгосон зорилтот бүлгийхэнд харилцааны янз бүрийн сувгийг ашиглан, богино хугацаанд тодорхой нэг асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулдаг үйл ажиллагаа юм.

Ухуулга сурталчилгаа нь бодлогын өөрчлөлт хийх таатай орчинг бүрдүүлж, шийдвэр гаргачдыг зөв шийдэлд чиглүүлэх, нөлөөлөх, тэдний дэмжлэгийг бий болгох үйл ажиллагаа юм.

Уур амьсгалын өөрчлөлт мэдээлэл сургалт болон ухуулга сурталчилгаа зохион байгуулах үе шат



Мэдээлэл сургалт болон ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулахдаа олон нийтийн өөрсдийн оролцоог идэвхижүүлсэн, хүмүүсийн анхаарлыг татахуйц материал бэлтгэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарна.

Хавсралт 1. ХГСА-Д СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА ХИЙХ АРГА АРГАЧЛАЛ

НЭГ. СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХГҮА -н үр дүнг сайжруулах, үйл ажиллагааг төлөвлөх, агуулгыг тодруулах зорилгоор бид сурагчид, эцэг эх багш нараас сэтгэл ханамжийн судалгаагаар дүгнэлт хийж судалгааны үр дүнг тооцоолох боломжтой юм.

Сэтгэл ханамжийн судалгааг эцэг, эх асран хамгаалагчид - суралцагчид (бага анги, дунд анги, ахлах анги), багш нараас авч болох ба энэ үйл ажиллагаанд хамрагдаж байгаа бусад хүмүүсээс авч болох юм. Сэтгэл ханамжийн судалгааг дараах зорилгоор хэрэглэнэ. Үүнд:

- ХГСА-ын хүрээнд төлөвлөгдсөн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлыг илрүүлэх
- ХГСА-ны явцад үндсэн чадваруудыг сурагчдын болон эцэг эхийн сэтгэл ханамжийг илрүүлэх
- ХГСА-г хэрэгжүүлэх явцад гарч буй өөрчлөлтүүдийг тодруулах, сайжруулах харьцуулах
- Хөтөлбөрт хамрагдаж буй сурагчдын ялгаатай хэрэгцээг хангаж байгааг тодруулах, тэгш бус байдал байгаа эсэхийг шалгах, илрүүлэх

ХОЁР. СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТУУД

Сэтгэл ханамжийн судалгаа нь аль ч салбарт маш өргөн хэрэглэгддэг үг хэллэг бөгөөд ХГСА-ны сургалтын талаарх санал болгож буй үйлчилгээ нь хэрэглэгчийн (сурагч, эцэг эх) хүлээлтэд хэрхэн нийцэж байна вэ гэдгийг тодорхойлдог өргөн ойлголт юм. Сэтгэл ханамжийн судалгаа нь тодорхой хэмжүүрийн дагуу тооцогддог ба сургалтын үйл ажиллагаагаа хөгжүүлэх шат дамжлагыг нарийн тодорхойлж өгдгөөрөө давуу талтай.

Та сэтгэл ханамжийн судалгааг хийснээр дараах үр дүнг болон төлөвлөгөөг боловсруулан гаргах боломжтой. Үүнд:

1. Давуу болон сул талаа мэдэх

Сэтгэл ханамжийн судалгаанаас гарах эхний үр дүн бол тухайн сэдвийн талаарх сурагчдын мэдэрч буй сэтгэл ханамжийн түвшнийг үнэлэн гаргадаг. Эндээс сурагчдын үйл ажиллагаанд хамрагдсанаар сэтгэл ханамжтай байгаа болон сэтгэл ханамжгүй байгааг тодорхой болгоно.

2. Ач холбогдол ба бодит байдлын зөрүүг тодорхойлох

Сурагчдад олгож буй бидний сонгож авсан сэдэв тус бүр сурагчдын сонирхолд нийцэж байна уу, сурагчдын сонирхлыг татаж байна уу, бодож байсан хүлээж байсан үр дүнг илэрхийлж чадаж байна уу, тэдний хэрэгцээг нь хангаж байна уу, эцэг эхийн хүүхдээ хөгжүүлэх гэсэн сонирхолд хүлээж байгаа үр дүнд хэрхэн нийцэж байгаа болон нийцэхгүй байгааг тодорхойлж болно.

3. Үр дүнг тодруулах

Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс бид үйл ажиллагааны түвшинд гаргасан зардал буюу багшийн гаргасан хөдөлмөр үр дүнтэй байсан эсэхийг үнэлэх боломжтой. Тухайлбал, багш тодорхой нэг сэдэв үзүүлэлтэд ач холбогдол өгч, цаг заваа их хэмжээгээр зарцуулсан байж болно. Гэтэл тухайн сэдэв нь тухайн үйл ажиллагааны онцлогоос хамааран сурагчдын хувьд тийм ч ач холбогдолтой сэдэв байгаагүй бөгөөд үйл ажиллагаанд нөлөөгүй байж болох юм.

4. Судалгааны үр дүнд тулгуурлан төлөвлөгөөгөө сайжруулах

- **Өнөөгийн нөхцөл байдалд:** ХГСА-г зохион байгуулах явцад тохиолдож буй хүчин зүйлийг илрүүлэн түүнийг хэрхэн хадгалж үлдэх болон бусдаас ялгарах давуу тал болгон ашиглахад анхаарах.
- **Богино хугацааны төлөвлөлтөд:** Сурагчид, эцэг эхийн хувьд маш чухал боловч сэтгэл ханамжтай байлгаж чадахгүй байгаа үзүүлэлт тус бүрийг хэрхэн сайжруулах талаар төлөвлөх.
- **Дунд хугацааны төлөвлөлтөд:** Сурагчид, эцэг эх, багшийн хувьд ач холбогдол бага боловч сэтгэл ханамжийг бий болгож байгаа үзүүлэлтийг хэрхэн ач холбогдолтой болгох ба сургах тал дээр анхаарч ажиллах.
- **Урт хугацааны төлөвлөлтөд:** Төгсгөлд нь ач холбогдол, сэтгэл ханамжийн түвшинд хамгийн бага байгаа үзүүлэлтээ сайжруулахад анхаарна.

Сэтгэл ханамжийн судалгаа хийх үед

Сэтгэл ханамжийн судалгааг үйл ажиллагаа зохион байгуулсны дараа сэдэв тус бүрээр авч болох ба нэгдсэн байдлаар ч авч болох юм. Хэрэв та сэдэв тус бүрээр авах юм бол түүний хариулт зөвхөн тэр сэдвийн хүрээнд байх ба сэдэв тус бүрээр авч нэгтгэж үзэж боломжтой мөн өөрт хэрэгтэй бусад дэлгэрэнгүй мэдээллийг магадгүй авч болох юм.

Сэтгэл ханамжийн судалгаагаар ямар зүйлийг заавал асуух ёстой вэ?

Суралцагч, эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаагаар **заавал** асуух ёстой асуулт.

Та энэ үйл ажиллагаанд (сургалтад) дахин хамрагдах уу?

Судалгаанд хамрагдсан субъектууд “Тийм” гэж хариулах нь хамаагүй хялбар байдаг. Үүнийг тодруулахын тулд бидний үйл ажиллагаанд аль сэдвийг өөрчлөх, аль сэдвийг үргэлжлүүлэн тодруулах талаар бусад асуултуудыг бэлтгэж асуух хэрэгтэй.

Бүх талаас суралцагч, эцэг эхийн, багшийн сэтгэл ханамжийн асуултыг асуух жишээ:

- Та энэ үйл ажиллагаанд (сургалтад) хамрагдсанаар хэр сэтгэл хангалуун байдаг вэ?
- Та бидний үйл ажиллагаанд (сургалтад) дахин хамрагдах боломжтой юу?
- Та хүүхдүүдээ ийм чиглэлийн сургалтад (үйл ажиллагаанд) дахин хамруулах уу?
- Та манай үйл ажиллагааг (сургалт) бусдад санал болгох уу?

Үйл ажиллагааны (сургалт) талаар суралцагч, эцэг эхэд таалагдсан эсвэл хүсээгүй зүйлийн талаар асуухыг үгүйсгэх хэрэггүй.

Сэтгэл ханамжийн судалгаа хийхийн тулд Та юу хийх ёстой вэ?

Сэтгэл ханамжийн судалгаа хийдэг давтамж нь таны сургалтын (үйл ажиллагааны) давтамжаас хамаарна. Хамгийн гол нь судалгаанд өгсөн хариултыг үнэлж, саналыг нь хэрэгжүүлж байгаа гэдгээ эцэг, эх сурагчдад мэдэгдэх хэрэгтэй. Магадгүй сурагчид, эцэг эх саналаа хувиараа өгсөн байж болно тэр саналыг ч гэсэн оруулж тусгаж авна.

Судалгааны үр дүнг хэрхэн тооцох вэ?

Үйл ажиллагаанд хамрагдаж байгаа өөр өөр субъектуудээс сэтгэл ханамжийн судалгаа авч сургалт (үйл ажиллагаа) -ын талаарх мэдээлэл мэдээллийн баазтай болно. Эцэг эхийн судалгааг сургалтын эхэнд болон төгсөлд авч болно.

Үр дүнг тооцох аргачлал

Эцэг эхийн нас, боловсролын түвшин, ажил мэргэжил, өрхийн сарын орлого, айлын хэд дэх хүүхэд, зэрэг ерөнхий мэдээллийг авч болно.

Үр дүнд боловсруулалт, шинжилгээ хийх

Боловсруулалт хийхэд дараах алхмуудыг анхаарч үзэх шаардлагатай.

1. Өгөгдлийг цэвэрлэх: Хоосон, шаардлага хангаагүй, хэт худлаа, хүчингүй утгуудыг цэвэрлэх
2. Хэрвээ 2 буюу түүнээс дээш судалгаа нэгтгэх шаардлагатай бол хялбар арга замуудыг хэрэглэх
3. Судалгаанд цугласан өгөгдлүүдийн төлөөлөх чадвартай эсэхийг хянах
4. Түүврийн бус алдаа гарахаас сэргийлэх
5. Судалгаа цуглуулах процесст гарсан өгөгдөлтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх
6. Кодлох, кодын тайлбарыг оновчтой оруулах
7. Түүврийн мэдээллийн нягтлах

Үр дүнд шинжилгээ хийх

1. **Тайлбарлах статистик (Descriptive statistic)** - Тайлбарлах (Хувьсагч бүрийн дундаж утга, хамгийн их, бага утга, стандарт хазайлт, давтамж, стандарт алдаа, нийт тоо, хоосон утгуудын тоо, ... зэргийг тодорхойлж шинжилгээ хийхэд бэлтгэх)
2. **Дүгнэх статистик (Inferential statistic)** - Дүгнэх (Хүчин зүйлийн шинжилгээ, найдвартай байдлын шинжилгээ, хэвийн тархалтын шинжилгээ, ялгаатай байдлын шинжилгээ, хамаарлын шинжилгээ, регрессийн шинжилгээ, ...)
3. **Дүгнэлт гаргах** (Шаардлагагүй асуулгыг устгах, сайжруулах, холбоо хамаарлуудыг тогтоох, хэрхэн хамаарч байгаа эсэх, зорилгоо хангасан эсэх, ...)

ОНЛАЙН СУДАЛГААНЫ АШИГ ТУС

- Богино хугацаанд багш, суралцагч, эцэг эхийн сэтгэл ханамжийн талаарх мэдээлэлтэй болно.
- Таны судалгаа маш их ажлыг хөнгөвчлөн, цаг хугацааг хэмнэж хэд хэдэн хувилбараар мэдээлэл авах боломжтой болно.
- Интернэт судалгаа хямд зардлаар бий болох ба цаас хэмнэж эргэж нэгтгэх шивэх гэх мэт зардал бага шаарддаг.
- Энэ нь янз бүрийн материал, илтгэл (видео, карт, фото) харуулах боломж олгоно.

Хялбар хэл: Асуулга нь энгийн, тодорхой, ойлгомжтой байх ёстой. Ойлгоход төвөгтэй өгүүлбэр, хэт дэлгэрэнгүй урт өгүүлбэр хэрэглэхгүй байх. Энэ нь хэн нэг нь хэд хэдэн удаа дахин дахин уншихад хүргэх ба энэ нь асуулгын утгыг алдагдуулж болох магадлалтай учир сэтгэл ханамжийн үнэлгээг алдаатай болоход хүрнэ. Асуултуудаа энгийн олон сонголттой, эсвэл хариулт нь “тийм”, “үгүй” гэсэн хялбар хариулттай гэх мэтээр хувилбар сонгож болно. Таны судалгаанд авч буй асуултууд хэт их буюу 20- оос их байвал хариулахад төвөгтэй байна, хамгийн оновчтой асуулгын тоо 10 байвал зохимжтой гэж үзнэ. Таны асуух асуултууд шууд чиглэсэн, хөтөлсөн асуултууд байж болохгүй. Хариулагч өөрөө энэ нь судалгааны зорилго юу байсан, ямар асуултуудаар тодруулан асууж байна гэх зэргийг ойлгох боломж бүрдүүлэх нь зохимжтой байна.

Судалгааны хэмжээсжүүлэх арга, аргачлал

а. Хэмжээсжүүлэх арга, аргачлал – Өөр өөр хариулттай асуулгын хариулт, оноог хэмжээсжүүлэх

Асуулгын өгөгдлийн хэмжээсжүүлэлт, өөр өөр зэргийг харгалзан статистик арга аргачлал ашиглан нарийн хэмжээсжүүлэлт хийх.

Өгөгдлийн шинжилгээ – Судалгааны өгөгдөлд анализ хийх тохиромжтой арга, аргачлал

Өгөгдөлтэй холбоотой статистик шинжилгээ хийх, шинжилгээний нарийн арга аргачлал ашигладаг, шинжилгээ хийх аргуудын тайлбарыг тайлбарлаж, баримтжуулдаг.

Арга аргачлал

Судалгааны асуулгад ихэвчлэн хаалттай асуулгуудыг (сонгох/олон сонголтод, /үнэн-худал, тийм-үгүй, ... гэх мэт) ашигладаг. Хаалттай асуулгад (1/0 сонголттой), нэрлэсэн, дараалсан төрлийн хувьсагчид ихэвчлэн хэрэглэгддэг бөгөөд тэдгээрийн арга аргачлалын талаар орууллаа. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга бол Лайкартын шкал арга юм.

Лайкартын шкал хэмжигдэхүүн нь асуулга, судалгаанд ихэвчлэн хэрэглэдэг психометрийн хэмжүүр юм. Энэхүү аргачлалыг Ренсис Лайкер (Америк-сэтгэл судлаач) үүсгэсэн бөгөөд түүний нэрээр нэрлэжээ. Хүснэгтэд Лайкартын шкал нь хариултын төрлүүдийг харуулж байна.

	Асуултын төрөл	Асуултын хувилбар	Хариултын хувилбар
1	Хүлээн зөвшөөрөх	Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчийн шууд оролцоог хүлээн зөвшөөрч байна уу?	1. Эрс татгалзах 2. Татгалзах 3. Бага зэрэг татгалзах 4. Төвийг сахих 5. Бага зэрэг хүлээн зөвшөөрөх 6. Хүлээн зөвшөөрөх 7. Бүрэн хүлээн зөвшөөрөх 7 үзүүлэлтээр хэмжээсжүүлэлт хийх ба 1 бол 0 хувь, 4 бол 50 хувь, 7 бол 100 хувь гэж үзэж болох ба 7 түвшин нь 5 ба 3 түвшинд шилжих боломжтой.
2	Тохиромжтой байдал	Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчид шууд оролцох нь тохиромжтой юу?	
3	Ач холбогдолтой байдал	Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчид шууд оролцох нь чухал эсэх?	
4	Санал нийлэх	Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчид шууд оролцож байгааг та юу гэж бодож байна?	
5	Үйл ажиллагаа, бодит байдлыг дүгнэх	Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчид шууд оролцдог.	
6	Өөрийн мэдрэгдэх, санагдах, тунгаан бодох	Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчид шууд оролцоно гэдэгт итгэдэг.	
7	Итгэл үнэмшил	Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчид шууд оролцох нь тэргүүлэх асуудал мөн үү?	
	Тэргүүлэх чиглэл, асуудал, дараалал	Хичээлээс гадуурх үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагчид шууд оролцож байгаа нь...	

Өгөгдөл цуглуулах

Судалгааны өгөгдөл цуглуулах та бүхний мэддэг, хэрэглэдэг олон боломжууд байна. Google form дээр асуулга авах болон, Office-form, цаасан хэлбэрээр авч шивж оруулах, OMR технологи ашиглан /уншигч машин, аппликейшн/ мэдээлэл өгөгдөл цуглуулах боломжтой. Ж нь: цаасан, OMR -Optical mark reading технологи, гар утасны аппликейшн, компьютерт суурилсан онлайн, компьютерт суурилсан онлайн биш гэх аргачлалуудыг өргөн ашигладаг.

Жишээ 1: Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаа

Уг судалгааны үр дүнд тулгуурлан бид үйл ажиллагаандаа шинжилгээ хийж, өөрчлөлт, шинэчлэлт хийн ажиллах тул та бүхэн дараах асуултуудад үнэн зөвөөр хариулна уу?

- Таны хүүхэд ХГҮА -нд өөрийн саналаар хамрагдаж байгаа юу?
а/ Тийм өөрөө сонгож б/ Үгүй миний зөвлөснөөр
- Таны хүүхдэд ямар өөрчлөлт ороосой гэж Та хүсэж байна вэ?
а/ Бие дааж суралцах чадвартай болох б/ Бүтээлч сэтгэлгээтэй болгох
в/ Ямар нэг зүйлийг тууштай хийдэг болгох г/ Нийтэч болгох
- Та хүүхдийнхээ сургалтын үйл ажиллагааг үнэлнэ үү?
а/ Маш сайн б/ Хангалттай в/ Дундаж г/Хангалтгүй д/ Маш Хангалтгүй
- Таны бодлоор хүүхдийн тань сонирхол нэмэгдэж сайжирч байна уу
1/ Маш их сайжирсан 2/ Сайжирсан 3/ Хэвийн урьдынх шигээ 4/ Сайжраагүй
- Энэ үйл ажиллагаанд (сургалтад) хүүхдээ хамаруулахад хүндрэл бэрхшээлүүд юу байна вэ?
а/ Орж байгаа хэрэглэгдэхүүн үнэ ихтэй б/ Ном гарын авлага ховор
в/ Маш их ачаалалтай г/ Мэдэхгүй
- Сургалт болон үйл ажиллагааны жилийн тайлагналтай холбоотой мэдээллийг ямар хэлбэрээр авбал илүү үр дүнтэй гэж Та үзэж байна вэ?
а/ Цахимаар б/ Танхимын тайлангаар

Хавсралт 2. ХГСА -ын төлөвлөлтийн загвар жишээнүүд

Сургууль ХГСА-ын төлөвлөгөөтэй байна. Энэхүү төлөвлөгөө нь сургуулийн жилийн төлөвлөгөөний тодорхой хэсэг байна. Төлөвлөгөөг АУБ, судалгаа менежментийн баг (Захирал, Сургалтын менежер, Нийгмийн ажилтан, Дотуур байрны багш, Эмч г.м)-тай хамтран ажиллаж сурагчдын хэрэгцээ сонирхол, нөхцөл байдал, багш ажилтан, эцэг эхчүүд, олон нийтийн байгууллага, иргэдийн саналыг нэгтгэн харилцан уялдаатай боловсрууна.

1. Арга зүй

Төлөвлөлтийг сургуулийн, ангийн, секц дугуйлангийн, сурагчдын зөвлөлийн, сайн дурын бүлгүүдийн, эцэг эхийн зөвлөлийн гэх мэт түвшинд хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх зорилтуудын хүрээнд боловсруулж болно.

ХГСА-н төлөвлөлт гаргахдаа зорилтуудыг интеграцчилах байдлаар хийж болно. Жишээ нь: Эрүүл аюулгүй амьдрах арга ухаанд сургах, Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх гэсэн 2 зорилтыг, Суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих, Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих гэсэн 2 зорилтуудыг нэгтгэх байдлаар авч үзэж болно.

Төлөвлөлтийн жишээ 1:

1. Сургуулийн төлөвлөлт

..... аймаг, дүүргийн сум сургуулийн хичээлээс гадуурх сургалтын ажлын төлөвлөгөө

<p>Монгол Улсын боловсролын зорилго, бодлого, чиглэл</p> <p>МУ-ын боловсролын тухай хууль, бодлогын баримт бичгүүд Сургалтын төлөвлөгөө Сургалтын хөтөлбөр</p>	<p>Сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилийн зорилго</p> <ul style="list-style-type: none"> • Ёс суртахуунтай хүүхэд • Бүтээлч санаачилгатай, сурах арга барилтай хүүхэд • Эрүүл чийрэг бие бялдартай хүүхэд г.м
<p>ХГСА-ын зорилго:</p> <p>Сурагч өөртөө итгэлтэй, бие бялдар, оюун сэтгэхүй, ёс суртахууны төлөвшилтэй, нийгмийн олон талт харилцаанд зохицон, бусдыг манлайлж, хамт олны хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах, шийдвэр гаргах чадвартай, бүтээлч, санаачилгатай хувь хүн болон хөгжихөд дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Сургууль орон нутгийн нөхцөл байдал:</p> <p>Сурагчийн тоо – Бүлгийн тоо – Багш ажилтны тоо – Эцэг эхийн клуб, сайн дурын бүлгийн тоо –</p>
<p>ХГСА-ын зорилт:</p> <ul style="list-style-type: none"> • Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшлийг дэмжих • Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах • Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх • Бие бялдар, авьяас чадварыг хөгжүүлэх • Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих • Суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих • Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих • Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх 	

Жишээ 2: Зорилтод тулгуурласан төлөвлөлт

Хугацаа (сараар)	Чиглэл							
	Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшлийг дэмжих	Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах	Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх	Бие бялдар, авьяас чадварыг хөгжүүлэх	Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих	Суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих	Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих	Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх
9								
10								
11								
12								
1								
2								
3								
4								
5								

Жишээ 3. ХГСА-н жилийн календарчилсан төлөвлөлт

№	Үйл ажиллагаа	Сараар										Хариуцах эзэн	
		9	10	11	12	1	2	3	4	5	6		
Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшлийг дэмжих													
1	Эцэг эхийн уулзалт, сургалт												
2	Сурагчдын дунд хүмүүжил төлөвшил рүү чиглэсэн сургалт, нэрэмжит өдрүүд аян зохион байгуулах · Цахим хэрэглээ, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх · Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх												
Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах													
1	Эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийх (эрсдэлтэй болон зорилтот бүлгийн)												Сургуулийн захиргаа, Нийгмийн ажилтан, сургуулийн эмч нь харъяа дүүрэг хорооны эрүүл мэндийн төв, Өрхийн эмнэлэгтэй хамтрах
2	Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх · Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх · Халдварт өвчин бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх · Хорт зуршилд автахгүй байх, мэдээлэлтэй байх												

Бие бялдар, авьяас чадварыг хөгжүүлэх											
1	Спортын дугуйлангийн үйл ажиллагааг зохион байгуулах · Сагсан бөмбөг · Хөл бөмбөг · Гар бөмбөг · Бөхийн төрлүүд · Хөнгөн атлетик · Шатар, даам гэх мэт оюуны спортын төрлүүд										
	Соёл, урлагийн дугуйлан · Хөгжмийн төрлүүд · Бүжгийн төрлүүд · Дууны төрлүүд г.м										
Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих;											
1											
2											
3											

Жишээ 4: Ангийн жилийн төлөвлөгөө

Анги хамт олон хурлаараа ярилцан хэлэлцэж, асуудлыг илрүүлж хэрхэн шийдвэрлэх сайжруулах боломжийг тодорхойлж зорилгоо дэвшүүлнэ. Хамт олны зорилго хүрэх үр дүнг товч ойлгомжтой үгээр тодорхойлогдсон байх бөгөөд сурагч, эцэг эх, асран хамгаалагч дэмжсэн, хэрэгжүүлэхийг хүссэн үр дүнг хүлээсэн байна.

Ангийн төлөвлөгөө нь анги хамт олны төлөвлөлт хөгжлийг улам сайжруулах, зорилгоо бодит үр дүн болгон хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтран боловсруулсан баримт бичиг юм. Сургууль зорилгодоо хүрэхэд анги бүрийн зорилго, жилийн төлөвлөгөө чухал үүрэгтэй юм. Иймд хүүхэд нэг бүрийн хүсэл хэрэгцээг тусгасан, сургуулийн зорилгоо дэмжсэн байх ёстой.

Ангийн хичээлээс гадуурх сургалтын ажлын төлөвлөлт

Чиглэл	Улирал			
	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Гэр бүлийн хүрээнд олгох хүмүүжил, төлөвшлийг дэмжих				
Эрүүл, аюулгүй амьдрах арга ухаанд сургах;				
Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх;				
Бие бялдар, авьяас чадварыг хөгжүүлэх;				
Мэдээллийн технологийн зохистой хэрэглээг дэмжих;				
Суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих				
Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих;				
Байгаль, экологийн хүмүүжлийг төлөвшүүлэх;				

Жишээ 5: Удирдамж

Төсөлт хичээл 1. (дугуйлан, секцийн нэр)

Төслийн зорилго: Тухайн секц, дугуйлангийн зорилгыг тодорхойлж бичих

Хугацаа: Хичээллэх нийт хугацааг бичнэ. Жич: 2022 оны 10 сараас 2023 оны 05 сар хүртэл г.м

Хамрах хүрээ: Секц дугуйланд хамрах сурагчдыг анги, болон насаар нь ангилж болно. Жич: 7-9 дүгээр анги, 12-14 нас г.м ...

Хичээллэх өдөр цаг: Даваа гараг бүрийн 16:00-17:00 цагт тоот өрөө, танхим г.м

Тавигдах шаардлага: секц дугуйланд хамрагдах суралцагчдад тавих ерөнхий шаардлагыг бичнэ. /секц, дугуйлан тус бүрийн онцлогт нийцсэн байх/

Сурагчдад өгөх чадварууд: Суралцагчдад олгох ерөнхий болон тусгай ур чадваруудыг бичнэ.

Хүлээгдэж буй үр дүн: Суралцагчдын эзэмшсэн мэдлэг чадварын үр дүнд бий болох бүтээгдэхүүн, ур чадварын үзүүлбэр г.м

Зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагаагаар ХГСА-н төлөвлөлтийг хийх нь зохимжтой. ХГСА-н төлөвлөлт гаргахдаа зорилтуудыг интеграцчилах байдлаар хийж болно. Жишээ нь: Эрүүл аюулгүй амьдрах арга ухаанд сургах, Болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ур чадвар эзэмшүүлэх гэсэн 2 зорилтыг, Суралцагчдын нийгэм, олон нийтийн үйл ажиллагааг дэмжих, Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих гэсэн 2 зорилтуудыг нэгтгэх байдлаар авч үзэж болно.

Үйл ажиллагааны төлөвлөгөө /хийгдэх ажлуудыг өдөр тус бүрээр нь дэлгэрэнгүй бичих/

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1			
2			
3			

Төсөл хариуцсан багш:

Зөвлөмж боловсруулсан:

Н.Болормаа	БМДИ арга зүйч
Ц.Лхагвасүрэн	Боловсролын хүрээлэн ЭША
С.Отгонтуяа	Боловсролын хүрээлэн ЭША
Б.Энхтулга	БМДИ арга зүйч
Х.Энхжаргал	Боловсролын хүрээлэн ЭША

Формат 60x84/8

Офсет хэвлэл. Офсет хэдлэлийн цаас. 80гр/м²

Хэвлэлийн хуудас 7 х.х